МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАН

2017 VI сар

№9

МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАН

Дугаар №9

Улаанбаатар хот
2017 оны 6 дугаар сар

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ 7

ТОЙМ 9

1. МАКРО-САНХҮҮГИЙН ОРЧИН 15

1.1 Дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээлийн тойм 15

- Дэлхийн эдийн засаг 15
- Дэлхийн санхүүгийн зах зээл 17
- Дэлхийн түүхий эдийн зах зээл 19

1.2 Монгол Улсын макро эдийн засгийн тойм 21

- Монгол Улсын эдийн засгийн төлөв байдал 21
- Гадаад сектор 24
- Бодит сектор 29
- Мөнгө санхүүгийн сектор 33
- Улсын төсөв 36

2. САНХҮҮГИЙН САЛБАР, ТҮҮНИЙ ДАРХЛАА 41

2.1 Банкны салбарын төлөв байдал 41

- Банкны салбар 41
- Макро зохистой бодлого, түүний хэрэгжилт 48

2.2 Банкны бус санхүүгийн салбарын төлөв байдал 49

- Банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо 49
- Хөрөнгийн зах зээл 54
- Даатгалын салбар 57
- Хөдөө аж ахуйн бирж ба түүхий эдийн арилжаа 60

3. САНХҮҮГИЙН САЛБАРЫН ДЭД БҮТЭЦ, ТҮҮНИЙ ИНСТИТУЦИ 61

3.1 Хууль, эрх зүйн орчинд гарсан өөрчлөлт 61

3.2 Төлбөр тооцооны систем 63

3.3 Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагаа 66

ДҮРСЛЭЛҮҮД

Дүрслэл Т.1	Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын зураглал	13
Дүрслэл 1.1	Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл	15
Дүрслэл 1.2	АНУ-ын эдийн засгийн зарим гол үзүүлэлтүүд	16
Дүрслэл 1.3	Евро бүсийн ажилгүйдлийн түвшин	16
Дүрслэл 1.4	БНХАУ-ын нүүрсний импорт	16
Дүрслэл 1.5	Зарим хөрөнгийн захын индекс	17
Дүрслэл 1.6	Хөгжингүй улс орнуудын бодлогын хүү	18
Дүрслэл 1.7	Зарим хөгжингүй орнуудын Засгийн газрын 10 жилийн хугацаатай бондын өгөөж	18
Дүрслэл 1.8	Банк хоорондын захын хүү, LIBOR	18
Дүрслэл 1.9	Голлох валютуудын ам.доллартай харьцах ханш	18
Дүрслэл 1.10	Зарим түүхий эдийн үнэ	19
Дүрслэл 1.11	БНХАУ-ын нүүрсний импорт (сая тонн)	20
Дүрслэл 1.12	Төлбөрийн тэнцлийн алдагдал	21
Дүрслэл 1.13	Импортын жилийн өсөлт	21
Дүрслэл 1.14	Гадаадын шууд хөрөнгө оруулалт	22
Дүрслэл 1.15	Монгол Улсын улирлын ДНБ-ий жилийн өсөлт	22
Дүрслэл 1.16	Гадаад, дотоод цэвэр актив болон М2 мөнгө	24
Дүрслэл 1.17	Зээлийн чанар (салбараар, валютын төрлөөр)	24
Дүрслэл 1.18	Инфляцийн задаргаа	24
Дүрслэл 1.19	Төлбөрийн тэнцлийн гүйцэтгэл	25
Дүрслэл 1.20	Урсгал ба хөрөнгийн дансны тэнцэл	25
Дүрслэл 1.21	Урсгал тэнцлийн санхүүжилт	25
Дүрслэл 1.22	Санхүүгийн дансны бүтэц	26
Дүрслэл 1.23	Гадаад худалдааны нөхцөлийн индекс	26
Дүрслэл 1.24	Нийт экспорт	26
Дүрслэл 1.25	Нийт импорт	27
Дүрслэл 1.26	Гадаад валютын ханш	27
Дүрслэл 1.27	Гадаад валютын албан нөөц	28
Дүрслэл 1.28	Эдийн засгийн өсөлтийн задаргаа	30
Дүрслэл 1.29	Санхүү, даатгалын үйл ажиллагааны өсөлт, эдийн засагт эзлэх хувь	30
Дүрслэл 1.30	Бодит ДНБ, нийт зээлийн өсөлт, нийт хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь	30
Дүрслэл 1.31	Уул уурхайн салбарын үйлдвэрлэл, зээлийн өсөлт, зээлийн чанар	31
Дүрслэл 1.32	Боловсруулах салбарын үйлдвэрлэл, зээлийн өсөлт, зээлийн чанар	31
Дүрслэл 1.33	Барилгын салбарын үйлдвэрлэл, зээлийн өсөлт, зээлийн чанар	31
Дүрслэл 1.34	Үл хөдлөх хөрөнгийн үйлчилгээний салбарын үйлдвэрлэл, зээлийн өсөлт, зээлийн чанар	32
Дүрслэл 1.35	Худалдааны салбарын үйлдвэрлэл, зээлийн өсөлт, зээлийн чанар	32
Дүрслэл 1.36	Бусад салбарын үйлдвэрлэл, зээлийн өсөлт, зээлийн чанар	32
Дүрслэл 1.37	Өрхийн хэрэглээ, нийт хэрэглээний зээл , хэрэглээний импортын өсөлт	32
Дүрслэл 1.38	М2 мөнгөний бүтэц	33
Дүрслэл 1.39	М2 мөнгөний жилийн өсөлтийн задаргаа	33
Дүрслэл 1.40	Мөнгөний үзүүлэлтүүдийн ерөнхий бүтэц ба хандлага	34
Дүрслэл 1.41	Мөнгөний нийлүүлэлт болон мөнгөний үржүүлэгч	34
Дүрслэл 1.42	Банкуудын хадгаламж болон зээлийн хүү	34
Дүрслэл 1.43	Банк хоорондын захын хүү	35
Дүрслэл 1.44	Банк хоорондын захын хүүний хэлбэлзэх интервал	35
Дүрслэл 1.45	Нэгдсэн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн жилийн өөрчлөлт	38
Дүрслэл 1.46	Нэгдсэн төсвийн тэнцлийн гүйцэтгэл	38
Дүрслэл 1.47	Засгийн газрын богино ба урт хугацаат бондын арилжаа	39
Дүрслэл 1.48	Засгийн газрын бонд ба зээл	39

Дүрслэл 2.1	Банкны салбарын активын бүтэц	41
Дүрслэл 2.2	Банкны салбарын пассивын бүтэц	41
Дүрслэл 2.3	Банкны салбарын актив, пассивт гарсан өөрчлөлт	42
Дүрслэл 2.4	Банкны салбарын эх үүсвэрийн жилийн өсөлт	42
Дүрслэл 2.5	Банкны салбарын актив, зээлийн жилийн өсөлт	43
Дүрслэл 2.6	Олгосон зээлийн жилийн өсөлт	43
Дүрслэл 2.7	Салбаруудын зээлийн төвлөрөл	43
Дүрслэл 2.8	Зээлийн чанарын үзүүлэлт, салбараар	44
Дүрслэл 2.9	Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн өсөлт	44
Дүрслэл 2.10	Чанаргүй зээлийн харьцаа, валютын төрлөөр	44
Дүрслэл 2.11	Өөрийн хөрөнгийн үзүүлэлтүүд	45
Дүрслэл 2.12	Банкны салбарын ашигт ажиллагаа	45
Дүрслэл 2.13	Банкны салбарын төлбөр түргэн гүйцэтгэх чадвар	45
Дүрслэл 2.14	Хөрвөх чадварын үзүүлэлтүүд	46
Дүрслэл 2.15	Өрхийн бодит орлогын өсөлт	46
Дүрслэл 2.16	Өрхийн орлого, зарлагын харьцаа	46
Дүрслэл 2.17	Өрхийн өрийн дарамт	47
Дүрслэл 2.18	Өрхийн өр, орлогын харьцаа	47
Дүрслэл 2.19	Хувийн салбарын өрийн дарамт	47
Дүрслэл 2.20	Орон сууцны үнэ, ипотекийн зээлдэгчдийн тооны өсөлт	48
Дүрслэл 2.21	Бүртгэлтэй банк бус санхүүгийн байгууллагын тоо	49
Дүрслэл 2.22	Банк бус санхүүгийн байгууллагын нийт хөрөнгийн бүтэц	50
Дүрслэл 2.23	Банк бус санхүүгийн байгууллагын нийт зээл, зээлийн чанар	50
Дүрслэл 2.24	Банк ба ББСБ-ын зээлийн сарын дундаж хүү	51
Дүрслэл 2.25	Хадгаламж, зээлийн хоршоо болон гишүүдийн тоо	52
Дүрслэл 2.26	Хадгаламж, зээлийн хоршоодын нийт зээл, зээлийн чанар	53
Дүрслэл 2.27	Хадгаламж, зээлийн хоршоодын өр төлбөр ба өөрийн хөрөнгө	53
Дүрслэл 2.28	ТОП-20 индекс болон зах зээлийн үнэлгээ	54
Дүрслэл 2.29	Хөрвөх чадвар, хувьцааны арилжааны үнийн дүн	55
Дүрслэл 2.30	Бүртгэлтэй хувьцаат компанийн тоо, тэдгээрийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилт	56
Дүрслэл 2.31	Арилжааны төлбөр тооцоо	56
Дүрслэл 2.32	Даатгалын компаниудын өр төлбөр, эзэмшигчдийн өмч	58
Дүрслэл 2.33	Батлан даалт гаргасан байдал болон санхүүжилтийн эх үүсвэр	60
Дүрслэл 3.1	Их дүнтэй төлбөр тооцооны системийн нэг өдрийн дундаж үзүүлэлт	63
Дүрслэл 3.2	Бага дүнтэй төлбөр тооцооны системийн нэг өдрийн дундаж үзүүлэлт	63
Дүрслэл 3.3	Картын гүйлгээний нэг өдрийн дундаж үзүүлэлт	64

ХҮСНЭГТҮҮД

Хүснэгт Т.1	МУ-ын санхүүгийн тогтвортой байдлын зураглалын гол ба дэд үзүүлэлтүүд	13
Хүснэгт 1.1	Төсвийн орлогын гүйцэтгэл	23
Хүснэгт 1.2	Урсгал тэнцлийн алдагдлын санхүүжилт	26
Хүснэгт 1.3	Монгол Улсын нийт гадаад өр	28
Хүснэгт 1.4	Монгол Улсын зээлжих зэрэглэлийн өөрчлөлт	29
Хүснэгт 1.5	Бодит салбарын үндсэн үзүүлэлтүүд	30
Хүснэгт 1.6	Бодит ДНБ-ий өсөлт (салбаруудаар)	30
Хүснэгт 1.7	Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөө ба урьдчилсан гүйцэтгэл	36
Хүснэгт 1.8	Нэгдсэн төсвийн орлогын урьдчилсан гүйцэтгэл	36
Хүснэгт 1.9	Нэгдсэн төсвийн зарлагын төлөвлөгөө ба гүйцэтгэл	37
Хүснэгт 1.10	Засгийн газрын өрийн бүтэц, өрийн хэрэгслээр	39
Хүснэгт 1.11	Гадаад өрийн үлдэгдэл валютын бүтцээр	40
Хүснэгт 2.1	Банк бус санхүүгийн байгууллагын голлох статистик үзүүлэлтүүд	49
Хүснэгт 2.2	Банк бус санхүүгийн байгууллагын эрхэлж буй үйл ажиллагааны төрөл	50

Хүснэгт 2.3	Банк бус санхүүгийн байгууллагын санхүүгийн голлох үзүүлэлтүүд	51
Хүснэгт 2.4	Орлого, зарлага, ашигт ажиллагаа	51
Хүснэгт 2.5	ББСБ-уудын зохистой харьцааны үзүүлэлтүүдийг хангасан байдал	52
Хүснэгт 2.6	Хадгаламж, зээлийн хоршоодын голлох статистик үзүүлэлтүүд	53
Хүснэгт 2.7	Даатгалын салбарын тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн тоо	57
Хүснэгт 2.8	Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ	57
Хүснэгт 2.9	Даатгалын компаниудын хөрөнгө балансын зүйлээр	57
Хүснэгт 2.10	Даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөр, бүтээгдэхүүнээр	58
Хүснэгт 2.11	Хөдөө аж ахуйн бирж дээрх түүхий эдийн арилжааны үнийн дүн	60

ШИГТГЭЭНҮҮД

Шигтгээ 1:	Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын зураглал	12
Шигтгээ 2:	Засгийн газрын гадаад өрийн эрсдэлүүд	39

ӨМНӨХ ҮГ

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс “Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын тайлан”-г хагас жил тутам боловсруулан олон нийтэд танилцуулдаг бөгөөд 9 дэх дугаарыг Та бүхэнд өргөн барьж байна.

Тайлангийн 8 дахь дугаарыг олон нийтэд хүргэснээс хойш буюу 2016 оны 12 дугаар сараас хойш олон улсын эдийн засаг, санхүүгийн зах зээлд төдийгүй Монгол Улсын эдийн засагт томоохон үйл явдлууд тохиолоо. Энэ хугацаанд АНУ-ын Холбооны Нөөцийн Банк бодлогын хүүгээ хоёр ч удаа нэмэгдүүлсэн, Европын төв банк, Япон Улсын төв банкууд бодлогын хүүгээ урт хугацаанд бага түвшинд хадгалахаа мэдэгдсэн, ОПЕК-ийн гишүүн орнуудын 5 дугаар сард болсон ээлжит хуралдаанаар газрын тосны гарцын хязгаарлалтыг дахин 9 сараар сунгахаар тохиролцсон зэрэг үйл явдлууд олон улсад өрнөсөн бол Монгол Улс ОУВС-тай хамтран “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг ирэх гурван жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр боллоо.

ОУВС-гийн захирлуудын зөвлөл 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдөр хуралдан Монгол Улсын эдийн засгийг сэргээн тогтворжуулах зорилгоор “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд тус хөтөлбөрийн хүрээнд нийт 5.5 тэрбум ам.долларын[1] санхүүжилтийг олон улсын санхүүгийн байгууллагууд, донор улсуудаас олгохоор шийдвэрлэсэн юм. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд цаашид төсвийн нэгдсэн байдлыг хадгалан төсвийн алдагдлыг бууруулах, дотоодын санхүүгийн зах зээлд учирч буй дарамтыг бууруулах, гадаад төлбөрийн нөхцөлийг сайжруулах, өрийн тогтвортой байдлыг хангах, банкны салбарын найдвартай байдлыг бэхжүүлэх зэрэг бодлогын зорилтуудыг тавьж байна.

ОУВС-гийн хөтөлбөрийг Монгол Улсад хэрэгжүүлэхээр болсон нь зах зээлд оролцогчдын итгэлийг сэргээсэн үйл явдал боллоо. Үүний нэг жишээ нь тус хөтөлбөр хэрэгжих хүлээлт, Монгол Улсын засгийн газраас яаралтай авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд Засгийн газрын баталгаатай Хөгжлийн банкны 2017 оны 3 дугаар сарын 21-ний өдөр төлөгдөх хуваарьтай 580 сая ам.долларын евро бондыг Засгийн газраас шинээр үнэт цаас гаргаж, дахин санхүүжүүлэх ажлыг амжилттай гүйцэтгэсэн явдал юм. Энэ нь төлбөрийн чадваргүйд хүрэх эрсдэлийг арилгаж, зээлжих зэрэглэл буурах эрсдэлээс бүрэн сэргийлсэн чухал ач холбогдолтой арга хэмжээ байв.

Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлыг хангахад богино болон дунд хугацаанд ОУВС-гийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж, хувийн хэвшлийн өсөлтөд суурилсан эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгох, хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаанд нийгмийн эмзэг давхаргын баталгааг хангах, өрийн дарамтыг үе шаттайгаар бууруулах, эдийн засгийн уул уурхайн салбараас хэт хамааралтай байдлыг бууруулах, банкны салбарын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх зэрэг бүтцийн бодлогуудыг амжилттай хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч байгууллагуудаас богино хугацаанд Монгол Улсын гадаад төлбөрийн чадвар харьцангуй дээрдэж буй хэдий ч цаашид төсвийн алдагдал, өрийн дарамтыг бууруулахад тодорхой эрсдэлүүд байсаар байгааг онцолж байна.

Иймд төсөв, гадаад сектор, банкны салбарын эрсдэлийг цаашид бууруулахад

[1] *Уг дүн нь Хятадын Ардын банкны своп хэлцлийг оруулсан дүн бөгөөд үлдсэн санхүүжилтийг ОУВС, АХБ, Дэлхийн банк, Япон, БНСУ-ын Засгийн газраас олгохоор тохиролцсон.*

ОУВС-гийн хөтөлбөрт туссан арга хэмжээг амжилттай хэрэгжүүлэх, салбарын эрсдэлийг бууруулахад чиглэсэн төсөв, мөнгөний бодлогын харилцан уялдааг хангах, мөчлөг сөрсөн макро зохистой бодлого хэрэгжүүлэх нь чухал ач холбогдолтой болж байна.

Санхүүгийн салбар нь эдийн засагт хөрөнгийн хуваарилалтыг хийх гол суваг төдийгүй итгэлцэл дээр оршин тогтнодог эмзэг бүтэц тул түүний тогтвортой байдал нь санхүүгийн зах зээлд оролцогчдын үнэн зөв мэдээлэлд үндэслэсэн бодитой хүлээлт, үйлдлээс ихээхэн хамааралдаг. Тиймээс Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл нь Монгол Улсын санхүүгийн тогтолцоо, түүний тогтвортой байдлыг хангах үндсэн чиг үүргийнхээ хүрээнд санхүү, эдийн засгийн бодлогын асуудлыг тогтмол авч хэлэлцэхийн зэрэгцээ, олон нийтэд хүргэж буй мэдээллийн чанарыг сайжруулах, санхүүгийн талаарх иргэдийн суурь мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор “Санхүүгийн тогтвортой байдлын тайлан”-г тогтмол боловсруулан нийтэлсээр байна.

Санхүүгийн тогтвортой байдал нь системийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн макро зохистой арга хэмжээнээс гадна уламжлалт макро эдийн засгийн бодлого, санхүүгийн салбарын хяналт шалгалт, зохицуулалт, институцийн оновчтой тогтолцоо, тэдгээрийн харилцан уялдаат байдал зэргээс хамаардаг өргөн цар хүрээтэй ойлголт юм.

Иймд бид “Санхүүгийн тогтвортой байдлын тайлан”-г боловсруулахдаа албан ёсны эх сурвалж, статистикт үндэслэсэн нийт макро эдийн засаг, санхүүгийн салбарын нөхцөл байдал, хандлагын талаар харилцан уялдаа бүхий мэдээлэл өгөх зарчмыг баримталж байна.

Энэхүү тайлангийн агуулгыг цаашид сайжруулахад уншигч таны оролцоо, хувь нэмэр ихээхэн үнэ цэнтэй тул энэхүү тайлантай холбогдох аливаа саналаа Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ажлын албанд хаяглан, fsc@mongolbank.mn цахим шуудангаар ирүүлж болно. Таны саналыг хүлээж авахдаа бид үргэлж таатай байх болно.

ТОЙМ

АНУ-ын эдийн засгийн жилийн өсөлт хүлээлтээс доогуур гарсан ч Хятад, Евро бүсийн эдийн засгийн идэвх сайжирсан тул шинжээчид дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөллийг өмнөх төсөөллөөс 0.1 нэгж хувиар нэмэгдүүлж, 2017 онд 3.5 хувиар өснө гэж төсөөлжээ.

Хятадын дэд бүтцийн хөрөнгө оруулалт нэмэгдэж, хэрэглээ өсч эдийн засгийн өсөлтийг дэмжсэн бол Евро бүсийн гадаад болон дотоод эрэлт мөнгөний уламжлалт бус тэлэх бодлогын нөлөөгөөр өсч, хөдөлмөрийн зах зээл сэргэж эдийн засгийн өсөлтийг дэмжлээ. Харин АНУ-ын авто машины борлуулалт болон дулааны хэрэглээ буурснаас хэрэглээ буурч, эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлэв.

АНУ-ын Холбооны Нөөцийн Банк 2017 оны 2 дугаар сард ажил эрхлэлт болон инфляци хүлээгдэж буй түвшинд хадгалагдсаар байвал 3 дугаар сард бодлогын хүүгээ дахин нэмнэ гэж мэдэгдсэний дагуу 3 дугаар сарын 15-ны өдөр 0.25 нэгж хувиар нэмэгдүүлэв. ХНБ-аас 2017 оны 6 дугаар сарын 14-ний өдөр мэдээлснээр АНУ-ын инфляцийн түвшин зорилтот 2 хувийн хүлээлтээс доогуур, ажилгүйдлийн түвшин буурч байгаа тул бодлогын хүүгээ 2017 оны 6 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дахин 0.25 хувиар нэмэх шийдвэрийг гаргаад байна. Ингэснээр бодлогын зорилтот хүү 1-1.25 хувьд хүрлээ.

Евро бүсийн эдийн засаг 2017 оны I улиралд 1.7 хувиар өслөө. Мөнгөний уламжлалт бус тэлэх бодлогын нөлөөгөөр гадаад болон дотоод эрэлт өсч, хөдөлмөрийн зах зээл сэргэж Евро бүсийн эдийн засгийн өсөлтийг дэмжив. Түүнчлэн 2017 оны 2 дугаар сард 55.4 байсан аж үйлдвэрийн салбарын идэвхжлийг илтгэх PMI индекс 5 дугаар сард 57.0 болж, 2011 оны 4 дүгээр сараас хойшхи дээд түвшиндээ хүрч өссөн байна. Ийнхүү Евро бүсийн аж үйлдвэрийн салбарын идэвхжил сайжирч, үйлдвэрлэлийн хэмжээ, ажлын байр нэмэгдэхээр байна.

Хятадын эдийн засаг 2017 оны I улиралд хүлээлтээс өндөр буюу 6.9 хувиар өсч, 2015 оны 9 дүгээр сараас хойшхи хамгийн өндөр түвшинд хүрлээ. Дэд бүтцийн хөрөнгө оруулалт нэмэгдэж, хэрэглээ өссөн нь эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлэв.

Дэлхийн зах зээл дээр зэсийн үнэ 2017 оны 2 дугаар сард дунджаар 5941 ам.доллар/тонн болж, 2015 оны 5 дугаар сараас хойшхи дээд цэгтээ хүрчээ. Уг өсөлтөд АНУ-ын шинэ ерөнхийлөгч дэд бүтцийн хөрөнгө оруулалтад 1 их наяд ам.доллар зарцуулахаа амалсан нь голлон нөлөөлсөн юм. Мөн Чили болон Перу дахь томоохон уурхайн ажилчид ажил хаялт зарласан, Индонезийн зэсийн уурхайн нийлүүлэлт зогссон зэргээс үүдэн 2017 оны эхний хагаст зэсийн үнэ дахин өсч, 6106 ам.доллар/тонн-д хүрсэн.

Дэлхийн болон БНХАУ-ын эдийн засгийн өсөлт удааширч байгаагаас шалтгаалан голлох эрдэс бүтээгдэхүүний эрэлт буурч, улмаар үнийн төлөв сайнгүй, АНУ-ын Холбооны Нөөцийн Банк мөнгөний хатуу бодлого баримтлах болсонтой уялдан хөрөнгийн урсгал хөгжиж буй орнуудад бус хөгжингүй орнуудыг чиглэж байгаа нь уул уурхайн олборлолт, экспортод суурилсан хөгжиж буй орнуудад томоохон сорилтыг бий болгож байна.

Монгол Улсын эдийн засгийн бодит өсөлт 2015 онд 2.4 хувь, 2016 онд 1.0 хувь, 2017 оны эхний улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 4.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлтийн дийлэнх хувийг тайлбарлаж байсан уул уурхайн салбарын өсөлт удааширч 2017 оны эхний улирлын байдлаар -1.8 хувьд хүрэв. Харин уул уурхайн бус салбар тайлант хугацаанд өмнөх оны мөн үеэс 6.0 хувиар өссөнөөр 2 улирал дараалан өссөн үзүүлэлттэй байна.

Монгол Улсын төлбөрийн тэнцэл 2017 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр 62.9 сая ам.долларын алдагдалтай гарч, алдагдал өмнөх оны мөн үеэс 167.8 сая ам.долларaар өссөн үзүүлэлттэй байна. Санхүүгийн дансны ашиг өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 82.2 хувь буюу 468.6 сая ам.долларaар буурчээ.

Төлбөрийн тэнцлийн урсгал ба хөрөнгийн данс 2017 оны эхний 5 сарын байдлаар 2.5 сая ам.долларын алдагдалтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 389.4 сая ам.долларaар буурсан эерэг үзүүлэлттэй байна. Ийнхүү урсгал ба хөрөнгийн тэнцлийн алдагдал буурахад барааны гадаад худалдааны тэнцэл 55.4 хувиар сайжирч, үйлчилгээний дансны алдагдал 11.6 хувиар буурсан, анхдагч орлогын дансны алдагдал 11.8 хувиар буурсан нь голлох нөлөө үзүүлжээ.

Санхүүгийн данс 2017 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр 101.3 сая ам.долларын ашигтай гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 468.6 сая ам.долларaар буурсан үзүүлэлт юм.

М2 мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт 2017 оны 5 дугаар сарын байдлаар 21.5 хувиар өсч 12.9 их наяд төгрөгт хүрлээ. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн 14.9 нэгж хувийг бусад хадгаламжийн өсөлт, 6.6 нэгж хувийг М1 мөнгөний өсөлт бүрдүүлж байна.

2017 оны 5 дугаар сарын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 2,666.6 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 3.1 хувиар буюу 80.3 тэрбум төгрөгөөр давж, өмнөх оны мөн үеийнхээс 27.9 хувиар буюу 581.5 тэрбум төгрөгөөр илүү байна. Харин төсвийн нийт зарлага дээрх хугацаанд 3,079.1 тэрбум төгрөг буюу 78.6 хувийн гүйцэтгэлтэй гарч, Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт тэнцэл 412.5 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Банкны салбарт 2017 оны 5 дугаар сарын байдлаар нийт 14 банк 1494 салбар нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Нийт харилцагчдын тоо 8.8 сая, зээлдэгчдийн тоо 903.8 мянгад хүрлээ[2].

Банкны салбарын нийт активын хэмжээ 2017 оны 5 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 3.5 их наяд төгрөгөөр өсч 25.7 их наяд төгрөгт хүрлээ. Нийт активын бүтцийг авч үзвэл 48.3 хувь нь зээл, 10.3 хувь нь банкны нөөц, 12.4 хувь нь Засгийн газрын үнэт цаас, 4.9 хувь нь Төв банкны үнэт цаас, үлдэх 24.1 хувь нь бусад хөрөнгө байна.

Харин 2017 оны 5 дугаар сарын байдлаар нийт пассивын жилийн өсөлт 14.2 хувь байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 10.8 нэгж хувиар өссөн дүнтэй байна.

2015 оны 5 дугаар сараас 2016 оны 6 дугаар сар хүртэлх хугацаанд банкны салбарын зээлийн жилийн өөрчлөлт сөрөг утгатай байсан бол 2016 оны 6 дугаар сараас эхлэн өсч, 2017 оны 5 дугаар сарын байдлаар 10.9 хувьд хүрээд байна. Нийт чанаргүй зээлийн хэмжээ 5 дугаар сарын эцсийн байдлаар 1153.8 тэрбум төгрөгт хүрч (нийт зээлийн 9.1 хувь), өмнөх оны мөн үеэс 92.1 тэрбум төгрөгөөр буюу 8.7 хувиар өссөн бол хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 925.3 тэрбум төгрөгт хүрч (нийт зээлийн 7.3 хувь) 4.5 хувиар нэмэгдлээ. Чанаргүй зээлийн өсөлт нь зээлийн эрсдэлийн сангийн зардлыг өсгөснөөр банкны салбарын өөрийн хөрөнгийн болон ашигт ажиллагааны үзүүлэлтэд сөргөөр нөлөөлж байна.

2017 оны I улирлын байдлаар 529 Банк бус санхүүгийн байгууллага, 282 Хадгаламж зээлийн хоршоо, 17 Даатгалын компани, Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй 302 Хувьцаат компани үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрийн тоо жил ирэх тусам нэмэгдэж байна. Гэсэн хэдий ч банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын санхүүгийн салбарт эзлэх хувь бага хэвээр байна.

2017 он гарсаар Монгол Улсын банк, санхүүгийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр холбогдох хууль тогтоомжид хэд хэдэн өөрчлөлт оруулаа.

[2] *Давхардсан тоогоор.*

Тухайлбал Монголбанкны Ерөнхийлөгчийн 2017 оны А-10 болон 2017 оны А-97 дугаар тушаалаар “Банкны салбарын хууль эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”-ийг боловсруулсан. Энэ хүрээнд Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийг боловсруулан 2017 оны 5 дугаар сард УИХ-аар батлуулсан.

Санхүүгийн салбарын үндсэн дэд бүтэц болох төлбөр тооцооны системийн үйл ажиллагаа тайлант хугацаанд хэвийн үргэлжлэв. Төлбөр тооцооны системийн нэг өдрийн дундаж үзүүлэлт жил бүр өсөн нэмэгдэж байна.

Шигтгээ 1: Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын зураглал

Санхүүгийн тогтвортой байдал нь макро эдийн засгийн тогтвортой байдалтай харилцан уялдаа бүхий чухал ойлголт болохыг 2008 оны дэлхийн санхүү эдийн засгийн хямрал тод томруунаар харуулсан. Гэвч санхүүгийн системийн ямар нөхцөл байдлыг тогтвортой гэж үзэх талаар нэгдсэн тодорхойлолт өнөө хэр байхгүй байгаа нь санхүүгийн тогтвортой байдлыг үнэлж, судлахад учирч буй бэрхшээл юм[3]. Гэсэн хэдий ч зарим орны төв банкууд өөрсдийн санхүүгийн салбарын онцлогийг харгалзан үзэж, санхүүгийн тогтвортой байдлыг харилцан адилгүй байдлаар тодорхойлох хандлага нэмэгдсэний зэрэгцээ санхүүгийн тогтвортой байдлыг үнэлэх аргачлалуудыг хөгжүүлсээр байгаа юм. Сүүлийн жилүүдэд улс орнууд санхүүгийн тогтвортой байдлын тайландаа түгээмэл ашиглаж буй "санхүүгийн тогтвортой байдлын зураглал"-ыг анхлан ОУВС-гийн эдийн засагчид боловсруулсан бөгөөд энэ нь санхүүгийн системд учирч болзошгүй эрсдэлийн түвшин, санхүүгийн байгууллагуудын эмзэг байдал, макро санхүүгийн орчны нөхцөл байдал зэргийг үнэлэн, нэгдсэн дүгнэлт, төсөөлөл өгөхөд ашиглагддаг. Энэхүү зураглалыг байгуулах аргачлалын шат дараалыг тоймлон авч үзвэл дараах байдалтай байна.

- Гол үзүүлэлтүүд буюу санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй эрсдэл, эмзэг байдал, нөхцөл байдлыг тодорхойлно.

- Гол үзүүлэлтүүдийн бүрэлдэхүүнд багтах, санхүүгийн тогтвортой байдалд учирч болзошгүй эрсдэл, түүнд нөлөөлөх нөхцөл байдлын тухайн үе дэх төлөвийг сайн илэрхийлэх дэд үзүүлэлтүүдийг сонгоно.

- Сонгогдсон дэд үзүүлэлт тус бүрээс эдгээрийн санхүүгийн тогтвортой байдалтай хамааралгүй бүрдэл хэсгүүд болох улирлын нөлөөлөл, тренд зэргийг шалгаж, засварлана. (Дэд үзүүлэлтүүдийн тоон мэдээлэл нь 2000-2016 оныг хамрах бөгөөд статистикийн боломжит байдлаас шалтгаалан харилцан адилгүй оноос эхэлсэн болно.)

- Дэд үзүүлэлтүүд тус бүрийн санхүүгийн тогтвортой байдалтай эерэг, сөрөг хамаарлаас шалтгаалан эерэг хамааралтай дэд үзүүлэлтүүдийг "-1" утгаар үржүүлж, харин сөрөг хамааралтай дэд үзүүлэлтүүдийг шууд авч, дэд үзүүлэлт тус бүрийн хугацааны цуваг утгын хувьд өсөх дараалалд оруулна. Жишээ нь, бодит ДНБ-ий өсөлт эерэг тогтвортой байх нь санхүүгийн тогтвортой байдалд эерэгээр нөлөөлөх бөгөөд энэ хэрээр санхүүгийн тогтвортой байдалд учирч болзошгүй эрсдэл буурна. Тиймээс бодит ДНБ-ийн өсөлтийн утга өндөр байх тусам зураглалд тусгах эрсдэлийн утга бага байна. Иймд бодит ДНБ-ий өсөлтийг "-1"-ээр үржүүлж, өсөх дараалалд оруулна. Харин эсрэг тохиолдолд буюу чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь хэмжээг авч үзвэл уг үзүүлэлт өндөр байх тусам санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх тул чанаргүй зээлийн түвшинг шууд авч, утгуудыг өсөх дараалалд оруулна.

- Үүний дараа дэд үзүүлэлтүүдийг 11 тэнцүү хэмжээтэй дэд олонлогт хуваах бөгөөд дэд олонлог тус бүрт харгалзан 0-10 хүртэлх утга өгнө. Ингэснээр дэд үзүүлэлт бүрийн дундаж утга нь 5 болно. Өндөр утга нь эрсдэл, эмзэг байдал их байгааг илтгэнэ.

- Гол үзүүлэлтүүдийг санхүүгийн тогтвортой байдлын зураглалд буулгахдаа тэдгээрийн утгыг түүний бүрэлдэхүүнд багтах дэд үзүүлэлтүүдэд оноосон утгуудын энгийн дунджаар тооцно. Мөн хэрэв гол үзүүлэлтийн утга бутархай гарвал хамгийн ойролцоо бүхэл тоон утгыг авна.

---

[3] *Өөрөөр хэлбэл, санхүүгийн тогтвортой байдал гэдэг нь төсөв, мөнгөний зэрэг макро эдийн засгийн бодлого, хууль эрх зүйн орчин, санхүүгийн салбар дахь микро, макро зохистой бодлого гэх мэт өргөн цар хүрээнд, тэдгээрийн харилцан уялдаагаар тодорхойлогддог ойлголт юм.*

- Гол үзүүлэлтүүдийг олон хэмжээст байдлаар графикт дүрсэлж, тайлбар хийнэ.

Хүснэгт Т.1

МУ-ын санхүүгийн тогтвортой байдлын зураглалын гол ба дэд үзүүлэлтүүд

Санхүүгийн тогтвортой байдлын зураглалд ашигласан үзүүлэлтүүд	
1. Макро эдийн засгийн эрсдэл	c. Банкны 1 жилээс бага хугацаатай гадаад зээл
a. ДНБ-ий бодит өсөлт	d. Хөрвөх чадвар сайтай актив ба богино хугацаат өр төлбөрийн харьцаа
b. Инфляци	**5. Банкны ашигт ажилллагаа ба төлбөрийн чадварын эрсдэл**
c. Төсвийн нийт тэнцэл/ДНБ	a. Активын өгөөж
d. Улсын нийт өр/ДНБ	b. Үл хөдлөх хөрөнгийн салбарт олгосон зээл/Нийт зээл
2. Гадаад секторын эрсдэл	c. Барилгын салбарт олгосон зээл/Нийт зээл
a. Нэрлэсэн үйлчилж буй ханшийн жилийн өөрчлөлт	d. Уул уурхайн салбарт олгосон зээл/Нийт зээл
b. Экспортын өсөлт	e. Чанаргүй зээл ба нийт зээлийн харьцаа
c. Гадаад өр/ДНБ	**6. Хөрөнгийн үнийн эрсдэл**
d. Голлох түүхий эдийн үнийн өсөлт	a. ТОП-20 өөрчлөлт
e. ГШХО/ДНБ	b. Уул уурхайн гол 3 компанийн хувьцааны үнийн өөрчлөлт
3. Мөнгө, зээлийн захын эрсдэл	c. Засгийн газрын бондын өгөөж
a. Нийт зээл/ДНБ	d. Орон сууцны үнийн индекс
b. АНУ болон Монгол Улсын мөнгөний бодлогын хүүний зөрүү	**7. Хувийн хэвшил, өрхүүдийн төлбөрийн чадварын эрсдэл**
c. Мөнгө (М2)/ДНБ	a. Хувийн хэвшилд олгосон зээлийн чанар
d. Зээл ба хадгалмжийн хүүгийн зөрүү	b. Хуийн хэвшилд олгосон зээл/ДНБ
4. Банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадвар ба санхүүжилтийн эрсдэл	c. Өрхүүдийн зээлийн чанар
a. Долларжилт	d. Өрхүүдэд олгосон зээл/ДНБ
b. Зээл, хадгаламжийн харьцаа	

Энэ аргачлал нь тоон өгөгдлийг тодорхой тархалттай байх гэсэн нөхцөл тавих шаардлагагүй харьцангуй энгийн арга юм.

Монгол Улсын Засгийн газраас Азийн Хөгжлийн Банк (АХБ)-тай хамтран хэрэгжүүлж буй "Санхүүгийн салбарын хөгжлийг дэмжих төсөл"-ийн хүрээнд олон улсын туршлага, Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн салбарын онцлог, тоон мэдээллийн олдоцтой байдал зэргийг харгалзан үзэж МУ-ын санхүүгийн тогтвортой байдлын зураглалд ашиглах нийт 7 гол, 30 дэд үзүүлэлтүүдийг тодорхойлсон болно (Хүснэгт Т.1).

Дүрслэл Т.1

Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын зураглал



Эх сурвалж: Монголбанк

Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын зураглалаас харахад 2016 оны эцсийн байдлаар гадаад секторын, макро эдийн засгийн, мөнгө, зээлийн, хөрөнгийн үнийн, хувийн хэвшил болон өрхүүдийн санхүүгийн эрсдэлүүд түүхэн хугацааны дундаж түвшингүүдээсээ өндөр байна[4].

Зураглалын үр дүнгээс санхүүгийн систем тогтвортой эсвэл тогтворгүй байна гэсэн шууд дүгнэлт хийх нь учир дутагдалтай бөгөөд үүнийг санхүүгийн системийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй эрсдэлүүдийн талаарх ерөнхий төсөөлөл өгөх, аливаа бодлогын хэлэлцүүлэгт анхан шатны эх сурвалж байдлаар ашиглах нь зохистой юм.

[4] *Түүхэн хугацааны дундаж түвшин нь хэвийн эрсдэлийн түвшинг илэрхийлэх албагүй юм.*

1 МАКРО-САНХҮҮГИЙН ОРЧИН

1.1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ

АНУ-ын эдийн засгийн жилийн өсөлт хүлээлтээс доогуур гарсан ч Хятад, Евро бүсийн эдийн засгийн идэвх сайжирсан тул шинжээчид дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөллийг өмнөх төсөөллөөс 0.1 нэгж хувиар нэмэгдүүлж, 2017 онд 3.5 хувиар өснө гэж үзжээ. Хятадын дэд бүтцийн хөрөнгө оруулалт нэмэгдэж, хэрэглээ өсч эдийн засгийн өсөлтийг дэмжсэн бол Евро бүсийн гадаад болон дотоод эрэлт мөнгөний уламжлалт бус тэлэх бодлогын нөлөөгөөр өсч, хөдөлмөрийн зах сэргэж эдийн засгийн өсөлтийг дэмжлээ. Харин АНУ-ын авто машины борлуулалт болон дулааны хэрэглээ буурснаас хэрэглээ буурч, эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлэв.

Дүрслэл 1.1

Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл



Эх сурвалж: ОУВС-гийн төсөөлөл, "Дэлхийн эдийн засгийн хандлага (World economic outlook update)" тайлан, 2017 оны 4 дүгээр сар

АНУ-ын эдийн засаг 2017 оны I улиралд хүлээлтээс бага буюу 0.7 хувиар өсч, өмнөх улирлаас 1.5 нэгж хувиар буурав. Хэдийгээр үл хөдлөх хөрөнгө болон газрын тос олборлолтын хөрөнгө оруулалт, экспорт зэрэг өссөн ч, авто машины борлуулалт, байрны халаалтын хэрэглээ зэрэг өрхийн хэрэглээ буурч эдийн засагт сөргөөр нөлөөллөө. Хувийн хэрэглээний зардал өмнөх улиралд 3.5 хувиар өсч байсан бол I улиралд 0.3 хувь болж, тогтмол хөрөнгө оруулалт өмнөх улиралд 9.4 хувь байсан бол 4.3 хувь болж тус тус буурлаа. Экспорт 2016 оны IV улиралд 4 хувиар өссөн бол 2017 оны I улиралд 5.8 хувь болж, импорт 4.1 хувиар өсч, өмнөх улирлаас 4.9 нэгж хувиар буурсан байна.

АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуулийн дараагаар Холбооны Нөөцийн Банк (ХНБ) 12 дугаар сарын 14-ны өдөр бодлогын хүүгээ 0.25 нэгж хувиар нэмэгдүүлсэн. АНУ-ын ажилгүйдлийн түвшин буурч, инфляци өсч, иргэдийн бодит орлого нэмэгдэж, дэлхийн санхүүгийн зах зээл тогтворжиж эхэлсэн нь ХНБ бодлогын хүүгээ нэмэх шалтгаан болсон. Үүний дараагаар ХНБ 2017 оны 2 дугаар сард ажил эрхлэлт болон инфляци хүлээгдэж буй түвшинд хадгалагдсаар байвал 3 дугаар сард бодлогын хүүгээ дахин нэмнэ гэж мэдэгдсэний дагуу 3 дугаар сарын 15-ны өдөр 0.25 нэгж хувиар нэмэгдүүлээд байв. ХНБ-аас 2017 оны 6 дугаар сар 14-ний өдөр мэдээлснээр АНУ-ын инфляцийн түвшин зорилтот 2 хувийн хүлээлтээс доогуур, ажилгүйдлийн түвшин буурч байгаа тул бодлогын хүүгээ 2017 оны 6 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дахин 0.25 хувиар нэмэх шийдвэрийг гаргаад байна. Ингэснээр бодлогын зорилтот хүү 1.25 хувьд хүрлээ. Цаашид ХНБ нь өөрийн балансын хэмжээг багасгаж, одоо эзэмшиж буй моргэйжээр баталгаажсан үнэт цаас, бусад өрийн бичгийн хөрөнгө оруулалтаа бууруулах хүлээлттэй байна.

Дүрслэл 1.2

АНУ-ын эдийн засгийн зарим гол үзүүлэлтүүд



Эх сурвалж: Блүмберг

Евро бүсийн эдийн засаг 2017 оны I улиралд 1.7 хувиар өслөө. Мөнгөний тоо хэмжээний тэлэх бодлогын нөлөөгөөр гадаад болон дотоод эрэлт өсч, хөдөлмөрийн зах зээл сэргэж Евро бүсийн эдийн засгийн өсөлтийг дэмжив. Түүнчлэн 2017 оны 2 дугаар сард 55.4 байсан аж үйлдвэрийн салбарын идэвхжлийг илтгэх PMI индекс 5 дугаар сард 57.0 болж, 2011 оны 4 дүгээр сараас хойшхи дээд түвшиндээ хүрч өссөн байна. Ийнхүү Евро бүсийн аж үйлдвэрийн салбарын идэвхжил сайжирч, үйлдвэрлэлийн хэмжээ, ажлын байр нэмэгдэхээр байна. Харин инфляци 2017 оны 5 дугаар сарын байдлаар 1.4 хувь болж өмнөх сараас 0.5 нэгж хувиар буурчээ.

Евро бүсийн нийт ДНБ-ний 29 хувийг эзлэх Герман болон 11 хувийг эзлэх Испанийн эдийн засаг эрчимтэй өсч бүсийн өсөлтөд дэмжлэг болсон ч нийт ДНБ-ний 21 хувийг эзлэх Францын өсөлт удааширч, 16 хувийг эзлэх Италийн өсөлт хэвээр байлаа.

Дүрслэл 1.3

Евро бүсийн ажилгүйдлийн түвшин



Эх сурвалж: Блүмберг

Хятадын эдийн засаг 2017 оны I улиралд хүлээлтээс өндөр буюу 6.9 хувиар өсч, 2015 оны 9 дүгээр сараас хойшхи хамгийн өндөр түвшинд хүрлээ. Дэд бүтцийн хөрөнгө оруулалт нэмэгдэж, хэрэглээ өссөн нь эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлэв. Түүнчлэн 2017 оны 3 дугаар сарын байдлаар аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 7.6 хувиар, жижиглэнгийн худалдаа 10.9 хувиар, төрийн компаниудын хөрөнгө оруулалт 13.6 хувиар тус тус өссөн нь өсөлтөд дэмжлэг боллоо. Харин хэрэглээ 2017 оны эхний улиралд нийт ДНБ-ний 77.2 хувийг эзэлж байна. Хятадын эдийн засгийн өсөлтөд цэвэр экспорт 4.5 хувь, нийт хөрөнгө оруулалт 18.3 хувийн нөлөөг үзүүлсэн.

Дүрслэл 1.4

БНХАУ-ын нүүрсний импорт (сая тонн)



Эх сурвалж: Блүмберг

Хятадын Ардын банк юанийн ханшийг хамгаалах зорилгоор энэ жил мөнгөний бодлогоо чангаруулах арга хэмжээг авч, богино болон урт хугацааны хүүгээ хэд хэдэн удаа нэмэгдүүлэв.

Хятадын санхүү, эдийн засгийн байдал өр болон банк, санхүүгийн байгууллагуудын балансын эмзэг байдлаас ихээхэн хамааралтай байна. Хятадын эрх баригчид өрийн асуудал эдийн засгийн өсөлтөд нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байгаа ч хувийн секторийн өр ДНБ-ний 260 гаруй хувьд хүрээд буй нь компаниуд өрийн хямралд өртөх, чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэх, цаашлаад банкны системд тогтворгүй байдал бий болох эрсдэлтэй тул өрийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх шаардлагатайг олон улсын шинжээчид сануулсаар байна.

ДЭЛХИЙН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Зах зээлд оролцогчид АНУ-ын эдийн засагт сэргэх төлөв ажиглагдаж, төсвийн тэлэх бодлого, мөнгөний хумих бодлого хэрэгжин, журам зохицуулалтыг цөөлөх, худалдааны хамгаалах бодлогын хэрэгжилтийг хүлээсэн байдалтай байсан хэдий ч бодлогын өөрчлөлтүүдийн хугацаа, хэрэгжилтийн дэлхийн санхүү эдийн засагт нөлөөлөх нөлөөлөл тодорхойгүй хэвээр байгаа нь зах зээлд тодорхойгүй байдал үүсгэсээр байна. Европын улс орнуудад улс төрийн тодорхойгүй байдал үүссэний улмаас энэ бүс нутгийн улс орнуудын засгийн газрын бондын өгөөж буурах хандлага ажиглагдав.

Түүнчлэн хөрөнгийн өгөөж бүс нутаг, эдийн засгийн сектор, хөрөнгийн төрлөөсөө хамааран бие биедээ харилцан нөлөөлөх нөлөөлөл харьцангуй буурсан хэмээн Олон улсын төлбөр тооцооны банк (BIS) үзэж байна. Дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын дараа үеэс эхлэн зах зээлд хөрөнгийн өгөөж харилцан хамааралтайгаар тогтож байсан бол энэ хандлага 2017 оны эхний хагаст ажиглагдсангүй. Энэ нь хөрөнгө оруулагчдын эрсдэлийн дуршил (risk appetite) хөрөнгийн үнэлгээнд төдийлөн нөлөөгүй болсныг илтгэж байгаа юм. Өөрөөр хэлбэл хөгжингүй болон хөгжиж буй улсуудын хөрөнгийн зах зээл, хөгжиж буй улсуудын засгийн газрын үнэт цаасны өгөөж, хөгжингүй улсуудын урт хугацаат үнэт цаасны өгөөж, ам.долларын ханш, компаниудын бондын өгөөж зэрэг үзүүлэлтүүд 2009 оноос хойш харилцан уялдаатайгаар хөдөлж байсан бол АНУ-ын бодлогын тодорхойгүй байдлаас шалтгаалан хөрөнгө оруулагчдын эрсдэлийн үнэлэмж өөрчлөгдөн, хөрөнгийн үнүүдийн корреляц буураад байна.

Дүрслэл 1.5

Зарим хөрөнгийн захын индекс



Эх сурвалж: Блүмберг.
Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2017 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн статистик болно, 2015.12.31=100.

Хөгжингүй улс орнуудын эдийн засгийн төлөв сайжирч байгаатай холбоотойгоор хувьцааны зах зээлд сэргэлт ажиглагдаж байна. Тухайлбал ажилгүйдлийн түвшин буурч, үйлдвэрлэл сэргэсэн, инфляцийн түвшин өсч, түүхий эдийн үнэ өсч эхэлсэн нь хувьцааны зах зээлд эерэгээр нөлөөлж байна.

Зах зээлд оролцогчдын итгэл ийнхүү сэргэж эдийн засгийн эерэг төлөв ажиглагдах болсон нь макро эдийн засгийн бодлогын орчин өөрчлөгдөх хүлээлтийг бий болгов. Ялангуяа томоохон эдийн засаг бүхий улс орнуудын мөнгөний бодлогын төлөв, түүний талаарх хүлээлт зах зээлийн анхаарлын төвд ороод байна.

Дүрслэл 1.6

Хөгжингүй улс орнуудын бодлогын хүү



Эх сурвалж: Блүмберг.
Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2017 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн статистик болно.

Томоохон эдийн засаг бүхий улс орнуудын төв банкууд мөнгөний харилцан адилгүй бодлого явуулж байна. АНУ-ын хувьд энэ оны 3, 6 дугаар сард бодлогын хүүгээ тус бүр 0.25 хувиар нэмэгдүүлсэн бөгөөд цаашид 9, 12 дугаар сард бодлогын хүүг дахин нэмж магадгүй гэсэн хүлээлттэй байгаа бол Европын төв банк, Японы төв банкууд бодлогын хүүгээ урт хугацаанд бага түвшинд хадгалах төлөвтэй байгаа юм. Мөнгөний бодлогын дээрх харилцан адилгүй байдал нь бондын зах зээлд мөн нөлөөлж байна.

Дүрслэл 1.7

Зарим хөгжингүй орнуудын Засгийн газрын 10 жилийн хугацаатай бондын өгөөж



Эх сурвалж: Блүмберг.
Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2017 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн статистик болно.

Тухайлбал АНУ-ын засгийн газрын 10 жилийн хугацаатай бондын өгөөж 2017 оны эхэнд 2.45% байсан бол 2017 оны 6 дугаар сард 2.15% болж бууруаад байна. Энэ нь тус улсын засгийн газрын бондын үнэ өссөнийг илтгэх үзүүлэлттэй юм. Харин Япон Улсын засгийн газрын 10 жилийн хугацаатай бондын өгөөж 0.01 хувиас 0.12 хувийн хооронд хэлбэлзсэн үзүүлэлттэй байна.

Дүрслэл 1.8

Банк хоорондын захын хүү, LIBOR



Эх сурвалж: Блүмберг.
Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2017 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн статистик болно.

Зах зээл дээрх хөрөнгийн үнийн төлөв байдлаас ажиглахад хөгжиж буй улс орнуудад тулгарч буй сорилтууд төдийлөн өөрчлөгдсөнгүй.

Дүрслэл 1.9

Голлох валютуудын ам.доллартай харьцах ханш



Эх сурвалж: Блүмберг.
Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2017 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн статистик болно, 2015.12.31=100.

АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн дараа хөгжингүй улс орнуудын хөрөнгийн үнэд огцом хэлбэлзэл үүсч байсан бөгөөд энэхүү сөрөг шокийн нөлөө хадгалагдсан хэвээр байна. Тухайлбал БНХАУ-ын эдийн засгийн өсөлт, гадаад худалдаа, санхүүгийн зах зээлийн төлөв байдал нь дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээлд үүсээд буй одоогийн

нөхцөл байдалтай уялдан валютын зах болон бондын зах зээлд хөрвөх чадвар муудахад хүргээд байна.

Нэг талаас АНУ-ын эдийн засгийн төлөв эерэг дүр зурагтай байгаа, нөгөө талаас Европын улс орнуудад сонгуулийн жил таарсан, улс төр, геополитикийн тодорхой бус байдал байсаар байгаа нь олон улсын валютын захад нөлөөлж байна. 2017 оны эхний хагаст ам.долларын эсрэг голлох валютууд, тухайлбал евро, фунт, иений ханш чангарах хандлага ажиглагдлаа.

ДЭЛХИЙН ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Дэлхийн зах зээл дээр зэсийн үнэ 2017 оны 2 дугаар сард дунджаар 5941 ам.доллар болж, 2015 оны 5 дугаар сараас хойшхи дээд цэгтээ хүрчээ.

Дүрслэл 1.10

Зарим түүхий эдийн үнэ



Эх сурвалж: Блүмберг.
Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2017 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн статистик болно, 2015.12.31=100.

Уг өсөлтөд АНУ-ын шинэ ерөнхийлөгч дэд бүтцийн хөрөнгө оруулалтад 1 их наяд ам.доллар зарцуулахаа амласан нь голлон нөлөөлсөн юм. Мөн Чили болон Перу дахь томоохон уурхайн ажилчид ажил хаялт зарласан, Индонезийн зэсийн уурхайн нийлүүлэлт зогссон зэргээс үүдэн 2017 оны эхний хагаст зэсийн үнэ өсч, 6106 ам.доллар/тн-д хүрсэн. Хэдийгээр хоёр ч томоохон зэсийн уурхайн үйл ажиллагаа зогсоод байсан ч зах зээл дээр зэсийн нийлүүлэлт их хэвээр, эрэлт сул байснаас 3 дугаар сараас үнэ эргэн буурч, 5 дугаар сард 5600 ам.долларын түвшинд очсон. Харин 2017 онд зэсийн зах зээл дээр Хятадын хэрэглээ тогтворгүй байх төлөвтэй байгаагаас үнэ одоогийн түвшнээс буурна гэж шинжээчид үзэж байна.

Монгол Улсын зэсийн салбар 2015, 2016 онд нийт экспортын орлогын 47 хувийг бүрдүүлдэг голлох салбар байсан бол нүүрсний үнийн өсөлтөөс үүдэн 2017 оны 5 дугаар сарын байдлаар нийт экспортын 25 хувийг бүрдүүлж байна. Улмаар экспортын орлогын зэсийн салбараас хамаарах хамаарал буурч буй нь тогтвортой байдалд эерэгээр нөлөөлж байна.

Тайлант хугацаанд Монгол Улсын экспортын гол бүтээгдэхүүний нэг нүүрсний үнэ дэлхийн зах зээл дээр өсөлттэй байлаа. Үнийн өсөлтөөс үүдэн Монгол Улсын нүүрсний экспортын орлого 2017 оны 5 дугаар сард өмнөх оны мөн үеэс 376 хувиар өссөн бөгөөд үүний 66 хувийг тоо хэмжээний өөрчлөлт, 34 хувийг үнийн өөрчлөлт бүрдүүлж байна. Ингэснээр нийт экспортын орлогод эзлэх нүүрсний экспортын хувийн жин 40 хувьд хүрч өсөв. Тухайлбал Австралийн сайн чанарын коксжих нүүрсний гэрээний жишиг үнэ 2016 оны III улиралд 92 ам.доллар/тн байсан бол 2016 оны IV, 2017 оны I улиралд харгалзан дунджаар 200 ам.доллар/тн, 285 ам.доллар/тн-д хүрч өссөн. Үнэ ийнхүү өсөхөд Хятадын Засгийн газраас агаарын бохирдолыг бууруулах зорилгоор уурхайн ажлын өдрийг 16 хувиар бууруулсан нь голлон нөлөөлсөн. 2017 оны 4 дүгээр сард Австралийн зүүн эргийг “Debbie” хар салхи дайрч өнгөрсний улмаас төмөр зам, усан боомт, нүүрсний уурхай зогсонги байдалд орж, улмаар Квинслэнд мужийн нүүрсний гарц эрс буурсан нь үнэд дэмжлэг үзүүлсэн. Австралид болсон байгалийн гамшгаас үүдэн нийлүүлэлт саатсанаар үнэ дахин өсч 1 тонн

нүүрсний үнэ 314 ам.долларт хүрсэн нь 2011 оноос хойшхи хамгийн өндөр үзүүлэлт байв.

Дүрслэл 1.11

БНХАУ-ын нүүрсний импорт (сая тонн)



Эх сурвалж: Блүмберг.
Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2017 оны 1 дүгээр улирлын статистик болно, 2015.12.31=100.

2016 оны сүүлийн хагаст дунджаар 61 ам.доллар байсан бол 2017 оны эхээр 82 ам.долларын түвшинг даваад байсан нэг тонн хүрэн нүүрсний үнэ 4 дүгээр сард 73 ам.доллар болж буурсан. Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор Хятад улс нүүрсний олборлолтоо танаж эхэлснээс хүрэн нүүрсний импорт өсч, үнэ өссөн. Гэвч Хятадын ЗГ-аас хэрэгжүүлсэн дотоодын олборлолтыг хязгаарлах бодлого нь томоохон уурхайнуудад энэ жилийн хувьд цуцлагдаад байгаа явдал нь 4 дүгээр сард эрчим хүчний нүүрсний нийт үйлдвэрлэл 10 хувиар өсөхөд хүргэж ийнхүү үнэд нөлөөллөө. Цаашдаа энэ бодлогод өөрчлөлт орохгүй байх нь үнэ өсөхгүй байх гол шалтгаан болно гэж шинжээчид үзэж байна.

Харин алтны хувьд дэлхийн зах зээл дээрх үнэ 2017 оны эхнээс тогтвортой өссөөр байна. Нэг унци алтны үнэ 2017 оны эхэнд 1159 ам.доллар байсан бол энэ оны 6 дугаар сарын эхээр 1292 ам.долларт хүрч оны эхнээс 11.5 хувиар өслөө. АНУ-ын шинэ Ерөнхийлөгчийн татвар, эрүүл мэндийн бодлогын шинэчлэл гэх мэт томоохон асуудлууд хойшлогдсон, Хойд Солонгос зэрэг улсуудтай үүсээд буй улс төрийн хурцадмал байдал, геополитикийн эрсдэл, Европын томоохон орнуудын улс төрийн сонгуулийн үр дүнгийн тодорхой бус байдал зэрэг нь оны эхнээс алтны үнэ өсөхөд голлон нөлөөлөөд байна. Их Британи, Франц зэрэг улсуудад удаа дараалан болсон гэмт халдлага дэлхийн улс төр, нийгмийн тогтворгүй байдалд нэмэрлэн, хөрөнгө оруулагчдыг эрсдэл багатай хөрөнгө болох алтанд хөрөнгө оруулахад хүргэж, энэ нь тус түүхий эдийн үнэд эерэгээр нөлөөлөөд байна. Түүнчлэн эрэлт өсөх төлөвтэй байгааг техник шинжилгээний үзүүлэлтүүд давхар илтгэж байна. Тухайлбал, хамгийн сүүлийн зураглалаар харвал, алтны үнийн сүүлийн 50 өдрийн дундаж 200 өдрийн дунджаа огтолж үүнээс дээш гарсан. Ийм тохиолдол сүүлийн 5 жилд ердөө 4 удаа тохиосон гэдгийг шинжээчид онцоллоо. Энэхүү хөдөлгөөн нь зах зээл дээр эерэг хүлээлт бий болсныг үндсэндээ илтгэдэг байна. АНУ-ын ХНБ бодлогын хүүгээ энэ жил гурван удаа өсгөх хүлээлт үүсээд байгаа нь ам.долларын хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэн нөгөөтэйгүүр цаашид алтны үнэд дарамт үзүүлэх боломжтойг шинжээчид онцолж байна.

2017 оны эхэнд 57 ам.долларт хүрч өсөөд байсан нэг баррель Брент төрлийн газрын тосны үнэ 6 дугаар сарын эхээр 50 ам.долларт хүрч оны эхнээс 12 хувиар бууруад байна. ОПЕК-ийн гишүүн орнуудын 5 дугаар сард болсон ээлжит хуралдаанаар газрын тосны гарцын хязгаарлалтыг дахин 9 сараар сунгахаар тохиролцсон билээ. Гэхдээ АНУ-ын газрын тосны нийлүүлэлт хурдацтай өсч буй энэ үед ОПЕК-ийн орнууд гарцын хязгаарлалтын хэмжээг нэмэгдүүлээгүй нь газрын тосны үнэд төдийлөн эерэг нөлөө үзүүлж чадахгүй байх магадлалтай. Дэлхийн томоохон банк, санхүүгийн байгууллагууд газрын тосны үнийг 2017 оны эцэс хүртэл баррель тутамд 55-56 ам.доллар байхаар таамаглаж байна.

1.2 МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч байгууллагуудаас Монгол Улсын урт хугацааны эдийн засгийн төлөвийг эерэгээр харж байгаа хэдий ч богино болон дунд хугацаанд төсөв, гадаад өрийн хувьд эрсдэл хэвээр байгааг анхааруулсаар байна.

Дүрслэл 1.12

Төлбөрийн тэнцлийн алдагдал



Эх сурвалж: Монголбанк.
Тэмдэглэл: *Урьдчилсан гүйцэтгэл
**Чингис бонд, Самурай бонд, Хөгжлийн банкны гадаад зээл, ЗГ-ын томоохон бонд, зээл зэргийг хасч тооцсон болно.

Гадаад секторын төлөвийг илэрхийлэгч төлбөрийн тэнцлийн статистикийг авч үзвэл 2017 оны 5 дугаар сарын байдлаар нийт төлбөрийн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэтэй харьцуулахад 2.6 дахин буурч 62.9 сая ам.долларт хүрсэн. Урсгал дансны алдагдал 94.4 хувиар буурч 23.6 сая ам.долларт, санхүүгийн дансны тэнцэл 82.2 хувиар буурч -101.3 сая ам.долларт хүрчээ. Төлбөрийн тэнцлийн алдагдал ийнхүү буурахад урсгал дансны алдагдлын бууралт санхүүгийн дансны ашгийн бууралтаас өндөр байсан нь голлон нөлөөлжээ.

2011-2013 онд дунджаар 4.8 тэрбум ам.долларын алдагдалтай явж ирсэн төлбөрийн тэнцлийн урсгал дансны алдагдал 2014 оноос эхлэн огцом буурч, улмаар 2015 онд өмнөх оноос 2 дахин буурсан бол 2016 онд өмнөх оноос 26.2 хувиар буурч -699.7 сая ам.долларт хүрсэн. Уг үзүүлэлт 2017 оны эхний 5 сарын байдлаар 94.4 хувиар буюу 396.8 сая ам.доллараар буурахад барааны гадаад худалдааны ашиг 55.4 хувиар өссөн, үйлчилгээний гадаад худалдааны алдагдал 11.6 хувиар буурсан нь урсгал дансны тэнцэл сайжрахад нөлөөлжээ.

Дүрслэл 1.13

Импортын жилийн өсөлт



Эх сурвалж: Гааль, татварын ерөнхий газар.
Тэмдэглэл: Жил бүрийн эхний 5 сарын гүйцэтгэлийг ашиглав.

Гаалийн статистик мэдээгээр гадаад худалдааны тэнцэл 2017 оны эхний 5 сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 69.4 хувийн өсөлттэй буюу 418.2 сая ам.доллараар өсч 1,021.0 сая ам.долларт хүрсэн. Үүнд экспортын өсөлт импортын өсөлтөөс давсан (экспорт 42.0 хувиар, импорт 27.8 хувиар өссөн) нь голлон нөлөөлжээ. 2017 оны эхний 5 сарын байдлаар гадаад худалдааны нийт эргэлт өмнөх оны мөн үеэс 36.3 хувийн өсөлттэй буюу 1,069.6 сая ам.доллараар өсч 4,016.0 сая ам.долларт хүрсэн нь төсвийн орлого бүрдэлт, цаашлаад эдийн засгийн идэвхжилд эерэг нөлөөтэй юм.

2017 оны эхний 5 сарын байдлаар өмнөх оны мөн үеэтэй харьцуулахад нефтийн бүтээгдэхүүний импорт 92.2 хувиар, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн 42.0 хувиар,

хэрэглээний бүтээгдэхүүн 10.4 хувиар тус тус өсч, аж үйлдвэрийн орц 5.5 хувиар буурсан байна.

Нийт экспорт тайлант хугацаанд өмнөх оны мөн үеэс 42.0 хувиар буюу 744.3 сая ам.долларaар өсөв. Экспортын өсөлтийг ерөнхий бүтээгдэхүүнээр авч үзвэл нүүрс 4.8 дахин, төмрийн хүдэр 2.2 дахин тус тус өссөн нь дээрх өсөлтийг голлон тайлбарлаж байна. Харин зэсийн хүдэр, баяжмал 20.0 хувиар, мөнгөжөөгүй алт 37.0 хувиар тус тус буурсан нь нийт экспортод сөргөөр нөлөөлөв.

2017 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр санхүүгийн дансны ашиг өмнөх оны мөн үеэс 468.6 сая ам.долларaар буурч 101.3 сая ам.долларт хүрчээ. Санхүүгийн дансны гол үзүүлэлтийн нэг болох гадаадын шууд хөрөнгө оруулалт 2017 оны эхний 5 сарын байдлаар 236.6 сая ам.долларт хүрчээ.

Дүрслэл 1.14

Гадаадын шууд хөрөнгө оруулалт (цэвэр дүнгээр)



Эх сурвалж: Монголбанк.
Тэмдэгдэл: Томоохон компаниудын хөрөнгө оруулагчаас авсан зээлийн эргэн төлөлт хийгдсэн тул гадаадын шууд хөрөнгө оруулалт /цэвэр дүнгээр/ 2016 онд -4170.9 тэрбум ам.долларт хүрсэн.

Гадаад, дотоод эдийн засгийн тааламжгүй нөхцөл байдлаас шалтгаалан 2013 оноос хойш огцом буурсан Монгол Улсад орох гадаадын шууд хөрөнгө оруулалт Оюу толгой төсөл болон бусад томоохон төсөл хөтөлбөрүүдийн нөлөөгөөр дунд хугацаанд сэргэх хандлагатай байна.

Харин багцын хөрөнгө оруулалтын дансны хувьд Засгийн газар 2017 оны 3 сарын 9-ний өдөр олон улсын зах зээлд 600 сая ам.долларын Хуралдай бондыг амжилттай арилжлаа. Энэхүү бонд нь 8.75 хувийн хүүтэй 2024 онд эргэн төлөгдөх хуваарьтай 7 жилийн хугацаатай бонд бөгөөд уг бондоор Засгийн газрын баталгаатай Хөгжлийн банкны 580.0 сая ам.долларын евро бондын 82.0 хувь буюу 476.0 сая ам.долларыг дахин санхүүжүүлээд байна.

Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2015 онд 2.3 хувь, 2016 онд 1.0 хувийн өсөлттэй байсан бол 2017 оны I улиралд 4.2 хувийн өсөлттэй гарлаа.

Дүрслэл 1.15

Улирлын ДНБ-ий жилийн өсөлт, 2010 оны үнээр



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Уул уурхайн салбарын өсөлт I улиралд -1.8 хувьтай гарав. Харин уул уурхайн бус салбар тайлант хугацаанд өмнөх оны мөн үеэс 6.0 хувиар өссөн ба үүний дотор худалдааны салбар 2.5 хувь, бүтээгдэхүүний цэвэр татвар 1.9 хувь, боловсруулах үйлдвэрлэл 0.9 хувийн өсөлттэй байв.

ОУВС-гийн "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр" хэрэгжүүлэх бодлогын урьдач арга хэмжээний хүрээнд УИХ Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулав. Төсвийн орлогын хувьд дараах арга хэмжээг авахаар төсвийн тодотголд тусгажээ. Үүнд:

1. Архи, тамхины онцгой албан татвар, импортын тамхины гаалийн албан татварыг нэмэгдүүлэх: 2018 онд 10 хувь, 2019-2020 онд тус бүр 5 хувь нэмэх;

2. Автобензин, дизелийн түлшний онцгой албан татварыг хуульд заасан хязгаарт багтаан нэмэгдүүлэх;
3. Суудлын автомашины онцгой албан татварыг нэмэгдүүлэх: ингэхдээ хос тэжээлт автомашин, шингэрүүлсэн хийгээр ажилладаг автомашин, цахилгаан тэжээлт автомашины татварын хөнгөлөлтийг бууруулах, суудлын автомашины хөдөлгүүрийн багтаамж, насжилтаас хамааруулж онцгой албан татварын хэмжээг шинэчлэн тогтоох;
4. Хувь хүний орлогын албан татварыг шатлалтай болгох: Хувь хүний орлогын албан татварыг шатлалтай болгох, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ шинэчлэгдсэнтэй уялдуулан татварын хөнгөлөлтийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх (2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 10-25 хувиар 4 шатлал бүхий татвар ногдуулах бөгөөд жилийн орлого нь 18 сая хүртэл бол 10 хувь, 18-30 сая хүртэл бол 15 хувь, 30-42 сая хүртэл бол 20 хувь, 42 сая төгрөгөөс дээш бол 25 хувь);
5. Хадгаламжийн хүүгийн орлогод татвар ногдуулж эхлэх (10%);
6. Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийг нэмэгдүүлэх: 2018 оноос эхлэн гурван жилийн хугацаанд тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг ажил олгогч болон даатгуулагч тус бүр 1.0, 0.5, 1.0 нэгжээр буюу 2.5 нэгжээр (нийт 5 нэгжээр) нэмэгдүүлэх;

Харин төсвийн зарлагын хувьд нийгмийн халамжийн зардлыг хүн амын орлого багатай зорилтот бүлэгт чиглүүлэх, хүн ам зүйн бүтэц, хууль тогтоомжийн өөрчлөлтийн улмаас төсөвт үүссэн зардлын ачааллыг бууруулах, тэтгэврийн тогтолцоог шинэчлэх, цалин хөлсийг төсвийн боломжтой уялдуулах, зардлын үр ашгийг нэмэгдүүлэх зарчмыг баримтлан урсгал зарлагыг бууруулахаар төлөвлөсөн байна.

Дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлснээр Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 6,035.7 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 23.2 хувь, нийт зардал 8,750.2 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 33.6 хувь, нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн алдагдал 2,714.4 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 10.4 хувьд хүрэхээр байна.

2017 оны 5 дугаар сарын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 2,666.6 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 3.1 хувиар давжээ.

Хүснэгт 1.1

Төсвийн орлогын гүйцэтгэл (2017 оны 5 дугаар сар, тэрбум төгрөг)

Татварын төрөл	Төлөв.	Гүйц.	Зөрүү	Хувь
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламж	**2 823**	**2 913**	**-90**	**103%**
Татварын орлого	**2 115**	**2 302**	**-187**	**109%**
Үүнээс:				
Хувь хүний орлогын албан татвар	194	215	-21	111%
ААН-ийн орлогын албан татвар	368	399	-31	108%
Нийгмийн даатгалын орлого	427	496	-69	116%
Онцгой албан татвар	217	169	48	78%
Татварын бус орлого	**472**	**365**	**107**	**77%**
Үүнээс:				
Нийтлэг татварын бус орлого	401	353	48	88%
Хөрөнгийн орлого	0	0	0	226%
Тусламжийн орлого	71	12	59	16%

Эх сурвалж: Сангийн яам.

Харин төсвийн зарлагын хувьд 78.8 хувийн гүйцэтгэлтэй буюу 2951.1 тэрбум төгрөгт хүрч, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 412.5 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав.

М2 мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт 2017 оны 5 дугаар сарын байдлаар 21.5 хувиар өсч 12.9 их наяд төгрөгт хүрлээ. Харин М1 мөнгө өмнөх оны мөн үетэй харьцуулахад 40.3 хувиар буюу 703.4 тэрбум төгрөгөөр өсч, мөнгөний нийлүүлэлтийн 18.9 хувь буюу 2.5 их наяд төгрөгтэй тэнцэж байна.

Дүрслэл 1.16

Гадаад, дотоод цэвэр актив болон М2 мөнгө



Эх сурвалж: Монголбанк.
Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2017 оны 05 дугаар сарын статистик болно.

Нийт эдийн засгийн идэвхжил саарсантай холбоотойгоор банкны салбарын зээлийн чанар муу хэвээр байна. Уул уурхай, боловсруулах үйлдвэрийн салбарт олгосон зээлийн чанар бусад салбартай харьцуулахад муу байна.

Дүрслэл 1.17

Зээлийн чанар, салбараар, 2017 оны 5 дугаар сарын байдлаар (валютын төрлөөр)



Эх сурвалж: Монголбанк.
Тэмдэглэл: Бөмбөлгийн диаметрийн хэмжээ нь тухайн салбарт олгосон банкны зээлийн өрийн үлдэгдлийн хэмжээг илэрхийлнэ.

2017 оны 5 дугаар сард улсын хэрэглээний үнийн индекс жилийн 3.7 хувиар, Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс жилийн 3.8 хувиар тус тус өссөн байна. Дээрх хугацаанд Улаанбаатар хотын жилийн инфляцийг бүтцээр нь задлан авч үзвэл -0.2 нэгж хувийг мах, 0.2 нэгж хувийг хувцас, бөс бараа, 0.4 нэгж хувийг орон сууц, ус, түлшний үнийн өөрчлөлт тайлбарласан бол үлдсэн 3.3 нэгж хувийг бусад бараа, үйлчилгээний үнийн өсөлт бий болгожээ.

Дүрслэл 1.18

Инфляцийн задаргаа



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк.
Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2017 оны 5 дугаар сарын статистик болно.

ГАДААД СЕКТОР

Нийт төлбөрийн тэнцэл

Монгол Улсын төлбөрийн тэнцэл 2017 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр 62.9 сая ам.долларын алдагдалтай гарч, алдагдал өмнөх оны мөн үеэс 167.8 сая ам.долларaар өссөн үзүүлэлттэй байна. Санхүүгийн дансны ашиг өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 82.2 хувь буюу 468.6 сая ам.долларaар буурсан үзүүлэлттэй байна.

Дүрслэл 1.19

Төлбөрийн тэнцлийн гүйцэтгэл (сая ам.доллар)



Эх сурвалж: Монголбанк.
Тэмдэглэл: *Урьдчилсан гүйцэтгэл.

Урсгал ба хөрөнгийн данс

Төлбөрийн тэнцлийн урсгал ба хөрөнгийн данс 2017 оны эхний 5 сарын байдлаар 2.5 сая ам.долларын алдагдалтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 389.4 сая ам.долларaар буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Дүрслэл 1.20

Урсгал ба хөрөнгийн дансны тэнцэл



Эх сурвалж: Монголбанк.
Тэмдэглэл: *Урьдчилсан гүйцэтгэл.

Ийнхүү урсгал ба хөрөнгийн тэнцлийн алдагдал буурахад барааны гадаад худалдааны тэнцэл 55.4 хувиар сайжирч, үйлчилгээний дансны алдагдал 11.6 хувиар буурсан, анхдагч орлогын дансны алдагдал 11.8 хувиар буурсан нь голлох нөлөө үзүүлжээ. Урсгал тэнцлийн алдагдал 2015 онд дунджаар ДНБ-ий 8.1 хувь, 2016 онд ДНБ-ий 6.3 хувьтай тэнцэж байсан бол 2017 оны 1 дүгээр улирлын байдлаар 7.4 хувь болж өссөн үзүүлэлттэй байна.

Дүрслэл 1.21

Урсгал тэнцлийн санхүүжилт



Эх сурвалж: Монголбанк.
Тэмдэглэл: *Урьдчилсан гүйцэтгэл.

Урсгал дансны алдагдлыг 2013-2016 онд гадаад зээл болон гадаад валютын нөөцийн эх үүсвэрээр голлон санхүүжүүлжээ. Харин 2017 оны эхний 5 сарын байдлаар урсгал дансны алдагдал харьцангуй бага байгаатай холбоотойгоор өмнөх жилүүдтэй үл харьцуулагдахаар байна. Хүснэгт 1.4-өөс харахад сүүлийн жилүүдэд урсгал дансны алдагдлыг санхүүжүүлэх зээлийн бус санхүүжилт (хөрөнгө оруулалт)-ийн хувь хэмжээ 2012 оноос хойш тасралтгүй буурсаар ирсэн бөгөөд энэ нь нэг талаас бүрэлдэж буй эдийн засагтай улс орнууд, ялангуяа түүхий эд экспортлогч улсуудын эрсдэл нэмэгдсэн, нөгөө талаас АНУ-ын эдийн засаг сайжирч, ам.долларын ханш чангарснаар хөрөнгө оруулагчдын хөрөнгөө аюулгүй газар байршуулах сонирхол нэмэгдэж, хөрөнгийн урсгал хөгжингүй улсууд руу шилжих хандлагатай болсонтой холбоотой байна. Энэ нь манай улсын гадаад секторын эрсдэлийг нэмэгдүүлэх сөрөг нөлөөтэй ч хөгжингүй улс орнуудын эдийн засаг идэвхжихэд гадаад худалдаа, хөрөнгө оруулалтаар дамжин шууд бус замаар хөгжингүй орнуудын эдийн засагт эерэгээр нөлөөлөх боломжтой юм.

Хүснэгт 1.2

Урсгал тэнцлийн алдагдлын санхүүжилт

Огноо	Зээлийн санхүүжилт	Зээлийн бус санхүүжилт	Гадаад валютын нөөц
2010	20%	179%	-98%
2011	9%	91%	-0.4%
2012	10%	121%	-30%
2013	19%	42%	39%
2014	37%	39%	24%
2015	18%	54%	28%
2016	59%	38%	3%
2017M1-5	-10.9%	9.2%	2.7%

Эх сурвалж: Монголбанк.

Түүнчлэн өнгөрсөн оноос хэрэгжүүлсэн төсөв, мөнгөний бодлого болон ОУВС-тай хамтран хэрэгжүүлэх хөтөлбөрийн нөлөөгөөр макро-эдийн засгийн эрсдэл, тодорхой бус байдал багасч, гадаад худалдааны нөхцөл сайжирсан, богино хугацаат гадаад өрийн эргэн төлөлтийн дарамт буурсан, зах зээлд оролцогчдын итгэл сэргэх хандлагатай байгаа нь дунд хугацаанд хөрөнгө оруулалтын урсгал болон хөрөнгө, санхүүгийн дансны ашгийг нэмэгдүүлэх хүлээлттэй байна.

Санхүүгийн данс

Санхүүгийн данс 2017 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр 101.3 сая ам.долларын ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 468.6 сая ам.долларaар буурсан үзүүлэлт байна. Санхүүгийн дансны ашиг ийнхүү буурахад багцын хөрөнгө оруулалт 535.4 сая ам.долларaар буурсан нь голлон нөлөөлөв.

Дүрслэл 1.22

Санхүүгийн дансны бүтэц (сая ам.доллар)



Эх сурвалж: Монголбанк.
Тэмдэглэл: *Урьдчилсан гүйцэтгэл.

Гадаад худалдаа

2017 оны 5 дүгээр сард экспортын үнийн индекс өмнөх оны мөн үеэс 22 хувиар, импортын үнийн индекс 6 хувиар тус тус өссөнөөр Монгол Улсын гадаад худалдааны нөхцөлийн индекс (2012 оны 12 сарын суурьтай) 1.59 нэгж болж, өнгөрсөн оноос 15 хувиар сайжирсан үзүүлэлттэй байна.

Дүрслэл 1.23

Гадаад худалдааны нөхцөлийн индекс



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар, Монголбанк.
Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2017 оны 5 дугаар сарын статистик болно.

2017 оны эхний 5 сарын байдлаар экспорт өнгөрсөн оны мөн үеэс 42.0 хувиар өссөн бөгөөд гол нэрийн бүтээгдэхүүний ангиллаар авч үзвэл чулуун нүүрс 376.0 хувиар (45.0 нэгж хувь), төмрийн хүдэр, баяжмал 126.0 хувиар (4.0 нэгж хувь) тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

Дүрслэл 1.24

Нийт экспорт (жил бүрийн эхний 5 сарын байдлаар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар.

Импорт өнгөрсөн оны мөн үеэс 27.8 хувиар өссөн бөгөөд гол нэрийн бүтээгдэхүүний ангиллаар авч үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн 40.0 хувиар (13.0 нэгж хувь), нефтийн бүтээгдэхүүн 92.0 хувиар (11.0 нэгж хувь) тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

Дүрслэл 1.25

Нийт импорт (жил бүрийн эхний 5 сарын байдлаар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар.

Гадаад валютын ханш

Төгрөгийн ам.долларт харьцах Монголбанкнаас зарласан дундаж ханш 2017 оны 5 дугаар сард 2413.06 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 20.3 хувиар суларсан бол гадаад худалдааны эргэлтээр жигнэж тооцсон нэрлэсэн ханш (NEER) 2017 оны 5 дугаар сарын байдлаар 14.8 хувиар, бодит үйлчилж буй ханш (REER) 2017 оны 4 дүгээр сарын байдлаар 16.2 хувиар тус тус суларсан байна[5]. Нэрлэсэн үйлчилж буй ханшийн сулралт нь ам.долларын эсрэг төгрөгийн ханш суларч байгаатай холбоотой юм.

Дүрслэл 1.26

Гадаад валютын ханш (жилийн өөрчлөлтийн хувь)*



Эх сурвалж: Монголбанк.
Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2017 оны 5 дүгээр сарын статистик болно. (+) Чангаралт / (-) Сулралт

Гадаад өр

Монгол Улсын нийт гадаад өр (улсын болон хувийн секторыг нийтэд нь оруулснаар) сүүлийн 6 жил тасралтгүй өсч 2017 оны 1 дүгээр улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 6 хувиар буюу 1498.4 сая ам.долларaар нэмэгдэж, 25.0 тэрбум ам.долларт хүрсэн нь 2011 онтой харьцуулахад 14.0 тэрбум ам.долларaар буюу 2.3 дахин өссөн үзүүлэлт юм. Уг өсөлтөд 2011-2012 онд уул уурхайн салбарын компаниуд гадаадын хөрөнгө оруулагчаас авсан зээл, санхүүжилт, Монгол Улсын Засгийн газрын олон улсын зах зээлд гаргасан Чингис болон Дим сам бонд, Хөгжлийн банкны бондууд болон гадаад зээл, МИАТ ХК болон банкны салбарын гадаадын банк санхүүгийн байгууллагаас авсан зээл голлох нөлөөг үзүүлж байна.

Гадаад өрийн бүтцийг 2017 оны 1 дүгээр улирлын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулвал Төв банкны гадаад өр 343.5 сая ам.долларaар буурсан бол Засгийн газрын гадаад өр[6] 1771.9 сая ам.долларaар, хувийн хэвшлийн гадаад өр 70.0 сая ам.долларaар тус тус өссөн байна. Ингэснээр Засгийн газрын гадаад өр[3] 5.8 тэрбум ам.долларт буюу ДНБ-ий 53 хувьд[7] хүрсэн үзүүлэлттэй байна.

[5] *Жигнэсэн дунджаар тооцсон нэрлэсэн болон бодит ханшийг гадаад худалдааны түнш орнуудтай хийсэн худалдааны жингээр жигнэж тооцдог болно. REER ханш нь 1 сарын хоцрогдолтой тооцогддог.*

[6] *Засгийн газрын баталгаа бүхий гадаад зээлийг оруулаагүй.*
[7] *2016 оны нэрлэсэн ДНБ-ий гүйцэтгэлийг жилийн дундаж ханшаар хөрвүүлэв.*

Хүснэгт 1.3

Монгол Улсын нийт гадаад өр (сая ам.доллар)

Үзүүлэлт	2014	2015	2016Q1	2017Q1	Өөрчлөлт	
					Дүн	Хувь
Нийт гадаад өр	**21,851**	**22,718**	**23,459**	**24,957**	**1,498.4**	**6%**
I. Засгийн газар	**3,501**	**3,760**	**4,073**	**5,845**	**1,771.9**	**44%**
II. Төвбанк*	**1,570**	**1,960**	**2,084**	**1,741**	**-343.5**	**-16%**
III. Банк	**1,762**	**2,129**	**2,182**	**2,382**	**200.8**	**9%**
Богино хугацаат	357	407	444	501	56.9	13%
Урт хугацаат	1,406	1,721	1,738	1,882	143.9	8%
IV. Бусад сектор	**3,977**	**3,749**	**3,787**	**7,464**	**3,677.5**	**97%**
Богино хугацаат	555	326	343	435	91.4	27%
Урт хугацаат	3,421	3,423	3,444	7,030	3,586.2	104%
V. Шууд хөрөнгө оруулалт	**11,041**	**11,121**	**11,333**	**7,525**	**-3,808.4**	**-34%**

Эх сурвалж: Монголбанк.
Тэмдэглэл: *БНХАУ-ын Ардын банктай хийсэн своп хэлцлийн ашигласан дүнг оруулж тооцдог болно.

Гадаад валютын албан нөөц (ГВАН)

Монгол Улсын Гадаад валютын албан нөөцийн (ГВАН) хэмжээ 2017 оны 5 дугаар сарын эцсийн байдлаар 1,234.5 сая ам.долларт хүрч өмнөх оноос 14.4 хувиар буюу 207.4 сая ам.доллараар буурчээ. Энэ нь валютын төлбөртэй импортын 3.94 сарын хэрэгцээг хангах үзүүлэлт юм. Гадаад валютын албан нөөц харьцангуй тогтвортой байгаа нь (I) иргэд, аж ахуйн нэгжүүдийн Монголбанкинд тушаасан алтны хэмжээ нэмэгдсэн, (II) ОУВС-гийн хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсад орох гадаад валютын урсгал нэмэгдсэнтэй холбоотой юм.

Дүрслэл 1.27

Гадаад валютын албан нөөц



Эх сурвалж: Монголбанк.
Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2017 оны 5 дугаар сарын статистик болно.

ГВАН-ийн одоогийн түвшин нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үндсэн чиглэлд заасан 12 сарын импортын хэрэгцээт түвшинг хангахгүй байна:

- 2017 оны 5 дугаар сарын валютын шууд төлбөртэй импортын барааны дүнгээр авч үзвэл, 3.94 сарын буюу 118.3 хоногийн импортын,
- Монгол Улсын валютын шууд төлбөртэй импортын барааны сүүлийн 12 сарын дундаж гүйцэтгэлээр авч үзэхэд, 4.44 сарын импортын хэрэгцээг тус тус хангахаар байна.

ГВАН нь гадаад зах зээлийн сөрөг нөлөөллөөс дотоодын эдийн засгийг хамгаалах дархлаа болдог тул цаашид гадаад валютын албан нөөцийг одоогийн байгаа түвшнээс нэмэгдүүлэх нэн шаардлага тулгарч байна.

Монгол Улсын зээлжих зэрэглэл

Монгол Улсын зээлжих зэрэглэлийг олон улсын зэрэглэл тогтоогч Фитч, Стандард энд пүүрс, Мүүдиз агентлагуудаас тогтоож байна. Манай улсын зээлжих зэрэглэл[8] болон төлөв[9] сүүлийн жилүүдэд буурч хөрөнгө оруулалтын хувьд өндөр эрсдэлтэй орны ангилалд багтсан хэвээр байна.

Тайлант хугацаанд Мүүдиз агентлаг Монгол улсын зээлжих зэрэглэлийг 2 дугаар сарын 15-нд цаашид бууруулж болзошгүй хяналтанд оруулж, 3 дугаар сарын 30-ний өдөр зээлжих зэрэглэлийг "Саа1", төлөвийг "Тогтвортой" хэвээр үлдээн үнэлсэн. Мүүдиз агентлагийн үнэлгээнд Монгол Улсын Засгийн газрын гадаад төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэл нэмэгдсэн, гадаад санхүүжилтийн нөхцөл чангарч, зах зээлийн боломж хумигдаад байгаа, эдийн засгийн өсөлтийн төлөв сул, төсвийн алдагдал өндөр хэвээр,

[8] *Тухайн улсын Засгийн газрын зээлийн чадварыг илэрхийлдэг ба худалдааны нөхцөлтэй авсан өр төлбөрөө хугацаанд нь, бүтнээр эргэн төлөх чадвартай эсэх мөн тус үүргээ биелүүлэх бэлэн байдлыг харуулдаг.*

[9] *Зээлжих зэрэглэлийн хандлагыг илтгэх бөгөөд "эерэг" төлөв нь зэрэглэл сайжрах боломжтойг, "сөрөг" төлөв нь зэрэглэл буурч болзошгүй эрсдэлтэйг илэрхийлнэ.*

төсвийн алдагдал болон өрийн өсөлтийг хазаарлах бодлого хүлээлтээс удаан хэрэгжих төлөвтэй байгаа зэрэг хүчин зүйлс нь зээлжих зэрэглэлийг ийнхүү үнэлэхэд голлон нөлөөлснийг дурджээ.

Хүснэгт 1.4

Монгол Улсын зээлжих зэрэглэлийн өөрчлөлт

Огноо		Moody's			Fitch			Standard and Poors'		
		Үнэлгээ		Төлөв	Үнэлгээ		Төлөв	Үнэлгээ		Төлөв
2005	VII/18				B+		●			
	X/4	B1		●						
	XI/1							B		●
	XII/29							B		(+)
2006	XII/26							B+	▲	(+)
2007	XII/13							BB-	▲	●
	IX/20				B+		(+)			
2008	VI/2				B+		●			
	XII/9				B+		(-)			
	XII/19							BB-		(-)
2009	I/18				B	▼	(-)			
	VI/10	B1		(-)						
	X/30	B1		●						
	X/11				B		●			
	XI/20							BB-		●
2010	XI/23				B+	▲	●			
2011	XII/19							BB-		(+)
2012	X/29							BB-		●
2013	IV/16							BB-		(-)
	XII/13				B+		(-)			
2014	IV/29							B+	▼	●
	V/26	B1		(-)						
	VII/17	B2	▼	(-)						
	XII/11				B+		(-)			
2015	IV/29							B+		(-)
	XI/03							B	▼	●
	XI/04				B	▼	●			
	XI/24				B		●			
2016	I/14	B2		(-)	B		●			
	III/31	B2		(-)						
	IV/28							B		●
	VII/21				B		●			
	VIII/19							B-	▼	●
	VIII/26	B3	▼							
	XI/18	Caa1	▼	●						
	XI/21				B-	▼	●			
2017	II/15	Caa1	▼	●						
	II/20				B-		●			
	III/30	Caa1	▼	●						

Зэрэглэлийн өөрчлөлт ▲▼
Төлөв: (+)-эерэг, ●-тогтвортой, (-)-сөрөг

Эх сурвалж: Moody's, Fitch, S&P's, Монголбанк.

Фитч агентлаг ОУВС-гийн Монгол Улсад хэрэгжүүлэх "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-тэй холбогдуулан Монгол Улсын зээлжих зэрэглэлийг 2 дугаар сарын 20-ны өдөр "B-", төлөвийг "Тогтвортой" ангилалд хэвээр үнэлсэн. Түүнчлэн тус агентлаг хамгийн сүүлд 2017 оны 5 дугаар сарын 28-ний өдөр ОУВС-гийн Захирлуудын зөвлөлөөс Монгол Улсын Засгийн газар, Монголбанктай хамтран хэрэгжүүлэх "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийг албан ёсоор баталсан нь санхүүгийн эрсдэлийг бууруулах, эдийн засгийг тогтворжуулах болон төсвийн тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтой гэж мэдэгджээ. Түүнчлэн цаашид төсвийн үр ашигт байдлыг нэмэгдүүлэх, төсвийн алдагдлыг зорилтот түвшинд хүргэх болон дунд хугацаанд өрийн тогтвортой байдлыг хангахад хөтөлбөрийн болон уул уурхайн томоохон төслүүдийн хэрэгжилт нь зээлжих зэрэглэлийн үнэлгээнд чухал нөлөөтэй болохыг мэдэгдсэн юм.

Сангийн яамнаас мэдээлснээр Фитч агентлаг нь 2017 оны 8 дугаар сард Монгол Улсын зээлжих зэрэглэлийг дахин үнэлж үнэлгээний тайлангаа олон нийтэд мэдээлэх урьдчилсан товтой байна.

Ирэх жилүүдэд ОУВС-гийн хөтөлбөр болон уул уурхайн томоохон төсөл хөтөлбөрүүд амжилттай хэрэгжсэнээр эдийн засаг сэргэх, улсын төсөв, гадаад төлбөрийн чадвар огцом сайжрах хүлээлттэй байгаа тул Монгол Улсын дунд болон урт хугацааны эдийн засгийн төлөвийг ОУ-ын агентлагууд эерэгээр үнэлсэн хэвээр байна.

БОДИТ СЕКТОР

ОУВС-гийн Дэлхийн эдийн засгийн төлөвийн 2017 оны 4 дүгээр сарын тайлан (WEO)-д тусгаснаар манай улсын эдийн засгийн өсөлт 2017 онд -0.2 хувьтай байх төсөөлөлтэй байна. Харин албан ёсны статистик мэдээллээр эдийн засгийн өсөлт 2017 оны 1 дүгээр улиралд 4.2 хувиар өссөн эерэг үзүүлэлттэй байна.

Сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлтийн дийлэнх хувийг тайлбарлаж байсан уул уурхайн салбарын өсөлт удааширч тайлант хугацаанд -1.8 хувьд хүрэв. Харин уул уурхайн бус салбар тайлант хугацаанд өмнөх оны мөн үеэс 6.0 хувиар өссөнөөр 2 улирал дараалан өссөн үзүүлэлттэй байна.

Дүрслэл 1.28

Эдийн засгийн өсөлтийн задаргаа



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Уул уурхайн бус салбарыг эдийн засгийн үндсэн үйл ажиллагааны ангиллаар авч үзвэл худалдааны салбар 2.5 хувь, бүтээгдэхүүний цэвэр татвар 1.9 хувь, боловсруулах үйлдвэрлэл 0.9 хувийн өсөлттэй байсан нь уул уурхайн бус ДНБ-ий нийт 6.0 хувийн өсөлтийн 5.3 хувийг тайлбарлаж байна.

Хүснэгт 1.5

Бодит салбарын үндсэн үзүүлэлтүүд, 2010 оны зэрэгцүүлэх үнээр

	2015				2016				2017
	I	II	III	IV	I	II	III	IV	I
Бодит ДНБ, тэрбум төгрөг	**2 851**	**4 222**	**4 472**	**4 301**	**2 941**	**4 228**	**4 196**	**4 636**	**3 064**
Уул уурхайн	704	840	1 138	1 276	817	868	1 001	1 300	764
Уул уурхайн бус	2 148	3 382	3 334	3 025	2 124	3 360	3 195	3 337	2 300
Бодит ДНБ-ий өсөлт	**4.1%**	**2.4%**	**0.8%**	**2.7%**	**3.1%**	**0.1%**	**-6.2%**	**7.8%**	**4.2%**
Уул уурхайн	3.0%	3.4%	2.0%	4.1%	4.0%	0.7%	-3.1%	0.6%	-1.8%
Уул уурхайн бус	1.1%	-1.0%	-1.2%	-1.4%	-0.8%	-0.5%	-3.1%	7.2%	6.0%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Тайлант хугацаанд уул уурхайн салбараас гадна барилгын салбар 0.2 хувийн бууралттай байлаа.

Хүснэгт 1.6

ДНБ-ий бодит өсөлт (салбаруудаар)

	Бодит ДНБ	2016I		2017I	
		3.1%	100%	4.2%	100%
1	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	0.2%	5.9%	0.2%	5.1%
2	Уул уурхай, олборлолт	5.2%	166.6%	-1.8%	-42.7%
3	Боловсруулах үйлдвэрлэл	-1.0%	-30.8%	0.9%	22.5%
4	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0.2%	5.2%	0.1%	1.7%
5	Барилга	0.4%	12.2%	-0.2%	-4.4%
6	Бөөн/жиж.худалдаа; машин, мотоцикл засвар үйлчилгээ	-0.6%	-19.1%	2.5%	59.1%
7	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	-0.3%	-8.2%	0.6%	13.8%
8	Мэдээлэл, холбоо	0.0%	0.6%	0.0%	0.9%
9	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	0.2%	6.5%	0.0%	-0.5%
#	Бүтээгдэхүүний цэвэр татвар	-0.2%	-6.2%	1.9%	44.7%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Эдийн засгийн идэвх сүүлийн 3-4 жилийн турш саарч буйг дагаад санхүү, даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын ашиг, орлого болон зээл, хадгаламж олгох зэрэг үйлчилгээ мөн хумигдсан байна. Тухайлбал, өмнөх жилүүдэд 1.2-1.5 нэгж хувийн эдийн засгийн өсөлтийг бий болгож байсан санхүү, даатгалын үйл ажиллагаа 2016 онд 0.1 нэгж хувийн өсөлтийг эдийн засагт бий болгожээ[10].

Дүрслэл 1.29

Санхүү, даатгалын үйл ажиллагааны өсөлт, эдийн засагт эзлэх хувь



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Эдийн засгийн идэвхжил суларч буйн хирээр зээлийн өсөлт саарч, зарим үеүдэд сөрөг болсон хандлага сүүлийн жилүүдэд ажиглагдсан төдийгүй нийт зээлийн багцтай харьцуулахад хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэж байна.

Дүрслэл 1.30

Бодит ДНБ, нийт зээлийн өсөлт, нийт хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

[10] *Уг салбарын ангиллыг статистик тархаалтын хуваариас шалтгаалан 2017 оны 1 дүгээр улирлын байдлаар тооцох боломжгүй байна.*

Уул уурхайн салбар

Уул уурхайн салбар (нийт зээлийн багцын 6%, нийт чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн 28.4%)-ын гол нэр төрлийн бүтээгдэхүүнүүдээс тайлант хугацаанд олон улсын зах зээлд түүхий эдийн үнэ сэргэж, уурхайнуудын борлуулах нөхцөл сайжирч байгаатай холбоотойгоор нүүрс, төмрийн хүдрийн олборлолт өссөн үзүүлэлттэй байна. Түүнчлэн хайлуур жоншны баяжмал, молибдений баяжмал, алт зэрэг бүтээгдэхүүний үйлдвэрлэл өсөлттэй байсан бол энэхүү өсөлтөөс газрын тос, зэсийн баяжмал, хайлуур жонш, цайрын баяжмалын үйлдвэрлэлийн бууралт өндөр байсан тул уул уурхайн салбарын нийт өсөлт сөрөг утгатай гарахад хүрчээ. Оюу толгойн ил уурхайн зэсийн баяжмал, түүний металлын агууламж буурч байгаа нь зэсийн баяжмалын үйлдвэрлэл буурахад голчлон нөлөөлөв. Уул уурхайн салбарын үйлдвэрлэл 1 дүгээр улиралд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.4 хувиар агшчээ.

Дүрслэл 1.31

Уул уурхайн салбарын үйлдвэрлэл, зээлийн өсөлт, зээлийн чанар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк

Боловсруулах үйлдвэрлэлийн салбар

Боловсруулах үйлдвэрлэлийн салбар (нийт зээлийн багцын 10.6%, нийт чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн 13.0%)-ын өсөлт сүүлийн улирлуудад үр тарианы гурил, ундаа, согтуурулах ундаа зэрэг хүнсний бүтээгдэхүүн, нэхмэл бүтээгдэхүүн, кокс шахмал түлшний үйлдвэрлэл өсч байгаатай холбогдуулан сэргэж байгаа бөгөөд тайлант улиралд 19.8 хувиар өсчээ.

Дүрслэл 1.32

Боловсруулах салбарын үйлдвэрлэл, зээлийн өсөлт, зээлийн чанар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк

Барилга, үл хөдлөх хөрөнгийн салбар

Өрхүүдийн орон сууц худалдан авах эрэлт буурсантай уялдан барилгын салбарын уналт үргэлжилсэн хэвээр байна. Тус салбар нь 2017 оны эхний улирлын байдлаар нийт зээлийн багцын 9.6%, нийт чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн 11.6%; орон сууцны ипотекийн зээлийг оруулсанаар нийт зээлийн багцын 25.2%, нийт чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн 19.6%-ийг тус тус эзэлж байна.

Дүрслэл 1.33

Барилгын салбарын үйлдвэрлэл, зээлийн өсөлт, зээлийн чанар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк

Тодруулбал, 1 дүгээр улиралд тус салбар 14.3 хувиар агшсаны дийлэнх хувийг орон сууцны зориулалттай барилга, угсралтын ажлын удаашрал тайлбарлаж байна.

Дүрслэл 1.34

Үл хөдлөх хөрөнгийн үйлчилгээний салбарын үйлдвэрлэл, зээлийн өсөлт, зээлийн чанар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк

Худалдааны салбар

Худалдааны салбар (нийт зээлийн багцын 14.4%, нийт чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн 17.5%) тайлант улиралд 23.9 хувиар өсч, эдийн засгийн өсөлтийг бүрдүүлсэн гол салбаруудын нэг байв. Үүнд уул уурхайн салбарт хийгдэж буй бүтээн байгуулалтын хүрээнд хүнд даацын машин механизм, тоног төхөөрөмжийн борлуулалт нэмэгдсэнээс гадна суудлын автомашин, автобинзений борлуулалт нөлөөлөв.

Дүрслэл 1.35

Худалдааны салбарын үйлдвэрлэл, зээлийн өсөлт, зээлийн чанар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк

Бусад салбар

Бусад салбарууд (нийт зээлийн багцын 22.8%, нийт чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн 16.8%)-ын хувьд 1 дүгээр улиралд нийтдээ 1.9 хувиар өссөн бөгөөд үүний дийлэнх хувийг авто замаар тээх уул уурхайн бүтээгдэхүүний ачаа тээвэрлэлт өссөнөөр тээврийн салбар бүрдүүлэв. Харин бусад үйлчилгээний салбар[11] тайлант улиралд 0.1 хувиар удааширч, эдийн засгийн өсөлтөд төдийлөн нөлөө үзүүлсэнгүй.

Дүрслэл 1.36

Бусад салбарын[12] үйлдвэрлэл, зээлийн өсөлт, зээлийн чанар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк

Өрхийн хэрэглээ

Өрхийн хэрэглээ 2017 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 3.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Дүрслэл 1.37

Өрхийн хэрэглээ, нийт хэрэглээний зээл[13], хэрэглээний импортын өсөлт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк

Өнгөрсөн онд уг үзүүлэлт 8.8 хувиар агшаад байсан бол 2017 оны 1 дүгээр улиралд амралт, аялал жуулчлал, тээвэр, эм, эмнэлгийн хэрэгслийн хэрэглээ нэмэгдсэн нь хэрэглээний өсөлтөд эерэгээр нөлөөлжээ. Хэрэглээний өсөлттэй уялдан удаан болон түргэн эдэлгээтэй хэрэглээний бүтээгдэхүүний

[11] *Бусад үйлчилгээний салбарын өсөлтийн дийлэнх хэсгийг санхүү, даатгалын үйл ажиллагаа бүрдүүлдэг.*

[12] *Хөдөө аж ахуй, эрчим хүч, тээвэр, мэдээлэл холбоо, бусад үйлчилгээний салбаруудыг хамруулсан.*

[13] *Нийт хэрэглээний зээлд хэрэглээ, цалин, тэтгэврийн зээлүүдийг хамруулсан.*

импорт тайлант улиралд 21.2 хувиар тэлжээ. 2017 оны эхний улирлын байдлаар өрхийн хэрэглээний зээл нийт зээлийн багцын 20.9 хувь, нийт чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн 4.7 хувийг тус тус эзэлж байв.

МӨНГӨ САНХҮҮГИЙН СЕКТОР

М2 мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт 2017 оны 5 дугаар сарын байдлаар 21.5 хувиар өсч 12.9 их наяд төгрөгт хүрлээ. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн 14.9 нэгж хувийг бусад хадгаламжийн өсөлт, 6.6 нэгж хувийг М1 мөнгөний өсөлт бүрдүүлж байна.

Дүрслэл 1.38

М2 мөнгөний бүтэц (жилийн өсөлтийн хувь)



Эх сурвалж: Монголбанк.
Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2017 оны 5 дугаар сарын статистик болно.

М1 мөнгө өмнөх оны мөн үетэй харьцуулахад 40.3 хувиар буюу 703.3 тэрбум төгрөгөөр өсч, мөнгөний нийлүүлэлтийн 18.9 хувь буюу 2.4 их наяд төгрөгтэй тэнцэж байна. М1 мөнгийг бүрдүүлж буй төгрөгийн харилцах өмнөх оны мөн үеэс 591.9 тэрбум төгрөгөөр, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 111.5 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Бусад хадгаламж өмнөх оны мөн үеэс 17.8 хувиар буюу 1.6 их наяд төгрөгөөр нэмэгдэж, мөнгөний нийлүүлэлтийн 81.1 хувь буюу 10.5 их наяд төгрөгтэй тэнцэж байна. Энэхүү бусад хадгаламжийн жилийн өсөлтийн 0.6 нэгж хувийг валютын хадгаламж, 3.0 нэгж хувийг валютын харилцах, 14.2 нэгж хувийг төгрөгийн хадгаламжийн өсөлт тус тус бүрдүүлэв.

Дүрслэл 1.39

М2 мөнгөний жилийн өсөлтийн задаргаа, улирлаар



Эх сурвалж: Монголбанк.
Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2017 оны 5 дугаар сарын статистик болно.

М2 мөнгийг байршуулалт талаас нь харвал 2017 оны 5 дугаар сарын байдлаар дотоод цэвэр зээлийн өсөлт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 48.6 хувьтай байгаа бөгөөд энэ нь нийт мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн 53.3 нэгж хувийг бүрдүүлж байна. Түүнчлэн М2 мөнгөний өсөлтийн 24.0 нэгж хувийг Засгийн газрын зээл, 4.6 нэгж хувийг хувийн байгууллагуудын зээл, 17.4 нэгж хувийг бусад санхүүгийн байгууллагуудын зээлийн өсөлт тус тус бүрдүүлж байна.

Төлбөрийн тэнцлийн хүндрэлээс шалтгаалан Монгол Улсын гадаад цэвэр актив (ГЦА) 2013 оноос хойш буурсаар 2017 оны 5 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 65.61 хувиар буурч -4.5 их наяд төгрөгт хүрлээ. Энэ нь мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн -16.6 нэгж хувийг бүрдүүлэн сөргөөр нөлөөлжээ.

Дүрслэл 1.40

Мөнгөний үзүүлэлтүүдийн ерөнхий бүтэц хандлага (тэрбум төгрөг)



Эх сурвалж: Монголбанк.

Гадаад валютын харилцах, хадгаламжийн үлдэгдэл тайлант хугацаанд өмнөх оны мөн үеэс 9.6 хувиар өссөн хэдий ч төгрөгийн нийлүүлэлт үүнээс харьцангуй өндөр буюу 26.9 хувьтай байгаа тул М2 мөнгөнд эзлэх гадаад валютын харилцах, хадгаламжийн хувь буурч байна. Тухайлбал, 2016 оны эцсийн байдлаар уг харьцаа 34.9 хувь байсан бол 2017 оны 5 дугаар сарын байдлаар 28.3 хувь болж буурав.

Мөнгөний үржүүлэгч[14] сүүлийн 4 жилийн дунджаар 3.6 нэгж байгаа бөгөөд 2017 оны 5 дугаар сарын байдлаар 4.3 нэгжтэй тэнцүү байна.

Дүрслэл 1.41

Мөнгөний нийлүүлэлт болон мөнгөний үржүүлэгч



Эх сурвалж: Монголбанк.
Тэмдэглэл: *Хамгийн сүүлийн утга нь 2017 оны 5 дугаар сарын статистик болно.

Макро эдийн засгийн суурийг бэхжүүлэх, төрөгийн ханшийг хамгаалах, эдийн засгийн дунд хугацааны тогтвортой байдлыг хангах зорилгоор Монголбанк 2016 оны 12 дугаар сард мөнгөний бодлогын хүүг 1.0 нэгж хувиар бууруулан 14.0 хувь болгож, 2017 оны 3 дугаар сард энэ түвшинд хэвээр хадгалах шийдвэр гаргасан. Инфляци 2017 оны 5 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд жилийн 3.7 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд жилийн 3.8 хувьд хүрч, дунд хугацаанд Төв банкны зорилтот түвшиний орчимд тогтворжих хүлээлттэй, макро эдийн засгийн зарим үзүүлэлтүүдэд эерэг хандлага ажиглагдаж эдийн засагт богино хугацааны эрсдэл буурсан тул уул уурхайгаас хамаарал багатай салбаруудын өсөлтийг дэмжих зорилгоор мөнгөний бодлогыг зөөлрүүлэх шийдвэрийг Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл 2017 оны 6 дугаар сарын 15-ны өдөр гаргаж, мөнгөний бодлогын хүүг 2 нэгж хувиар бууруулан 12.0 хувьд хүргэлээ. Түүнчлэн бодлогын хүүний корридорыг бодлогын хүүнээс +2, -2 нэгж хувийн өргөнөөр тэгш хэмтэйгээр шинэчлэн тогтоов.

Дүрслэл 1.42

Банкуудын хадгаламж болон зээлийн хүү



Эх сурвалж: Монголбанк.
Тэмдэглэл: *Ипотекийн зээлийн хүүг оруулж тооцсон. Хамгийн сүүлийн утга нь 2017 оны 5 дугаар сарын статистик болно.

Банкуудын төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү[15] 2017 оны 5 дугаар сарын байдлаар өнгөрсөн оны мөн үеэс 2.6 нэгж хувиар нэмэгдэж жилийн 19.8 хувьд хүрэв. Харин хадгаламжийн жигнэсэн дундаж хүү

[14] *М2 мөнгө болон нөөц мөнгөний харьцаагаар тодорхойлогдоно.*

[15] *Банкуудын зээлийн жигнэсэн дундаж хүү нь Монголбанкны хөтөлбөрийн (ҮТХ) зээлийг оруулан тооцсон хүү болно. Харин хөтөлбөрийн зээлийг хасч тооцвол төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 2017 оны 5 дугаар сарын байдлаар 19.8 хувь байна.*

өмнөх оны мөн үеэс 0.4 нэгж хувиар буурч 12.8 хувьд хүрээд байна. Зээл, хадгаламжийн хүүний зөрүү 6.97 хувьтай тэнцэж байна.

Банк хоорондын зах дээрх богино хугацаат хэлцлийн хүүнүүд "Хүүний коридор" нэвтрүүлснээс хойш буюу 2013 оноос хойшхи хугацаанд бодлогын хүүнээс +/-2 хувийн дотор буюу хүүний коридор дотор хэлбэлзэж байна. (Хүүний коридор гэдэг нь банк хоорондын захын хүүний хэлбэлзэх муж бөгөөд зөвхөн хүүг төдийгүй түүний хэлбэлзэх мужийг тодорхойлдог орчин үеийн төв банкны арга хэрэгсэл юм.)

Дүрслэл 1.43

Банк хоорондын захын хүү



Эх сурвалж: Монголбанк.
Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2017 оны 5 дугаар сарын статистик болно.

Банк хоорондын захын хүүгийн хэлбэлзлийг авч үзвэл уг үзүүлэлт 2013-2016 онд 2.1-4.3 хувийн хооронд хэлбэлзэж байсан бол 2016 онд Төв банкны бодлогын хүү 4.5 хувиар нэмэгдсэнтэй холбоотойгоор 5.7 хувиар нэмэгдэж байв. Харин 2017 оны эхний 5 сарын байдлаар хүүгийн түвшний хэлбэлзэл харьцангуй тогтвортой байна.

Дүрслэл 1.44

Банк хоорондын захын хүүний хэлбэлзэх интервал*



Эх сурвалж: Монголбанк.
Тэмдэглэл: *Хүүний жил бүр хэлбэлзэх интервалыг тухайн Жилийн хамгийн их утгаас хамгийн бага утгыг хасч тооцов.

УЛСЫН ТӨСӨВ

Нэгдсэн төсвийн орлогын урьдчилсан гүйцэтгэл

2017 оны 5 дугаар сарын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 2,666.6 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 3.1 хувиар буюу 80.3 тэрбум төгрөгөөр давж, өмнөх оны мөн үеийнхээс 27.9 хувиар буюу 581.5 тэрбум төгрөгөөр илүү байна.

Хүснэгт 1.7

Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөө ба урьдчилсан гүйцэтгэл (тэрбум төгрөг)

Нэгдсэн төсвийн орлого	Жилийн төлөвлөгөө	2017 оны 5-р сар		
		*	**	**/*
Нийт орлого ба тусламжийн дүн	**6 506**	**2 823**	**2 913**	**103.2%**
Тогтворжуулалтын сан	**209**	**83**	**81**	**97.5%**
Ирээдүйн өв сан	**267**	**153**	**165**	**107.7%**
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	**6 030**	**2 586**	**2 667**	**103.1%**
I. Татварын орлого	**4 995**	**2 115**	**2 302**	**108.9%**
1. Орлогын албан татвар	1 044	562	614	109.3%
1.1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	495	368	399	108.5%
1.2. Хүн амын орлогын албан татвар	549	194	215	110.9%
2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	1 189	427	496	116.1%
3. Хөрөнгийн албан татвар	106	51	52	100.5%
4. Нэмэгдсэн өртгийн албан татвар	1 285	493	563	114.2%
5. Онцгой албан татвар	491	217	169	77.7%
6. Тусгай зориулалтын орлого	12	4	5	135.0%
7. Гадаад үйл ажиллагааны орлого	414	152	166	109.3%
8. Бусад татвар, төлбөр, хураамж	454	210	239	113.8%
II. Татварын бус орлого	**1 035**	**472**	**365**	**77.3%**
1. Нийтлэг татварын бус орлого	879	401	353	88.0%
2. Хөрөнгийн орлого	1	0	0	226.5%
3. Тусламжийн орлого	156	71	12	16.5%

Эх сурвалж: Сангийн яам.
Тэмдэглэл: *Төлөвлөгөө,
**Урьдчилсан гүйцэтгэл.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого төлөвлөгөөнөөс 3.1 хувиар буюу 80.3 тэрбум төгрөгөөр давахад ААН-ийн орлогын албан татвар 31.2 тэрбум төгрөг, хувь хүний орлогын албан татвар 21.1 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын шимтгэл 68.8 тэрбум төгрөг, НӨАТ 70.1 тэрбум төгрөг, бусад татвар, төлбөр, хураамжийн орлого 29.0 тэрбум төгрөгөөр төлөвлөгөөнөөсөө давсан нь эерэгээр нөлөөлсөн бол онцгой албан татвар 48.4 тэрбум төгрөг, татварын бус орлого 107.1 тэрбум төгрөгөөр тасарсан нь сөргөөр нөлөөлжээ.

Хүснэгт 1.8

2017 оны 5 дугаар сарын нэгдсэн төсвийн орлогын урьдчилсан гүйцэтгэл, үндсэн бүрэлдэхүүнээр (тэрбум төгрөг)

Төсвийн орлого	УТ*	ОНТ*	НДС*
Нийт орлого ба тусламжийн дүн	**2 134**	**973**	**819**
Тогтворжуулалтын сан	**81**	**0**	**0**
Тогтворжуулалтын сан	**165**	**0**	**0**
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	**1 888**	**973**	**819**
I. Татварын орлого	*1 451*	*355*	*574*
1. Орлогын албан татвар	399	215	0
1.1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	399	0	0
1.2. Хүн амын орлогын албан татвар	0	215	0
1.3. Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн татвар	0	0	0
2. Нийгмийн даатгалын шимтгэл хураамж	0	0	574
3. Хөрөнгийн албан татвар	0	52	0
4. Нэмэгдсэн өртгийн албан татвар	563	0	0
5. Онцгой албан татвар	169	0	0
6. Тусгай үйл ажиллагааны орлого	5	0	0
5. Гадаад худалдааны орлого	166	0	0
6. Бусад татвар	150	89	0
II. Татварын бус орлого	*437*	*618*	*245*

Эх сурвалж: Сангийн яам.
Тэмдэглэл: *УТ- Улсын төсөв, ОНТ- Орон нутгийн төсөв, НДС- Нийгмийн даатгалын сан.

Улсын төсөв

Улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 1,888.2 тэрбум төгрөгт хүрч 98.6 хувиар буюу 27.0 тэрбум төгрөгөөр төлөвлөгөөнөөс дутуу төвлөрсөн байна. Автобензин, дизелийн түлшний онцгой албан татварын орлого 57.0 тэрбум, төсөвт байгууллагын өөрийн орлого 35.1 тэрбум, тусламжийн орлого 61.9 төгрөгөөр тус тус төлөвлөгөөнөөс дутсан нь голлон нөлөөлсөн байна. НӨАТ-ын буцаан олголтоор 59.9 тэрбум төгрөг олгосон байна.

Орон нутгийн төсөв

Орон нутгийн төсвийн орлого 972.9 тэрбум төгрөгт хүрч 2.3 хувиар буюу 21.5 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс илүү төвлөрсөн байна. Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлтийг зарим аймгуудаар дэлгэрүүлбэл, Нийслэлийн үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын орлого 1.3 тэрбум, улсын тэмдэгтийн хураамжийн орлого 11.3 тэрбум, газрын төлбөрийн орлого 3.4 тэрбум, хүү торгуулийн орлого 2.6 тэрбум төгрөгөөр тус тус давж, хувь хүний

орлогын албан татварын буцаан олголтыг 10.7 тэрбум төгрөгөөр дутуу олгосон нь нийслэлийн орлого 16.3 тэрбум төгрөгөөр төлөвлөгөөнөөс давахад голлон нөлөөлсөн байна. Орхон аймгийн ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого 0.3 тэрбум, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын орлого 0.2 тэрбум, шууд бус орлого 0.1 тэрбум, бусад орлого 0.2 тэрбум төгрөгөөр тус тус давж, хувь хүний орлогын албан татварын буцаан олголтыг 0.3 тэрбум төгрөгөөр дутуу олгосон нь тус аймгийн орлого төлөвлөгөөнөөс 0.5 тэрбум төгрөгөөр давахад голлон нөлөөлсөн байна. Өмнөговь аймгийн үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын орлого 1.6 тэрбум, торгуулийн орлого 0.2 тэрбум, төсөвт байгууллагуудын орлого 0.4 тэрбум, тусламжийн орлого 1.9 тэрбум төгрөгөөр тус тус давж, хувь хүний орлогын албан татварын буцаан олголтыг 0.3 тэрбум төгрөгөөр дутуу олгосон нь тус аймгийн орлого төлөвлөгөөнөөс 4.5 тэрбум төгрөгөөр давахад голлон нөлөөлсөн байна.

Нийгмийн даатгалын сангийн орлого

Нийгмийн даатгалын санд 818.9 тэрбум төгрөг төвлөрсөн нь төлөвлөгөөнөөс 7.0 хувиар буюу 53.8 тэрбум төгрөгөөр илүү байна. Тус санд улсын төсвөөс 244.7 тэрбум төгрөгийн татаас олгосон байна.

Төсвийн зарлагын гүйцэтгэл

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага 2017 оны 5 дугаар сарын байдлаар 3,918.2 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 3,079.1 тэрбум төгрөгийн буюу 78.6 хувийн, улсын төсвийн зарлага 2,996.1 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 2,500.5 тэрбум төгрөгийн буюу 83.5 хувийн гүйцэтгэлтэй гарлаа.

Хүснэгт 1.9

Нэгдсэн төсвийн зарлагын төлөвлөгөө ба гүйцэтгэл (тэрбум төгрөг)

Нэгдсэн төсвийн зарлага	Жилийн төлөвлөгөө	2017 оны 5-р сар		
		*	**	**/*
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	**9 112**	**3 918**	**3 079**	**79%**
Урсгал зардал	7 143	3 116	2 641	85%
1. Бараа, үйлчилгээний зардал	*3 219*	*1 454*	*1 165*	*80%*
1.1. Цалин хөлс	1 792	757	721	95%
1.2. Нийгмийн даатгал	165	69	65	93%
1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал	1 263	627	379	60%
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	*1 203*	*439*	*390*	*89%*
3. Татаас	*273*	*138*	*105*	*76%*
4. Урсгал шилжүүлэг	*2 447*	*1 085*	*981*	*90%*
Хөрөнгийн зардал	1 647	630	310	49%
1. Дотоод эх үүсвэрээр:	*1 647*	*630*	*310*	*49%*
Эргэж төлөгдөх цэвэр зээл	321	172	128	74%
Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл	**-3 082**	**-1 332**	**- 413**	**31%**

Эх сурвалж: Сангийн яам.
Тэмдэглэл: *Төлөвлөгөө,
**Урьдчилсан гүйцэтгэл.

Үүнээс урсгал зардал 474.6 тэрбум төгрөг, хөрөнгийн зардал 320.5 тэрбум төгрөгөөр тус тус дутуу гүйцэтгэлтэй гарчээ. Урсгал зардлын бараа үйлчилгээний зардлын бүрэлдэхүүнд багтах цалин хөлс 36.2 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын зардал 4.6 тэрбум төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 247.9 тэрбум төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй байна. Бараа үйлчилгээний бусад зардлын дэлгэрэнгүй ангиллыг авч үзвэл бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 119.4 тэрбум, бараа үйлчилгээний бусад зардал 60 тэрбум төгрөг, норматив зардал 31.7 тэрбум төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй байгаа нь дийлэнх хувийг эзэлж байна.

Бусад голлох зардлагын хувьд зээлийн үйлчилгээний төлбөр 48.1 тэрбум төгрөг, татаас 33.0 тэрбум төгрөг, урсгал шилжүүлэг 72.2 тэрбум төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй байна.

Халамжийн сангийн зарлага

Улсын төсвийн халамжийн сангаас ахмад дайчин, алдар цолтой ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламжийн зардал 2.1 тэрбум, алдарт эхийн одонтой эхчүүдэд олгох тэтгэмжийн зардал 28.6 тэрбум, хүүхдэд олгох мөнгөн тэтгэмжийн зардал 63.5 тэрбум, насны хишгийн зардалд 10.0 тэрбум, засгийн газрын нөөц хөрөнгийн зардал 5.3 тэрбум, хөрөнгийн зардал 273.7 тэрбум төгрөгийн тус тус гүйцэтгэлтэй байна. Улсын төсвөөс орон нутагт 66.2 тэрбум төгрөгийн санхүүгийн

дэмжлэг, 25.6 тэрбум төгрөгийн орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлэг, 487.4 тэрбум төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлгийг тус тус олгосон байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлага

Нийгмийн даатгалын сангийн төлөвлөгдсөн зардал 95.8 хувийн буюу 756.7 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Тус сангаас улсын эмнэлгүүдэд 73.4 тэрбум төгрөгийн татаасыг олгосон байна.

Дүрслэл 1.45

Нэгдсэн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн жилийн өөрчлөлт



Эх сурвалж: Сангийн яам.
Тэмдэглэл: *-2017 оны 5 дугаар сраын орлого, зарлагын урьдчилсан гүйцэтгэлийн жилийн өөрчлөлт болно.

Төсвийн тэнцэл

2017 оны эхний 5 сарын байдлаар Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт тэнцэл 412.5 тэрбум, улсын төсвийн нийт тэнцэл 612.3 тэрбум төгрөгийн тус тус алдагдалтай гарлаа. Эдгээр алдагдал нь эхний 5 сарын төлөвлөсөн дүнгийн 31.0, 56.6 хувийг тус тус харгалзан эзэлж байна.

Дүрслэл 1.46

Нэгдсэн төсвийн тэнцлийн гүйцэтгэл (жил бүрийн 5 сарын байдлаар, тэрбум төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам.

Тайлант хугацаанд гадаад төслийн зээлийн үндсэн төлбөрт 62.8 тэрбум, Засгийн газрын урт хугацаат дотоод бонд, векселийн үндсэн төлбөрт 2525.7 тэрбум төгрөгийг тус тус төлж, 271.3 тэрбум төгрөгийн гадаад төслийн зээл авч, Засгийн газрын 459.9 тэрбум төгрөгийн урт хугацаат дотоод, 856.3 тэрбум төгрөгийн богино хугацаат дотоод, 1498.2 тэрбум төгрөгийн урт хугацаат гадаад бондыг тус тус арилжаалсан гүйцэтгэлтэй байна.

2017 он гарсаар Монголбанкаар дамжин хийгддэг Засгийн газрын богино хугацаат бондын анхдагч зах зээлийн 25 удаагийн арилжаагаар нийт 1857.0 тэрбум төгрөгийн бонд арилжаалахаар зарласан ба биелсэн саналын хэмжээ уг дүнгийн 90 хувь буюу 1675.5 тэрбум төгрөгт хүрэв. Харин урт хугацаат бондын хувьд 27.8 тэрбум төгрөгийн бонд арилжаалагджээ.

Манай улсын хувьд төсвийн алдагдлыг Засгийн газрын бонд, зээлээр санхүүжүүлж ирсэн бөгөөд ялангуяа бондын санхүүжилт төсвийн алдагдлын дийлэнх хувийг санхүүжүүлдэг. Шинээр гаргасан Засгийн газрын бонд, зээлийн багагүй хэсгийг үндсэн төлбөрт төлж байгаа нь Засгийн газар шинэ өр үүсгэх замаар хуучин өр төлбөрөө төлж буйг харуулж байна. Тухайлбал, 2013-2015 онуудад Засгийн газрын шинээр авсан зээл, шинээр гаргасан бондын дунджаар 55.3 хувийг зээл, бондын үндсэн төлбөрт төлж байсан бол 2017 оны эхний 5 сарын төсвийн урьдчилсан гүйцэтгэлээр уг үзүүлэлт дээрх дундаж үзүүлэлттэй ойролцоо буюу 56.6 хувьтай байна.

Дүрслэл 1.47

Засгийн газрын богино ба урт хугацаат бондын арилжаа



Эх сурвалж: Монголбанк.
Тэмдэглэл: Улаан цэгүүдээр Засгийн газрын бондыг арилжаалахаар зарласан боловч худалдан авах санал ирээгүй өдрүүдийг тэмдэглэв.

Төсвийн алдагдлыг зардал өндөртэй бондоор буюу өрийг өрөөр санхүүжүүлэх нь засгийн газрын өрийн тогтвортой байдлыг цаашид алдагдуулах эрсдэлтэй юм.

Дүрслэл 1.48

Засгийн газрын бонд ба зээл (шинээр гаргах, үндсэн төлбөр)



Эх сурвалж: Сангийн яам.
Тэмдэглэл: *2017 оны 5 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэл

Шигтгээ 2: Засгийн газрын гадаад өрийн эрсдэлүүд

Засгийн газрын нийт өрийн үлдэгдэл 2017 оны 1 дүгээр улирлын эцэст 20970.6 тэрбум төгрөгт хүрсэн ба үүнээс гадаад өр 13951.5 тэрбум төгрөг буюу 66.5 хувь, дотоод өр 5148.4 тэрбум төгрөг буюу 24.6 хувь, Засгийн газрын баталгаатай зээллэг 1870.7 тэрбум төгрөг буюу 8.9 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 1.10

Засгийн газрын өрийн бүтэц, өрийн хэрэгслээр

Үзүүлэлт	2015.12.31	2016.12.31	2017.03.31
I. Засгийн газрын дотоод өр	3 800	6 465	5 148
1.1 Үнэт цаас	3 333	5 489	4 438
1.2 Зээл	0	0	0
1.3 Өрийн бичиг/вексель	164	307	4
1.4 Концесс	261	669	706
1.5 Татварын урьдчилгаа	41	0	0
II. Засгийн газрын гадаад өр	7 881	12 364	13 952
2.1 Үнэт цаас	3 316	5 381	6 772
2.2 Зээл	4 565	6 983	7 180
III. Засгийн газрын өрийн баталгаатай зээллэг	2 744	3 452	1 871
3.1 Засгийн газрын өрийн баталгаа	2 744	3 452	1 871
Засгийн газрын нийт өр (I+II+III)	**14 425**	**22 280**	**20 971**

Засгийн газрын нийт өрийг бүтцээр нь авч үзвэл гадаад өрийн хувьд Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл 7179.7 тэрбум төгрөг буюу 2927.6 сая ам.доллар, нийт өрийн багцын 34.2 хувийг эзэлж байгаа бол гадаад үнэт цаасны үлдэгдэл 6771.8 тэрбум төгрөг буюу 2761.2 сая

ам.доллар, нийт өрийн багцын 32.3 хувийг эзэлж байна. Харин Засгийн газрын баталгаатай зээллэгийн үлдэгдэл 1870.7 тэрбум төгрөг буюу нийт өрийн багцын 8.9 хувийг эзэлж байна.

Засгийн газрын гадаад үнэт цаасны үлдэгдэл 2016 оны эцэст 5380.5 тэрбум төгрөг байсан бол 2017 оны 3 дугаар сарын 9-нд Засгийн газрын баталгаатай Хөгжлийн банкны 580.0 сая ам.долларын евробондыг дахин санхүүжүүлэх зориулалтаар 1498.5 тэрбум төгрөгийн (600 сая ам.долларын, 2024 онд төлөгдөх хуваарьтай, 8.75 хувийн хүүтэй, Хуралдай бонд) гадаад үнэт цаас гаргаж, 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар олон улсын зах зээлд нийт гаргасан Засгийн газрын үнэт цаасны үлдэгдэл 2761.2 сая ам.доллар буюу 6771.8 тэрбум төгрөг болж, хүүгийн төлбөрт 2017 оны эхний улирлын байдлаар нийт 36.0 тэрбум төгрөгийг төлөөд байна.

Засгийн газрын гадаад өрийн эрсдэлүүд

Засгийн газрын гадаад өрийн эргэн төлөлттэй холбоотой дараах эрсдэлүүд тулгарч байна. Үүнд:

- **Гадаад валютын ханшийн эрсдэл.** Засгийн газрын гадаад өр болон Засгийн газрын баталгааны үлдэгдэл нийт өрийн багцын 75.4 хувийг эзэлж байгаа нь гадаад валютын ханшийн эрсдэлийг энэ хэмжээгээр нэмэгдүүлж, гадаад валютын ханшийн өсөлтөөс үүдэн төгрөгөөр илэрхийлсэн гадаад өрийн үлдэгдэл өсөх, гадаад өрийн үйлчилгээний зардлыг нэмэгдүүлж болзошгүй байна. Тухайлбал гадаад валютын ханшийн өөрчлөлтөөс үүдэн төгрөгөөр илэрхийлсэн Засгийн газрын гадаад өр болон Засгийн газрын баталгаатай гадаад зээллэгийн үлдэгдэл 2015 оны жилийн эцсийн үлдэгдэлтэй харьцуулахад 2016 оны эцэст 2992.6 тэрбум төгрөг буюу 18.9 орчим хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 1.11

Гадаад өрийн үлдэгдэл валютын бүтцээр /тэрбум төгрөг/

Засгийн газрын өрийн үлдэгдэл валютын бүтцээр		Валют	2017.03.31	Хувь
1. Засгийн газрын гадаад өр			**13 952**	**66.5%**
1.1 **Үнэт цаас**			**6 772**	**32.3%**
1.1.1	АНУ-ын доллар	USD	6 772	32.3%
1.2 **Зээл**			**7 180**	**34.2%**
1.2.1	АНУ-ын доллар	USD	2 206	10.5%
1.2.2	Евро	EUR	436	2.1%
1.2.3	Японы иен	JPY	1 757	8.4%
1.2.4	Швейцарийн франк	CHF	0	0.0%
1.2.5	Шведийн крон	SEK	0	0.0%
1.2.6	БНСУ-ын вон	KRW	179	0.9%
1.2.7	БНХАУ-ын юань	CNY	0	0.0%
1.2.8	АНЭУ-ын дирхам	AED	13	0.1%
1.2.9	Кувейтын динар	KWD	93	0.4%
1.2.10	Зээлжих тусгай эрх	SDR	2 497	11.9%
2. Засгийн газрын өрийн баталгаа			**1 871**	**8.9%**
2.1 **Өрийн баталгаа**			**1 871**	**8.9%**
2.1.1	АНУ-ын доллар	USD	1 208	5.8%
2.1.2	Евро	EUR	0	0.0%
2.1.3	Японы иен	JPY	662	3.2%
2.1.4	Төгрөг	MNT	0	0.0%

Эх сурвалж: Сангийн яам.
Тэмдэглэл: *Төлөвлөгөө,
**Урьдчилсан гүйцэтгэл.

- **Өрийн дахин санхүүжилтийн эрсдэл.** Засгийн газрын зүгээс 2018 онд эргэн төлөгдөх хуваарьтай Чингис бондын 500.0 сая ам.доллар, Дим сам бондын 161.2 сая ам.долларын төлбөрийг гадаад валютын ханшид огцом нөлөөлөлгүйгээр, зах зээл болон хөрөнгө оруулагчдад ээлтэй хэлбэрээр дахин санхүүжүүлэх шаардлага тулгарч байна. Төлбөрийн хугацаа дөхөх тусам олон нийтэд тарж буй эрэг сөрөг мэдээллээс үүдэн гадаад үнэт цааснуудын хоёрдогч зах зээлд арилжаалагдаж буй үнэ болон өгөөжид огцом хэлбэлзэл үүсч, дахин санхүүжилтийн эрсдэл, зээллэгийн хүүгийн түвшний эрсдэлүүд тулгарч болзошгүй байна.

САНХҮҮГИЙН САЛБАР, ТҮҮНИЙ ДАРХЛАА 2

2.1 БАНКНЫ САЛБАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

БАНКНЫ САЛБАР

Ерөнхий төлөв байдал

Банкны салбарт 2017 оны 5 дугаар сарын байдлаар нийт 14 банк 1494 салбар нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Нийт харилцагчдын тоо 8.8 сая, зээлдэгчдийн тоо 866.8 мянгад хүрлээ[16].

Дүрслэл 2.1

Банкны салбарын активын бүтэц (жил бүрийн 5 сарын байдлаар)



Эх сурвалж: Монголбанк.

Банкны салбарын нийт активын хэмжээ 2017 оны 5 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 3.5 их наяд төгрөгөөр өсч 25.7 их наяд төгрөгт хүрлээ. Нийт активын бүтцийг авч үзвэл 48.3 хувь нь зээл, 10.3 хувь нь банкны нөөц, 12.4 хувь нь Засгийн газрын үнэт цаас, 4.9 хувь нь Төв банкны үнэт цаас, үлдэх 24.1 хувь нь бусад хөрөнгө байна.

Банкны салбарын активын бүтцийн гол өөрчлөлтүүдийг харвал нийт активт эзлэх зээлийн хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 1.9 нэгж хувиар буурсан бол, Төв банкны болон Засгийн газрын үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ 5.4 нэгж хувиар өсчээ.

Дүрслэл 2.2

Банкны салбарын пассивын бүтэц (жил бүрийн 5 сарын байдлаар)



Эх сурвалж: Монголбанк.

Банкны салбарын нийт эх үүсвэрийн хэмжээ 2017 оны 5 дугаар сарын эцэст өмнөх оны мөн үеэс 14.4 хувиар өсч, 22.4 их наяд төгрөг байна. Эх үүсвэрийн өсөлтөд банкуудын бусдаас татан төвлөрүүлсэн харилцахын хэмжээ 859.3 тэрбум төгрөгөөр, хадгаламжийн хэмжээ 1.3 их наяд төгрөгөөр, гадаад пассивын хэмжээ 1.0 их наяд төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлжээ.

[16] *Давхардсан тоогоор.*

Дүрслэл 2.3

Банкны салбарын актив, пассивт гарсан өөрчлөлт (2016.05-2017.05)



Эх сурвалж: Монголбанк.

Дүрслэл 2.4

Банкны салбарын эх үүсвэрийн жилийн өсөлт



Эх сурвалж: Монголбанк.

Эх үүсвэр

Банкны салбарын нийт эх үүсвэрийн 54.7 хувийг иргэд аж ахуй нэгж, төрийн байгууллагуудаас татсан харилцах, хадгаламж бүрдүүлж байна.

Эх үүсвэрийн бүтцийн өөрчлөлтөөс харахад нийт эх үүсвэрт эзлэх хадгаламжийн хэмжээ тогтвортой өсч байна. Харин харилцахын дүн эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан өмнөх жилүүдэд тасралтгүй буурсан хэдий ч, 2016 оны 4 дүгээр сараас эхлэн өсч, 2017 оны 5 дугаар сарын байдлаар нийт эх үүсвэрийн 14.4 хувийг бүрдүүлж байна.

Банкны салбарын нийт харилцах, хадгаламжийн 70.1 хувийг төгрөгийн, 29.9 хувийг валютын харилцах, хадгаламж бүрдүүлж байна. Гадаад валютын харилцах, хадгаламжийн нийт харилцах, хадгаламжид эзлэх хувийн жин оны эхнээс 6.9 нэгж хувиар буурчээ.

Банкуудын эх үүсвэр өссөн хэвээр байна. Монголбанкнаас мөнгөний уламжлалт бус бодлогын хүрээнд хэрэгжүүлсэн хөтөлбөрийн санхүүжилт болон харилцах хадгаламжийн тогтвортой өсөлттэй холбоотойгоор эх үүсвэрийн хэмжээ 2013 онд өсч байсан хэдий ч 2014 оноос хойш өсөлтийн хурд эргэн буурч, 2015 оны 1 дүгээр сард сөрөг утгатай болсон.

Харин 2017 оны 5 дугаар сарын байдлаар нийт пассивын жилийн өсөлт 14.2 хувь байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 10.8 нэгж хувиар өссөн дүнтэй байна.

Зээл

Банкны салбарын зээлийн өсөлт сүүлийн 11 сар дараалан эерэг гарав. Санхүүгийн салбарын зээлийн багцын дийлэнх хувийг бүрдүүлдэг банкны салбарын зээлийн өсөлт эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн, санхүүгийн зах зээлийн нөхцөл чангарсан, эдийн засгийн идэвхжил удааширснаар банкууд шинээр зээл олгох нь эрсдэлтэй гэж үзэн зээлээ хумьсан зэргээс шалтгаалан 2014 оны 2 дугаар сараас тасралтгүй буурч эхэлсэн.

Дүрслэл 2.5

Банкны салбарын актив, зээлийн жилийн өсөлт



Эх сурвалж: Монголбанк.

Улмаар 2015 оны 5 дугаар сараас 2016 оны 6 дугаар сар хүртэлх хугацаанд банкны салбарын зээлийн жилийн өөрчлөлт сөрөг утгатай байсан бол 2016 оны 6 дугаар сараас эхлэн өсч, 2017 оны 5 дугаар сарын байдлаар 10.9 хувьд хүрээд байна.

Дүрслэл 2.6

Олгосон зээлийн жилийн өсөлт (салбараар)



Эх сурвалж: Монголбанк.

Нийт зээлийг салбарын ангиллаар авч үзвэл үл хөдлөх хөрөнгө болон барилгын салбарт олгосон зээл өмнөх оны мөн үеэс буурсан бол бөөний болон жижиглэн худалдаа, уул уурхай олборлолт, боловсруулах үйлдвэрлэл болон бусад салбарт олгосон зээл өсжээ.

Зээлийн төвлөрлийн хэмжээ өндөр хэвээр байна. Банкны системийн хэмжээнд зээлийн төвлөрлийн эрсдэлд орох магадлал өндөр байгаа бөгөөд үүний шалтгаан нь манай орны эдийн засаг төрөлжилт багатай, цөөн тооны салбараас өндөр хамааралтай байгаатай холбоотой юм.

Дүрслэл 2.7

Салбаруудын зээлийн төвлөрөл



Голлох салбаруудаа	Зээлийн өрийн үлдэгдэл (2017Q1)	Оны эхнээс гарсан өөрчлөлт
Бөөний/жижиглэн худалдаа	14.4%	0.3%
Үл хөдлөх хөрөнгө	15.7%	-0.3%
Барилга	9.6%	-1.3%
Уул уурхай, олборлолт	6.0%	-0.1%
Боловсруулах үйлдвэрлэл	10.6%	0.1%
Бусад	43.7%	1.2%

Эх сурвалж: Монголбанк.
Тэмдэглэл: *Зээлийн багцад хамгийн өндөр жин эзэлж буй 4 салбарын зээлийн нийт дүнд эзлэх хувь.

2017 оны эхний улирлын байдлаар банкны салбарын нийт зээлийн өрийн үлдэгдлийн 56.3 хувь уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл, барилга, үл хөдлөх хөрөнгө, худалдаа зэрэг 5 салбарт төвлөрч байна. Иймд эдгээр салбаруудад хүндрэл үүсэхэд банкны салбарын зээлийн чанарт үзүүлэх сөрөг нөлөө нь өндөр юм.

Нийт чанаргүй зээлийн хэмжээ 5 дугаар сарын эцсийн байдлаар 1153.8 тэрбум төгрөгт хүрч (нийт зээлийн 9.1 хувь), өмнөх оны мөн үеэс 92.1 тэрбум төгрөгөөр буюу 8.7 хувиар өссөн бол хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 925.3 тэрбум төгрөгт хүрч (нийт зээлийн 7.3 хувь) 4.5 хувиар нэмэгдлээ.

Дүрслэл 2.8

Зээлийн чанарын үзүүлэлт, салбараар



Голлох салбарууд	Тухайн салбарын чанаргүй зээл/Нийт чанаргүй зээл (2017M5)
Уул уурхай, олборлолт	19.6%
Бөөний болон жижиглэн худалдаа	16.1%
Боловсруулах үйлдвэрлэл	23.2%
Барилга	9.0%
Үл хөдлөх хөрөнгө	10.2%
Бусад	21.9%

Эх сурвалж: Монголбанк.

2017 оны 5 дугаар сарын байдлаар уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл, худалдааны салбарын чанаргүй зээлийн харьцаа бусад салбаруудтай харьцуулахад өндөр буюу харгалзан 29.2, 18.5, 10.4 хувь байна.

Банкны салбарын хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн 70.5 хувь нь уул уурхай, бөөний болон жижиглэн худалдаа, боловсруулах үйлдвэрлэл, барилгын салбаруудад төвлөрсөн бөгөөд нийт зээлийн өрийн үлдэгдлийн 41.1 хувийг дээрх 4 салбарт олгосон зээл бүрдүүлж байгаа юм.

2017 оны 5 дугаар сарын эцсийн байдлаар нийт чанаргүй зээлийн 19.6 хувийг уул, уурхайн салбарын чанаргүй зээл, нийт хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн 27.7 хувийг мөн тус салбарын хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл дангаараа бүрдүүлж байна.

Дүрслэл 2.9

Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн жилийн өсөлт



Голлох салбарууд	Нийт чанаргүй зээл ба хугацаа хэтэрсэн зээлд эзлэх хувь
Уул уурхай, олборлолт	28.4%
Бөөний болон жижиглэн худалдаа	17.5%
Боловсруулах үйлдвэрлэл	13.0%
Барилга	11.6%
Үл хөдлөх хөрөнгө	8.0%

Эх сурвалж: Монголбанк.

2017 оны 5 дугаар сарын эцсийн байдлаар төгрөгийн чанаргүй зээлийн нийт төгрөгийн зээлд эзлэх хувь 8.0 хувь байхад валютын чанаргүй зээлийн нийт валютын зээлд эзлэх хувь 13.6 хувь буюу 5.6 нэгж хувиар өндөр байна.

Дүрслэл 2.10

Чанаргүй зээлийн харьцаа (валютын төрлөөр)



Эх сурвалж: Монголбанк.

Өөрийн хөрөнгө

Банкны салбарын өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтүүд тогтвортой байна. Эдийн засгийн нөхцөл байдал хүндрэлтэй, чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ нэмэгдсэн хэдий ч банкны салбарын зохистой харьцааны үзүүлэлтүүд тогтвортой хэвээр байна.

Дүрслэл 2.11

Өөрийн хөрөнгийн үзүүлэлтүүд



Эх сурвалж: Монголбанк.

Банкны системийн эрсдэл даах чадварыг тодорхойлдог өөрийн хөрөнгийн хэмжээ 5 дугаар сарын эцсийн байдлаар 3.1 их наяд төгрөгт хүрч өмнөх оны эцсээс 27.8 хувиар буюу 680.7 тэрбум төгрөгөөр өслөө.

2017 оны тавдугаар сарын байдлаар банкны салбарын өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 18.2 хувь байгаа нь Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж байна.

Ашигт ажиллагаа

Банкны салбарын ашигт ажиллагааны үзүүлэлтүүд сайжрах хандлагатай байна. 2017 оны 5 дугаар сарын байдлаар банкны салбарын нийт ашиг 103.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэтэй харьцуулахад 109.0 тэрбум төгрөгөөр өсчээ.

Үүний үр дүнд банкны салбарын ашигт ажиллагааны үзүүлэлтүүд болох активын болон өөрийн хөрөнгийн өгөөж 1.0 ба 9.0 хувьд хүрч өнгөрсөн оны мөн үеэс харгалзан 1.2 ба 11.0 нэгж хувиар тус тус өсчээ.

Дүрслэл 2.12

Банкны салбарын ашигт ажиллагаа



Эх сурвалж: Монголбанк.

Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар

Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар нь банкны системийн тогтвортой байдлыг илтгэдэг үндсэн үзүүлэлтүүдийн нэг бөгөөд харилцагчийн анхны шаардлагаар төлбөрийг түргэн түргэн гүйцэтгэх чадварыг илэрхийлдэг.

Дүрслэл 2.13

Банкны салбарын төлбөр түргэн гүйцэтгэх чадвар



Эх сурвалж: Монголбанк.

2017 оны 5 дугаар сарын байдлаар банкны системийн хэмжээнд төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 40.3 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 0.5 нэгж хувиар буурсан бөгөөд Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны доод хязгаарлалтаас (25 хувь) 15.3 нэгж хувиар илүү байна. Иймхүү банкны салбарын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа тогтвортой хэвээр хадгалагдахад банкууд татан төвлөрүүлсэн эх үүсвэрээ

харьцангуй эрсдэл багатай төв банкны болон Засгийн газрын богино хугацаат үнэт цаасанд хөрөнгө оруулалт хэлбэрээр байршуулж буй нь голлон нөлөөлж байна.

2017 оны 4 дүгээр сарын байдлаар банкуудын төв банкны болон Засгийн газрын богино хугацаат үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ 2.9 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 252.2 хувиар өсчээ.

Дүрслэл 2.14

Хөрвөх чадварын үзүүлэлт



Эх сурвалж: Монголбанк.
Тэмдэглэл: *(Банкны нөөц+ТБҮЦ)/(Харилцах+Хадгаламж).
**(Банкны нөөц+ТБҮЦ+ЗГ-ын богино хугацаатай үнэт цаас)/(Харилцах+Хадгаламж).

Өрхийн зээл, санхүүгийн үзүүлэлтүүд:

Санхүүгийн тогтвортой байдалд өрхүүдийн эдийн засгийн нөхцөл байдал чухал ач холбогдолтой байдаг. Өрхийн санхүүгийн байдал эрүүл, тогтвортой байх нь банкны салбар төдийгүй нийт системийн хэмжээнд чухал ач холбогдолтой юм. Иймд, өрхийн зээл, санхүүгийн зарим үзүүлэлтүүд, тэдгээрийн банкны салбарын зээлийн үзүүлэлтүүдтэй уялдуулан авч үзье.

Улсын хэмжээнд өрхийн сарын дундаж нэрлэсэн орлого 2017 оны эхний улиралд 4.4 хувиар, бодит орлого[17] 1.9 хувиар тус тус өслөө. Энэ нь 2015 оны 3 дугаар улирлаас хойш анх удаа өссөн үзүүлэлт боллоо.

Өрхийн нэрлэсэн орлогын өсөлтийн 3.0 нэгж хувийг цалин хөлс, 2.4 нэгж хувийг тэтгэвэр, тэтгэмж, нөхөн олговрын орлогын өсөлт тус тус бүрдүүлж байна.

Дүрслэл 2.15

Өрхийн бодит орлогын өсөлт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк.

Өрхийн бодит орлого өсөх нь өрхийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлэн, амьжиргааны түвшинг өсгөх, улмаар зээлийн эргэн төлөлтийн чадавхийг сайжруулах эерэг нөлөөтэй. 2017 оны эхний улиралд өрхийн нэрлэсэн зарлага өмнөх оны мөн үеэс 2.6 хувиар буурчээ.

Дүрслэл 2.16

Өрхийн орлого, зарлагын харьцаа



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Нэг өрхөд ногдох иргэдийн зээл 2017 оны эхний улиралд 6.7 саяд хүрч, өмнөх оны мөн үеэс 16.1 хувиар өсөв.

[17] *Инфляци = 2.5 хувь*

Дүрслэл 2.17

Өрхийн өрийн дарамт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк.
Тэмдэглэл: *Нэг өрхөд ногдох иргэдийн зээлийн өрийн үлдэгдэл; **Нэг өрхөд ногдох иргэдийн зээлийн өрийн үлдэгдэлийг улсын дундаж өрхийн жилийн орлогод харьцуулж тооцов; ***Иргэдийн зээлийн өрийн үлдэгдэл ба нэрлэсэн ДНБ-ий харьцаа (жилийн ДНБ). Хамгийн сүүлийн утга нь 2017 оны I улирлын статистик болно.

Нэг өрхөд ногдох иргэдийн зээл ба өрхийн жилийн дундаж орлогын харьцаагаар өрхийн өрийн дарамтыг төлөөлүүлэн хэмжихэд 2017 оны эхний улиралд өрхийн өрийн дарамт 59.1 хувь байна.

Дүрслэл 2.18

Өрхийн өр, орлогын харьцаа*



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк.
Тэмдэглэл: *Өрхийн дундаж орлогод эзлэх хувь бөгөөд энэхүү харьцааг тооцохдоо өрхийн орлогыг ҮСХ-ноос тооцон гаргадаг улсын өрхийн дундаж сарын орлогыг авч ашигласан болно. Харин орон сууцны зээлийн сарын төлбөрийг гаргахдаа 1 зээлдэгчийн орон сууцны дундаж зээлийн хэмжээ, жигнэсэн дундаж хугацаа, хүүг ашигласан болно.

Нэгж орлогод ногдох орон сууцны ипотекийн зээлийн төлбөрийн хувь хэмжээ буюу өр/орлогын харьцаа 2013 оны 3 дугаар улирал хүртэл буурсаар 38 хувьд хүрч байсан бол 2017 оны эхний улиралд 45.0 хувь болов. Энэхүү харьцаа нь дундаж өрх орлогоороо орон сууцны ипотекийн зээл авсан бол өр, төлбөрийн хувьд ямар дарамттай байхыг илтгэнэ.

Орон сууцны үнэ үргэлжлэн буурсаар байна. Орон сууцны үнийн индексийг Үндэсний статистикийн хороо 2007 оноос, Монголбанкнаас 2013 оноос тус тус тооцож эхэлсэн билээ. 2014 оноос эхлэн орон сууцны үнийн өсөлт саарч эхэлсэн бөгөөд 2017 оны эхний улиралд жилийн 4.8 хувийн бууралттай гарчээ.

Дүрслэл 2.19

Орон сууцны үнэ, ипотекийн зээлдэгчдийн тооны жилийн өөрчлөлт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк.
Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2017 оны 1 дүгээр улирлын статистик болно.

ААН-ийн зээл, санхүүгийн үзүүлэлтүүд:

Хувийн салбарын өрийн дарамтыг аж ахуйн нэгжийн дотоод зээл (арилжааны банкуудаас авсан) ба гадаад өр төлбөрийн ДНБ-д эзлэх хувиар төлөөлүүлэн хэмжиж болно. 2005 оноос хойш гадаад өрийн дарамт хурдтай өссөөр байгаа бөгөөд 2017 оны эхний улиралд хувийн салбарын гадаад өр ДНБ-ий 102.0 хувь буюу өмнөх оны мөн үеэс 51.4 нэгж хувиар огцом өсөөд байна. Үүнд 2016 оны 2 дугаар улиралд томоохон компаниуд хөрөнгө оруулагчаас авсан зээлээ эргэн төлөх зорилгоор олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас зээл авсан болон төгрөгийн ам.доллартай харьцах ханш суларсан нь нөлөөлсөн байна. Харин хувийн салбарын дотоод өр (арилжааны банкуудаас авсан зээл) ДНБ-ий 27.8 хувьд хүрч өсчээ.

Дүрслэл 2.20

Хувийн салбарын өрийн дарамт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк.
Тэмдэглэл: *Аж ахуйн нэгжийн зээлийн өрийн үлдэгдэл ба нэрлэсэн ДНБ-ий харьцаа (жилийн ДНБ);
**Хувийн салбарын гадаад өрийг Монголбанкны гадаад өрийн статистик дахь хадгаламжийн байгууллага болон бусад салбаруудын гадаад өрийн нийлбэр дүнгээр төлөөлүүлэн авсан (нэрлэсэн ДНБ-д эзлэх хувиар).

МАКРО ЗОХИСТОЙ БОДЛОГО, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ

Монголбанкнаас сүүлийн жилүүдэд санхүүгийн системийн эрсдэлийг бууруулах, эдийн засгийн мөчлөгийн далайцыг багасгах зорилгоор мөчлөг сөрсөн, эрсдэлд суурилсан микро хяналт шалгалт, макро зохистой бодлогын арга хэрэгслүүдийг ашиглаж байна. Үүнд:

- **Банкны салбарын төлбөр түргэн гүйцэтгэх болон эрсдэл даах чадварыг хадгалах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ:** Тайлант хугацаанд Монголбанкнаас банкуудын үйл ажиллагаанд газар дээр нь иж бүрэн, хэсэгчилсэн, гэнэтийн шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд эдийн засгийн нөхцөл байдал, тухайн банкны санхүүгийн чадвар, үйл ажиллагааны онцлог, зөрчлийн шинж байдал, системд үзүүлэх нөлөөллийг харгалзан хэрэгжүүллээ. Мөн банкуудын үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомж, Монголбанкнаас баталсан журам, заавар, зохистой харьцааны хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж ажилласан.
- **Хяналт шалгалтыг эрсдэлд суурилсан хэлбэрт шилжүүлэх болон Банкны тухай хууль, тогоомжийг сайжруулах арга хэмжээ:** Зөвхөн баримт, нотолгоогоор илэрсэн зөрчлийг арилгуулах чиглэлд албадлагын арга хэмжээ авдаг гүйцэтгэлд суурилсан хяналт шалгалтын хэлбэрийг өргөтгөн эрсдэлд суурилсан хэлбэрт шилжүүлэх нэмэлт өөрчлөлтийг Банкны тухай хуульд оруулах ажлыг эхлүүллээ. Энэ өөрчлөлтийг гүйцэтгэснээр Монголбанкнаас банкны салбарын тогтвортой байдлыг алдагдуулах, системд өндөр эрсдэл хуримтлуулах банкуудын зарим үйл ажиллагаа хязгаарлах, зогсоох макро бодлого хэрэгжүүлэх боломжтой болох бөгөөд ирээдүйд татвар төлөгчийн хөрөнгөөр банкны системд дэмжлэг үзүүлэх оновчгүй үйл ажиллагаа хязгаарлагдах давуу тал үүснэ.
- **Санхүүгийн салбарын активын удирдлагын бүтцийг төрөлжүүлэх, хоёрдогч зах зээлийг хөгжүүлэх**

арга хэмжээ: 2017 онд Сангийн яам, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Хууль зүй, дотоод хэргийн яамны төлөөллийг багтаасан өргөтгөсөн ажлын хэсгийг байгуулан санхүүгийн салбарт активын удирдлагын тогтолцоо хөгжүүлэх, түүний суурь эрх зүйн орчин бүрдүүлэхээр Азийн хөгжлийн банктай хамтран ажилласан. Активын удирдлагын тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулж, Сангийн яаманд хүргүүлсэн бөгөөд цаашид УИХ-д өргөн барих арга хэмжээг Засгийн газраас авах болно.

2.2 БАНКНЫ БУС САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА, ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШОО

Банк бус санхүүгийн байгууллагын өнөөгийн байдал

Ерөнхий төлөв байдал

2017 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 529 Банк бус санхүүгийн байгууллага Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байна.

Дүрслэл 2.21

Бүртгэлтэй банк бус санхүүгийн байгууллагын тоо



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Банкуудын зээлийн нөхцөл чангарсантай холбоотойгоор иргэд, аж ахуйн нэгжүүд банк бус санхүүгийн байгууллагуудад хандан хурдан шуурхай зээл авах ажиллагаа идэвхжсэн нь банк бус санхүүгийн байгууллагуудын тоо 2013 оноос эхлэн өсөхөд нөлөөлөв.

ББСБ-уудын 2016 оны эцэс болон 2017 оны 1 дүгээр улирлын эцсийн байдлаарх голлох үзүүлэлтүүдийг Хүснэгт 2.1-т хураангуйлан харуулаа.

Хүснэгт 2.1

Банк бус санхүүгийн байгууллагын голлох статистик үзүүлэлтүүд (тэрбум төгрөг)

№	Үндсэн үзүүлэлтүүд	2016	2017Q1
1	Нийт ББСБ-ын тоо	518	529
2	Харилцагчдын тоо	592 461	1 331 686
3	Хувьцаа эзэмшигчдийн тоо	1 042	1 098
4	Ажиллагсадын тоо	2 115	2 150
5	Салбар нэгжийн тоо	124	122
6	Нийт хөрөнгө	787	798
	Банкны салбарт эзлэх хувь	3.1%	3.2%
7	Нийт зээлийн өрийн үлдэгдэл	478	502
	Банкны салбарт эзлэх хувь	3.9%	4.1%
8	Нийт эзэмшигчдийн өмч	579	636
	Банкны салбарт эзлэх хувь	18.6%	19.5%
9	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	441	510
10	ББСБ-аас татсан зээл	121	63
	Үүнээс:		
	Богино хугацаат зээл	69	22
	Урт хугацаат зээл	52	41
11	Төслийн зээлийн санхүүжилт	21	36
12	Нийт орлого	193	45
13	Нийт зардал	134	32
14	Тайлант үеийн ашиг	59	13

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Нийт 529 ББСБ-ын 89.8 хувь нь зээл, 27.6 хувь нь гадаад валютын арилжаа, 5.7 хувь нь хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх, 5.1 хувь нь итгэлцлийн үйлчилгээ, 4.2 хувь нь факторингийн үйлчилгээ, 2.5 хувь нь төлбөрийн баталгаа гаргах, 2.3 хувь нь цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, 0.4 хувь нь богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйлчилгээг тус тус эрхлэн явуулж байна.

Хүснэгт 2.2

Банк бус санхүүгийн байгууллагын эрхэлж буй үйл ажиллагааны төрөл

№	Үйл ажиллагааны нэр төрөл	2016	2017Q1
1	Зээлийн үйл ажиллагаа	463	475
	Үүнээс: зээлийн үйл ажиллагааг дагнан эрхэлдэг	343	353
2	Гадаад валютын арилжаа	144	146
	Үүнээс: гадаад валютын арилжааг дагнан эрхэлдэг	51	51
4	Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	33	30
3	Итгэлцлийн үйлчилгээ	28	27
5	Факторингийн үйлчилгээ	22	22
6	Төлбөрийн баталгаа гаргах	16	13
7	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	12	12
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	2	2
9	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	2	2

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Нийт хөрөнгө

2007 оноос хойш нийт хөрөнгө жил бүр өссөөр 2017 оны 1 дүгээр улирлын эцэст 798.3 тэрбум төгрөгт хүрсний 762.6 тэрбум төгрөг нь эргэлтийн хөрөнгө байна.

Дүрслэл 2.22

Банк бус санхүүгийн байгууллагын нийт хөрөнгийн бүтэц (тэрбум төгрөг)



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Зээлийн чанар

2017 оны 1 дүгээр улирлын эцсийн байдлаар зээлийн багц нийт хөрөнгийн 62.9 хувь буюу 502.4 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны эцсээс 5.1 хувиар өссөн дүнтэй байна. Энэхүү өсөлтийн 3.3 нэгж хувь нь хэвийн зээлийн өсөлт, 12.7 нэгж хувь нь хугацаа хэтэрсэн зээлийн өсөлт, 13.4 нэгж хувь нь чанаргүй зээлийн өсөлтөөр тайлбарлагдаж байна.

Дүрслэл 2.23

Банк бус санхүүгийн байгууллагын нийт зээл, зээлийн чанар (тэрбум төгрөг)



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

2017 оны эхний улиралд чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 2.0 хувиар өсч 67.5 тэрбум төгрөгт хүрэв. Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 13.4 хувь байгаа нь банкны салбартай харьцуулахад 5.8 нэгж хувиар өндөр байгаа юм. Чанаргүй зээлийн хэмжээ цаашид ч өсөх хандлагатай байгаа ба эдийн засгийн өсөлт саарснаас шалтгаалан иргэд, аж ахуй нэгж байгууллагын орлого буурч буй өнөөгийн нөхцөлд их хэмжээгээр өндөр хүүтэй зээл олгосноор уг салбар дахь зээлийн эрсдэлийг нэмэгдүүлээд байна.

Зээлийн хүү

2017 оны 1 дүгээр улиралд ББСБ-уудын зээлийн сарын хамгийн өндөр хүү 8.5 хувь, сарын хамгийн бага хүү 1.2 хувьтай байсан бол ББСБ-ын зээлийн хүүг банкны зээлийн хүүтэй харьцуулахад хүүний зөрүү сарын 2.5 хувь байв.

Дүрслэл 2.24

Банк ба ББСБ-ын зээлийн сарын дундаж хүү (%)



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Нийт эх үүсвэр ба Эзэмшигчдийн өмчийн бүтэц

Эзэмшигчдийн өмч 2017 оны 1 дүгээр улирлын эцэст өмнөх оны мөн үетэй харьцуулахад 39.5 хувиар өссөн байна. 2016 оны эцсийн байдлаар нийт эх үүсвэрийн 26.5 хувийг өр төлбөр, 73.5 хувийг эзэмшигчийн өмч эзэлж байсан бол 2017 оны 1 дүгээр улирлын эцсийн байдлаар нийт өр төлбөр 20.4 хувь, эзэмшигчийн өмч 79.6 хувь болж өөрчлөгдсөн.

Хүснэгт 2.3

Банк бус санхүүгийн байгууллагын санхүүгийн голлох үзүүлэлтүүд (тэрбум төгрөг)

Үзүүлэлтүүд	2013	2014	2015	2016	2017Q1
Нийт актив	**381.1**	**508.0**	**623.2**	**787.2**	**798.3**
Нийт зээлийн өрийн үлдэгдэл	223.7	303.1	391.2	478.2	502.4
Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмч	**381.1**	**508.0**	**623.2**	**787.2**	**798.3**
Нийт өр төлбөр	**146.8**	**175.9**	**199.0**	**208.7**	**162.8**
Эзэмшигчдийн өмч	**234.3**	**332.1**	**424.2**	**578.5**	**635.5**
Үүнээс:					
Хувьцаат капитал	183.7	258.2	308.5	440.5	509.8
Бусад өмч	7.2	7.2	12.0	6.1	6.5
Сангууд	0.2	0.3	0.3	0.5	0.6
Хуримтлагдсан ашиг/алдагдал	41.7	64.0	102.0	130.4	117.7
Хоёрдогч өглөг	1.6	2.4	1.4	1.0	0.9
Нийт орлого	106.6	132.9	156.1	193.4	45.2
Нийт зарлага	76.8	96.5	109.7	134.4	32.3
Татварын дараах цэвэр ашиг	**29.8**	**36.4**	**46.4**	**59.0**	**12.9**

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

ББСБ-ын тоо өсөн нэмэгдэхийн хэрээр хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ өсчээ. 2017 оны 1 дүгээр улирлын эцсийн байдлаар хувь нийлүүлсэн хөрөнгө өмнөх оны мөн үеэс 168.5 тэрбум төгрөгөөр буюу 49 хувиар өссөн байна.

Орлого, зарлага, ашигт ажиллагаа

Тайлант хугацаанд ББСБ-ын салбар нийт 45.2 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 10 хувиар өссөн үзүүлэлт юм. Нийт орлогын 82.1 хувийг хүүгийн орлого, 14.2 хувийг хүүгийн бус орлого тус тус эзэлж байна. Харин ашигт ажиллагааны гол үзүүлэлт болох ROA (активын өгөөж) 2017 оны 1 дүгээр улирлын эцсийн байдлаар 1.8 хувь байна.

Хүснэгт 2.4

Орлого, зарлага, ашигт ажиллагаа (тэрбум төгрөг)

№	Үзүүлэлтүүд	2017Q1
1	**Нийт орлого**	**45.2**
	Хүүгийн орлого	37.1
	Хүүгийн бус орлого	6.4
	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	1.7
2	**Нийт зардал**	**32.3**
	Хүүгийн зардал	4.0
	Хүүгийн бус зардал	20.0
	Болзошгүй эрсдэлийн зардал	5.9
	Үндсэн бус үйл ажиллагааны зардал	0.7
3	**Орлогын татварын зардал**	**1.7**
4	**Татварын дараах цэвэр ашиг**	**12.9**

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

ББСБ-уудын зохистой харьцааны үзүүлэлт

Тусгай зөвшөөрөл эзэмшигч ББСБ-уудын санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлан мэдээг СЗХ-ны 2016 оны 147 дугаар тогтоолоор батлагдсан "Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам"-ын дагуу тооцоход системийн түвшинд дараах байдалтай байна.

Хүснэгт 2.5

ББСБ-уудын зохистой харьцааны үзүүлэлтүүдийг хангасан байдал

№	Үзүүлэлт	ББСБ-ын тоо	Эзлэх хувь
1	**Зохистой харьцааг хангаж ажилласан ББСБ-ын тоо**	438	82.8%
2	1 зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	58	11.0%
3	2 зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	24	4.5%
4	3 зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	6	1.1%
5	4 болон түүнээс дээш зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	3	0.6%
	Нийт	**529**	**100%**

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

2017 оны 1 дүгээр улирлын байдлаар тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй 529 ББСБ-ын 82.8 хувь нь зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан бол 11 хувь нь 1 харьцаа үзүүлэлтийг хангаагүй, 4.5 хувь нь 2 харьцаа үзүүлэлтийг хангаагүй, 1.1 хувь нь 3 харьцаа үзүүлэлтийг хангаагүй, 0.6 хувь нь 4 болон түүнээс дээш харьцаа үзүүлэлтийг хангаагүй ажилласан байна.

ББСБ-уудын эмзэг байдал

ББСБ-уудын тоо өмнөх оны мөн үеэс 66-аар буюу 14 хувиар нэмэгдсэн. Энэ нь нийт санхүүгийн систем дэх чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдсэнтэй холбогдуулан арилжааны банкуудаас тавигдах зээлийн нөхцөл чангарч, иргэд, жижиг дунд бизнес эрхлэгчид болон аж ахуйн нэгж байгууллагууд шаардлагатай зээлийн санхүүжилтийг банк бус санхүүгийн байгууллагуудаас авах тохиолдол улам ихэссэнтэй холбоотой юм. Үүнээс шалтгаалан нийт ББСБ-ын чанаргүй зээлийн хэмжээ өсч, тодорхой хэмжээний эрсдэлийг салбарын хэмжээнд бий болгоод байна.

Түүнчлэн макро эдийн засгийн нөхцөл байдал хүндэрч, эдийн засгийн өсөлт удааширч байгаа өнөөгийн нөхцөлд арилжааны банкуудын жилийн дундаж хүүгээс өндөр хүүтэй зээлийг иргэд, аж ахуй нэгж байгууллагуудад олгож байгаа нь эргээд тэдэнд дарамт учруулж, зээлийн эргэн төлөлт хугацаандаа төлөгдөхгүй байх, улмаар чанаргүй зээлийн хэмжээ өсөх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Хадгаламж, зээлийн хоршооны өнөөгийн байдал

Ерөнхий төлөв байдал

2017 оны 1 дүгээр улирлын байдлаар 282 Хадгаламж, зээлийн хоршоо СЗХ-ноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна.

Хадгаламж, зээлийн хоршоодын активын хэмжээ өмнөх оны мөн үеэтэй харьцуулахад 19.9 хувиар буюу 20.2 тэрбум төгрөгөөр өсөж 121.7 тэрбум төгрөгт хүрэв.

Дүрслэл 2.25

Хадгаламж, зээлийн хоршоо болон гишүүдийн тоо



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Хүснэгт 2.6

Хадгаламж, зээлийн хоршоодын голлох статистик үзүүлэлтүүд (тэрбум төгрөг)

№	Үндсэн үзүүлэлтүүд	2017Q1
1	**ХЗХ-дын тоо**	**282**
2	**Гишүүдийн тоо**	**47 918**
3	Нийт актив	121.7
	Банкны салбарт эзлэх хувь	0.5%
4	Нийт зээлийн өрийн үлдэгдэл	96.7
	Банкны салбарт эзлэх хувь	0.8%
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл	4.5
	Банкны салбарт эзлэх хувь	0.4%
6	Нийт татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдэл	74.7
	Банкны салбарт эзлэх хувь	0.9%
7	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн үлдэгдэл	13.4
8	**Нийт хоршоологчдын өмчийн үлдэгдэл**	**10.1**
9	**Бусад өр төлбөр**	**0.0**
10	Нийт орлого	6.9
11	Нийт зардал	6.5
12	**Тухайн үеийн ашиг, алдагдал**	**0.5**

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Зээлийн чанар

Тайлант хугацаанд нийт зээлийн багцын 90.2 хувийг хэвийн, 5.2 хувийг хугацаа хэтэрсэн, 4.6 хувийг чанаргүй зээл тус тус эзэлж байна. Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 0.3 нэгж хувиар өсч 4.6 хувьд хүрчээ.

Дүрслэл 2.26

Хадгаламж, зээлийн хоршоодын нийт зээл, зээлийн чанар (тэрбум төгрөг)



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Өр төлбөр ба өөрийн хөрөнгө

ХЗХ-дын өр төлбөр, өөрийн хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 20.2 тэрбум төгрөгөөр өслөө. Үүнд бусад өр төлбөрийн хэмжээ өмнөх оноос 1.5 тэрбум төгрөгөөр буюу 22.3 хувиар өссөн нь нөлөөлжээ.

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ 74.7 тэрбум төгрөг буюу нийт эх үүсвэрийн 61.3 хувийг эзэлж байгаа бөгөөд үүний 72.3 тэрбум төгрөг буюу 96.9 хувь нь хугацаатай хадгаламж байгаа бол 2.3 тэрбум төгрөг буюу 3.1 хувь нь хугацаагүй хадгаламж байна.

Дүрслэл 2.27

Хадгаламж, зээлийн хоршоодын өр төлбөр ба өөрийн хөрөнгө (тэрбум төгрөг)



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Ашигт ажиллагаа

2017 оны 1 дүгээр улиралд ХЗХ-дын нийт орлого 6.9 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 0.9 тэрбум төгрөг буюу 14.1 хувиар өссөн бол нийт зардал 6.5 тэрбум төгрөгт хүрч, 1 тэрбум төгрөг буюу 18.2 хувиар өссөн дүнтэй гарсан. Ингэснээр тайлант хугацаанд нийт цэвэр ашгийн хэмжээ 0.5 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад 0.1 тэрбум төгрөг буюу 22.2 хувиар буурав.

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Ерөнхий төлөв байдал

Үнэт цаасны зах зээлийн хөгжлийг зах зээлийн үнэлгээ, хөрвөх чадварын түвшин, зах зээлийн үнэлгээг дотоодын нийт бүтээгдэхүүнд харьцуулсан харьцаа, нийт арилжааны хэмжээ зэрэг үзүүлэлтүүдээр голчлон хэмждэг бөгөөд дээрх үзүүлэлтүүдийн ерөнхий төлөв, хандлагаас зах зээлийн бодит нөхцөл, байдлыг тодорхойлох боломжтой байдаг.

Зах зээлийн үнэлгээ

Үнэт цаасны зах зээлийн эдийн засагт эзлэх хувийг зах зээлийн үнэлгээ (ЗЗҮ)-гээр илэрхийлэх ба 2017 оны 1 дүгээр улирлын эцсийн байдлаар ЗЗҮ 1 их наяд 429.2 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.2 хувиар буюу 131.9 тэрбум төгрөгөөр өссөн бол харин өмнөх оны эцсээс 3 хувиар буюу 44.9 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй гарлаа.

Дүрслэл 2.28

ТОП-20 индекс болон зах зээлийн үнэлгээ



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Зах зээлийн үнэлгээ буурахад эдийн засгийн өсөлт удааширсан, уул уурхайн салбарын компанийн хувьцааны үнэ ханш дотоодын болон олон улсын хөрөнгийн бирж дээр огцом буурсан, гадаадын хөрөнгө оруулагчдын үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулах сонирхол 2012 оноос хойш эрс буурсан, зах зээлийн дэд бүтэц сул зэрэг нь голчлон нөлөө үзүүлжээ.

Тайлант хугацаанд ТОП-20 индексийн утга өмнөх оны мөн үеэс 12.3 хувиар өсч 12451.0 нэгжид хүрсэн бол энэ нь өмнөх оны эцсээс 0.04 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Зах зээлийн хөрвөх чадвар

Хөрвөх чадварын түвшин нь хувьцааны зах зээлийн эргэц, хурдыг илэрхийлэх бөгөөд хөгжингүй зах зээлтэй орнуудад дээрх харьцааны түвшин 70-90 хувьтай байх бөгөөд хөрвөх чадварын түвшинг нэмэгдүүлэх чиглэлээр хөрөнгийн биржүүд итгэмжлэгдсэн дилер (маркет мэйкер), үнэт цаас зээлээр худалдах, худалдан авах арга хэрэгслүүдийг ихээр ашиглаж гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг тухайн зах зээлд татаж байна.

Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын тухайн зах зээлд хөрөнгө оруулах сонирхол нь хөрвөх чадварын түвшин, ханшийн эрсдэлээс хамгаалах тогтолцоо буюу бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөлжилтөөс хамаарах бөгөөд “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн арилжаанд эзлэх гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын бүтцийг 2017 оны 1 дүгээр улирлын байдлаар авч үзвэл дотоодын иргэн 50.1 тэрбум төгрөг, гадаадын иргэн 0.69 тэрбум төгрөг, дотоодын аж ахуйн нэгж 80.2 тэрбум төгрөг, гадаадын аж ахуйн нэгж 6.5 тэрбум төгрөгөөр тус тус арилжаанд оролцжээ. Үнэт цаасны нийт арилжааны 5.2 хувийг гадаадын хуулийн этгээд бүрдүүлж байгаа бөгөөд үүнийг 2012 онтой харьцуулахад эрс буурсан үзүүлэлттэй байна.

2017 оны 1 дүгээр улирлын байдлаар зах зээлийн хөрвөх чадварын үзүүлэлт 0.35 хувь байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс даруй 0.3 нэгжээр буурсан бол өмнөх оны эцсээс 0.13 нэгжээр нэмэгдсэн байна. Хөрвөх чадварын түвшин багасахад голчлон хөрөнгийн биржид бүртгэлттэй хувьцаат компаниудын хяналтын багц цөөн тооны хөрөнгө оруулагчдын гарт

төвлөрсөн, нийт бүртгэлтэй компаниудын дийлэнх нь 75 хувиас дээш төвлөрөлтэй, нэмж үнэт цаас гаргах сонирхол бага, гадаад, дотоодын томоохон мэргэжлийн хөрөнгө оруулагч байхгүй, тэдгээрийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл дутмаг, хөрөнгийн бирж дээр итгэмжлэгдсэн дилер (маркет мэйкер)-ийн зуучлалын тогтолцоо хөгжөөгүй нь суурь нөлөө үзүүлжээ.

Дүрслэл 2.29

Хөрвөх чадвар, хувьцааны арилжааны үнийн дүн (жил бүрийн эхний улирлын байдлаар)



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Мөн мэргэжлийн зуучлагч байгууллагуудын санхүүгийн болон хүний нөөцийн чадавхи сул, маржин арилжаа буюу зээлээр үнэт цаас худалдан авах үйлчилгээний төрөл хөгжөөгүй, иргэдийн үнэт цаасны зах зээлийн талаарх мэдлэг, мэдээлэл хомс байгаагаас шалтгаалан хувьцаа худалдан авахаас илүүтэйгээр банкинд мөнгөө байршуулах сонирхол өндөр, хувьцаат компаниудын засаглалд итгэх итгэл сул зэрэг нь хөрвөх чадварын түвшинг бага байхад давхар нөлөөлжээ.

Үнэт цаасны арилжааны үзүүлэлтүүд

2017 оны 1 дүгээр улирлын байдлаар ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр 11 удаагийн арилжаа явагдаж, 12, 28, 39, 52, 104, 156 долоо хоногийн хугацаатай нийт 1.3 сая ширхэг үнэт цаасыг 119.5 тэрбум төгрөгөөр арилжаалсан байна. Харин ЗГҮЦ-ны хоёрдагч зах зээл дээр 142 мянган ширхэг үнэт цаас 13.7 тэрбум төгрөгөөр арилжаалагдсан байна. Хувьцааны нийт 64 удаагийн арилжаагаар 94 компанийн 28.9 сая ширхэг хувьцааг 5.0 тэрбум төгрөгөөр арилжсан нь нийт арилжааны үнийн дүнгийн 3.6 хувийг эзэлжээ. Тайлант хугацаанд хувьцааны багцын арилжаа хийгдээгүй бөгөөд харин тендерийн арилжаагаар 109 мянган ширхэг хувьцааг 30 сая төгрөгөөр арилжаалсан байна.

Үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн үзүүлэлтүүд

Бүртгэлтэй компани

2017 оны 1 дүгээр улирлын эцсийн байдлаар СЗХ-нд 302 хувьцаат компани бүртгэлтэй байгаагаас, төрийн өмчийн оролцоотой 19, төрийн өмчит 31, хувийн өмчит 252 компани байна.

Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувийн өмчит компаниудын дийлэнх нь өмч хувьчлалаар үүсэн бий болсноос үүдэн компанийн хувьцааны хяналтын багц цөөн тооны нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн гарт төвлөрсөн нь зах зээл дэх нийлүүлэлтэд сөргөөр нөлөөлөв.

Хувьцаат компанийн хяналтын багц цөөн тооны хөрөнгө оруулагчдын гарт төвлөрсөн нь компанийн засаглал сул, дотоод мэдээлэл эзэмшигч этгээд үнэт цаасны үнэ ханшид нөлөөлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулах сонирхлыг бууруулж байгаа нь зах зээлийн хөрвөх чадварыг бууруулах үндсэн шалтгаан болж байна.

Дүрслэл 2.30

Бүртгэлтэй хувьцаат компанийн тоо, тэдгээрийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилт



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.
Тэмдэглэл: *2017 оны 1 дүгээр улирлын байдлаар.

Олон улсын туршлагаас үзэхэд компанийн засаглалыг хувьцаа эзэмшигчдийн хурлаа хуралдуулсан, хараат бус төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээ сонгосон болон санхүүгийн тайлангаа төрийн эрх бүхий байгууллага, олон нийтэд мэдээлсэн байдал, ногдол ашиг тараалт, нийгмийн хариуцлага гэсэн үзүүлэлтүүдээр голчлон авч үздэг.

2017 оны 1 дүгээр улирлын байдлаар 16 компани 2016 оны жилийн эцсийн ашгаасаа нийт 54 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараах шийдвэр гаргасан бөгөөд үүнээс 7 компанийн 9.1 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараагдаад байна.

Зах зээлийн дэд бүтэц

2017 оны 1 дүгээр улирлын эцсийн байдлаар Хорооноос олгосон тусгай зөвшөөрөл бүхий үйл ажиллагаа явуулж буй арилжаа эрхлэх 2, үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх 1, төвлөрсөн хадгаламжийн 1, кастодиан банкны үйлчилгээ үзүүлэх 3, хөрөнгө оруулалтын менежментийн 14 компани үйл ажиллагаа явуулж байна.

Үнэт цаасны зах зээлийн төлбөр, тооцооны үзүүлэлтүүд

2017 оны 1 дүгээр улирлын байдлаар төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн дансаар 542 харилцагчийн 1062 удаагийн нийт 971.9 тэрбум төгрөгийн орлого, 191 харилцагчийн 481 удаагийн нийт 938.4 тэрбум төгрөгийн зарлагын гүйлгээ тус тус хийгджээ.

Дүрслэл 2.31

Арилжааны төлбөр тооцоо



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Мөн "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн үнэт цаасны арилжааны мөнгөн төлбөрөөс "Хас банк" ХХК 2.4 тэрбум, "Голомт банк" ХХК 1.8 тэрбум, "Худалдаа хөгжлийн банк" ХХК 1.3 тэрбум, "ХААН банк" ХХК 116 сая төгрөгийн гүйлгээг тус тус хийжээ.

Тус хугацаанд төвлөрсөн хадгаламжид шинээр нийт 4190 данс нээгдсэнээс, дотоодын иргэн 4129, гадаадын иргэн 28, дотоодын аж ахуй нэгж 32, гадаадын аж ахуйн нэгж 1 данс нээлгэсэн байна. 2012 оноос үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид нээгдсэн дансны тоо эрс өссөн нь төрөөс "Эрдэнэс таван толгой" ХК-ийн 1072 ширхэг хувьцааг үнэ төлбөргүйгээр эзэмшүүлэх шийдвэр гарсан нь голлон нөлөөлсөн.

ДААТГАЛЫН САЛБАР

Даатгалын салбарын ерөнхий мэдээлэл

Ерөнхий төлөв байдал

2017 оны 1 дүгээр улирлын байдлаар ердийн даатгалын 15, урт хугацаат даатгалын 1, ХАА-н давхар даатгалын 1 компани нийт 17 даатгагч үйл ажиллагаа явуулж байна. Даатгалын зах зээлд нийт 3152 мэргэжлийн оролцогч оролцож байгаагаас зуучлагч 41, хохирол үнэлэгч 30, 3091 төлөөлөгч Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж байна.

Хүснэгт 2.7

Даатгалын салбарын тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн тоо

Үзүүлэлт	2014	2015	2016	2017Q1
Даатгагч	17	17	17	17
Даатгалын төлөөлөгч	3 260	3 340	3 091	3 091
Даатгалын зуучлагч	30	37	40	41
Даатгалын хохирол үнэлэгч	20	27	31	30
Дүн	**3 327**	**3 421**	**3 179**	**3 179**

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Даатгагчийн хөрөнгө

2017 оны 1 дүгээр улирлын байдлаар даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй даатгалын компанийн нийт хөрөнгийн хэмжээ 224.8 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 35.9 тэрбум төгрөгөөр буюу 19 хувиар өсчээ.

Сүүлийн 5 жилд даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй нийт компаниудын хөрөнгийн хэмжээ 2.7 дахин нэмэгдсэн бол урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхэлж буй "Нэйшнл лайф даатгал" ХХК-ийн хөрөнгийн хэмжээ 2.1 дахин тус тус нэмэгдсэн дүнтэй байна. 2017 оны 1 дүгээр улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан ердийн болон урт хугацааны даатгалын компаниудыг нийт хөрөнгийн хэмжээгээр нь жагсаахад эхний нэг компани 18.4 хувийн, эхний гурван компани нийлээд 34.8 хувийн тус тус төвлөрөлтэй байв.

Хүснэгт 2.8

Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ (2017 оны I улирлын байдлаар, тэрбум төгрөг)

№	Даатгалын компаниуд	Нийт хөрөнгийн хэмжээ	Эзлэх хувь
1	Хөдөө аж ахуйн давхар даатгал	36.2	16.1%
2	Монгол даатгал	32.0	14.2%
3	Бодь даатгал	24.7	11.0%
4	Тэнгэр даатгал	18.1	8.1%
5	Мандал женерал даатгал	17.0	7.6%
6	Миг даатгал	11.4	5.1%
7	Практикал даатгал	11.2	5.0%
8	Номин даатгал	10.4	4.6%
9	Соёмбо даатгал	10.0	4.4%
10	Ард даатгал	9.0	4.0%
11	Хаан даатгал	8.2	3.7%
12	Нэйшнл лайф даатгал	7.7	3.4%
13	Монре даатгал	6.6	2.9%
14	Ган зам даатгал	6.5	2.9%
15	Гэр даатгал	5.8	2.6%
16	Улаанбаатар хотын даатгал	5.6	2.5%
17	Мөнх даатгал	4.3	1.9%
	Дүн	**224.8**	**100.0%**

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Нийт даатгалын компаниудын хөрөнгийн 58.9 хувийг хөрөнгө оруулалтын дүн, 19.0 хувийг бусад хөрөнгө, 11.1 хувийг үндсэн хөрөнгө, 11.0 хувийг даатгалын хөрөнгийн дүн, харин эх үүсвэрийн 53.1 хувийг өр төлбөр, 46.9 хувийг эзэмшигчдийн өмч тус тус эзэлж байна.

Хүснэгт 2.9

Даатгалын компаниудын хөрөнгө балансын зүйлээр (хувиар)

№	Үзүүлэлтүүд	Ердийн даатгал	Урт хугацаат даатгал	ХАА-н давхар даатгал
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	6%	7%	1%
2	Даатгалын авлагын дүн	7%	0%	0%
3	Бусад санхүүгийн хөрөнгийн дүн	5%	4%	4%
4	Бусад санхүүгийн бус хөрөнгийн дүн	1%	0%	0%
5	Хөрөнгө оруулалтын дүн	53%	56%	92%
6	Даатгалын хөрөнгийн дүн	14%	0%	1%
7	Үндсэн хөрөнгө /Цэвэр/	12%	34%	2%
8	Биет бус хөрөнгө /Цэвэр/	0%	0%	1%
9	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	2%	0%	0%
10	Өр төлбөр	7%	0%	2%
11	Нөөц сан	50%	21%	37%
12	Эзэмшигчдийн өмч	43%	78%	61%
13	Хувь нийлүүлсэн хөрөнгө	33%	68%	41%
14	Хуримтлагдсан ашиг	6%	-5%	18%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Ердийн даатгалын компанийн эх үүсвэрийн 50 хувь буюу 30.3 тэрбум төгрөгийг нөөц сан бүрдүүлж байгаа бол нийт хөрөнгийн 53 хувь буюу 95 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтын дүн эзэлж байна.

Даатгагчийн өр төлбөр ба эзэмшигчдийн өмч

Дүрслэл 2.32

Даатгалын компаниудын өр төлбөр, эзэмшигчдийн өмч



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмч дэх даатгалын нөөц сан 2014 оны 4 дүгээр улиралд 43.4 хувь, 2015 оны 4 дүгээр улиралд 42.1 хувь, 2016 оны 4 дүгээр улиралд 44.6 хувь, 2017 оны 1 дүгээр улиралд 46.9 хувь тус тус байв.

Даатгалын хураамжийн орлого ба нөхөн төлбөр

Даатгалын салбарын нийт хураамжийн орлогын хэмжээ 2017 оны 1 дүгээр улирлын байдлаар 37.5 тэрбум төгрөгт хүрлээ. Үүнээс ердийн даатгалын компаниуд 36.6 тэрбум төгрөгийн, урт хугацааны даатгалын компани 396.4 сая төгрөгийн, давхар даатгалын компани 504.4 сая төгрөгийн хураамжийн орлого тус тус төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2.10

Даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөр, бүтээгдэхүүнээр (тэрбум төгрөг)

№	Бүтээгдэхүүний хэлбэр	Даатгалын нийт хураамжийн орлого	Нийт нөхөн төлбөр
1	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	2.6	1.0
2	Хөрөнгийн даатгал	13.6	0.4
3	Авто тээврийн хэрэгслийн даатгал	3.6	2.1
4	Ачааны даатгал	0.2	0.0
5	Барилга угсралтын даатгал	0.1	0.0
6	Газар тариалангийн даатгал	0.0	0.0
7	Мал амьтдын даатгал	0.0	0.0
8	Агаарын хөлгийн даатгал	1.0	0.0
9	Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	0.1	0.0
10	Хариуцлагын даатгал	3.3	0.1
11	Санхүүгийн даатгал	0.5	0.4
12	Зээлийн даатгал	0.3	0.2
13	Итгэлцлийн даатгал	0.2	0.0
14	Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал	0.0	0.0
15	Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	0.0	0.0
16	Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	4.8	0.0
17	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	6.2	4.4
18	Амьдралын даатгал	0.4	0.2
19	Давхар даатгал	0.5	0.0
	Дүн	**37.5**	**8.8**

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

2005 оноос 2014 он хүртэлх хугацаанд нийт хураамжийн орлого 99.2 тэрбум төгрөгөөр ялангуяа 2012 оноос эхлэн огцом өссөн байна. Үүнд 2012 онд “Жолоочийн албан журмын даатгалын тухай хууль” батлагдаж, хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор албан журмаар даатгуулах даатгуулагчдын тоо нэмэгдэж, мөн түүнчлэн албан журмын даатгалын өсөлтийг дагаж авто тээврийн хэрэгслийн даатгал өндөр өсөлттэй гарсан нь голлон нөлөөлжээ. Харин 2017 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 8.8 тэрбум төгрөгийн даатгалын нөхөн төлбөр олгожээ.

Даатгалын салбарын ашигт ажиллагаа

2017 оны 1 дүгээр улирлын байдлаар даатгалын компаниудын ашигт ажиллагааг тооцоход, нийт хөрөнгийн өгөөжийн дүн салбарын хэмжээнд 0.4 хувь, үүнээс урт хугацаат даатгалын компанийн өгөөжийн дүн 0.6 хувь, давхар даатгалын компанийх 2.9 хувь гарсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад даруй 1.5 хувиар, 2016 оны жилийн эцсийн дүнгээс 5 хувиар буурсан үзүүлэлт юм. Ердийн даатгалын компаниуд алдагдалтай ажилласан байна. Харин өөрийн хөрөнгийн өгөөжийн салбарын дундаж үзүүлэлт 0.8 хувь байгаа

бөгөөд үүнээс урт хугацаат даатгалын өөрийн хөрөнгийн өгөөж 0.7 хувь, давхар даатгал 4.7 хувь, ердийн даатгал сөрөг гарсан нь өмнөх оны мөн үеийнхээс 2.8 хувиар өсч, өмнөх оны эцсийн дүнгээс 10.0 хувиар буурсан үзүүлэлт юм. Ердийн даатгалын компанийн хураамжийн орлого өмнөх оны мөн үеэс 9.7 тэрбум төгрөгөөр буюу 36 хувиар, татварын дараах цэвэр ашиг 3.7 тэрбум төгрөгөөр буюу 105.4 хувиар буурсан байна. Урт хугацаат даатгалын компанийн хураамжийн орлого 93 сая төгрөг буюу 30 хувиар, татварын дараах цэвэр ашиг 26 сая төгрөг буюу 2.6 дахин тус тус өсчээ.

Даатгалын салбарын тогтвортой байдал

2017 оны 1 дүгээр улирлын байдлаар хураамжийн орлогоос гадаадын давхар даатгалын компанид төлж байгаа төлбөр 20 тэрбум төгрөг буюу нийт хураамжийн орлогын 53 хувийг эзэлсэн бол өмнөх 5 жилийн эхний улирлуудын дундаж 46 хувьтай байв. Нийт давхар даатгалын төлбөрийн 98.9 хувийг ердийн даатгалын компани, 1.1 хувийг давхар даатгалын компани, 0.03 хувийг урт хугацаат даатгалын компани шилжүүлсэн ба ердийн даатгалын компани хураамжийн орлогын 54 хувийг, урт хугацаат даатгалын компани 1.3 хувийг, хөдөө аж ахуйн давхар даатгалын компани 42.4 хувийг давхар даатгалд тус тус төлжээ.

Давхар даатгалын үндэсний компани байхгүй байгаа нь даатгалын салбар дахь гадаад валютын гадагшлах урсгалыг нэмэгдүүлэх үндсэн шалтгаан болж, цаашид салбарын тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай байна Даатгалын салбар нь нийгэм, эдийн засагт учрах хүлээгдэгүй эрсдэлийг бууруулж, санхүүгийн тогтвортой байдлыг хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг хэдий ч, даатгалын салбарын өөрийн тогтворгүй байдал, системийн эрсдэлийн түвшин нь эргээд санхүүгийн тогтвортой байдалд томоохон нөлөө үзүүлдэг.

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл /Financial Stability Board/ болон Олон улсын даатгалын хяналт, зохицуулалтын байгууллагуудын хороо /IAIS/-ноос даатгалын салбарт учирч буй системийн эрсдэлийг үндсэн гурван чиглэлийн хүрээнд тодорхойлжээ. Үүнд:

- Санхүүгийн зах зээлийн бусад оролцогчид /банк, үнэт цаасны компаниуд/-оос үүдэлтэй эрсдэлийн нөлөөлөл;
- Даатгалын компани уг нөлөөлөлд хариу үйлдэл үзүүлснээр эрсдэл бууруулах чадвар;
- Даатгалын компани нь өөрөө системийн эрсдэлийг үүсгэгч.

Тиймээс Олон улсын даатгалын хяналт, зохицуулалтын хорооноос даатгалын салбарын тогтвортой байдлыг хангах, системийн хэмжээнд нөлөөлөхүйц даатгалын компанийг тодорхойлох, түүнд хяналт тавих, системийн эрсдэлийг эрт илрүүлж, урьдчилан сэргийлэх чиглэлээр 2010 оноос анхаарч, системийн хэмжээнд нөлөөлөхүйц даатгалын компанийг тодорхойлох үнэлгээний аргачлал, макро болон микро зохистой үзүүлэлтийн аргачлалыг боловсруулж, хөрөнгийн болон төлбөрийн чадварын шинэ стандарт, шаардлагуудыг бий болгоод байна.

Энэ хүрээнд тус байгууллагаас даатгалын салбар болон компаниудад учирч болох эрсдэлийг бууруулахын тулд макро болон микро зохистой үзүүлэлтийн хүрээнд хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэхийг гишүүн орнуудын зохицуулах байгууллагуудад зөвлөсөн бөгөөд уг зөвлөмжийг хэрэгжүүлснээр даатгалын салбарт нөлөөлөхүйц макро эдийн засгийн хувьсагчдын нөлөөллийг зөв тодорхойлох, тулгарч болзошгүй системийн эрсдэлийг эрт илрүүлэх тогтолцоо бүрдэх, ирээдүйд бий болж болохуйц эрсдэлд хариу үйлдэл үзүүлэх боломж бүрдэнэ гэж үзэж байна.

Зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэгч байгууллага

Зээлийн батлан даалтын сан нь эргэлтийн хөрөнгийн, хөрөнгө оруулалтын, бичил зээлийн гэсэн 3 төрлөөр батлан даалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд нэг удаа гаргах батлан даалтын дээд хэмжээ нь 250.0 сая төгрөг байна. 2017 оны 1 дүгээр улиралд нийт 3.8 тэрбум төгрөгийн зээлийн багцад 1.4 тэрбум төгрөгийн батлан даалтыг гаргасан байна.

Зээлийн батлан даалтын сан нь 10 банк, 6 банк бус санхүүгийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байгаагаас 2017 оны 1 дүгээр улиралд 3 банкаар дамжуулан батлан даалтын үйлчилгээг хүргэсэн.

Нийт гаргасан батлан даалтын 55.6 хувийг Төрийн банк, 38.5 хувийг Хаан банк, 5.9 хувийг Голомт банкны зээлэнд тус тус гаргасан бөгөөд банкнаас олгосон дундаж зээлийн хэмжээ 1.3 тэрбум төгрөг бол дунджаар зээлийн дүнгийн 36 хувьд нь батлан даалт гаргасан.

Дүрслэл 2.33

Батлан даалт гаргасан байдал болон санхүүжилтийн эх үүсвэр (сая төгрөг)



№	Үзүүлэлтүүд	2016	2017Q1
1	Батлан даалтын хэмжээ	1196.3	1367.0
	Үүнээс: Хугацаа хэтэрсэн	90.2	200.3
	Чанаргүй	1286.5	1639.0
2	Батлан даалт гаргасан зээлийн дүн	4080.0	3801.5
	Үүнээс: Хугацаа хэтэрсэн	229.2	468.0
	Чанаргүй	2781.1	3454.2
3	Үүрэг гүйцэтгүүлсэн батлан даалтын дүн	18.5	-

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ БА ТҮҮХИЙ ЭДИЙН АРИЛЖАА

Хөдөө аж ахуйн бирж ТӨХХК нь 2017 оны 1 дүгээр улиралд 30.9 тэрбум төгрөгийн арилжааг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 9.5 тэрбум төгрөг буюу 45 хувиар илүү дүнтэй арилжаа хийсэн байна. Үүнд 163.6 тонн ямааны ноолуур, 909.5 тонн хонины ноос, 27.8 тонн тэмээний ноос, 1055.6 тонн ямааны завод ноос, 513.0 тонн завод ноос арилжсан байна.

Хүснэгт 2.11

Хөдөө аж ахуйн бирж дээрх түүхий эдийн арилжааны үнийн дүн

Барааны нэр	2016		2017Q1	
	Барааны хэмжээ/ тонн/	Арилжааны дүн/тэрбум төгрөг/	Барааны хэмжээ/тонн/	Арилжааны дүн/тэрбум төгрөг/
Ямааны ноолуур	7 216.0	409.7	163.6	13.8
Хонины ноос	16 150.0	26.2	909.5	1.3
Ямааны завод ноос	1 639.0	23.2	1 055.6	14.9
Тэмээний ноос	774.0	3.9	27.8	0.1
Завод ноос /тэмээ, хонины/	1.1	0.0	513.0	0.6
Бодын хөөвөр	4.1	0.1	-	-
Нийт	**25 784.2**	**463.0**	**2 669.4**	**30.8**

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

ХАА-н гаралтай түүхий эдийн биржийн жилийн дундаж арилжаа 460 орчим тэрбум төгрөг байгаа бөгөөд үүний 66 орчим хувь нь жилийн 2 дугаар улиралд хийгддэг байна.

Харин 2015 оны хавраас эхэлж тус биржээр хүнсний улаан буудай арилжаалж эхэлсэн байна. Сүүлийн 2 жилд нийт арилжааны 20 гаруй хувийг жилийн 3 дугаар улиралд хийх хандлага ажиглагдаж байна. Ирэх 2, 3 дугаар улиралд ХААБ-ийн арилжаа нэмэгдэх хүлээлттэй байна. Цаашид биржээр арилжаалагдах бараа, түүхий эдийн төрлийг олшруулах шаардлагатай байна.

САНХҮҮГИЙН САЛБАРЫН ДЭД БҮТЭЦ, ТҮҮНИЙ ИНСТИТУЦИ 3

3.1 ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИНД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ

Банк, санхүүгийн салбарын голлох хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах, зарим хуулийг шинэчлэн найруулах, шинээр боловсруулах тухай (i) УИХ-ын 2016 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан "Төрөөс мөнгөний бодлогын талаар 2017 онд баримтлах үндсэн чиглэл"-д, (ii) 2016 оны 71 дүгээр тогтоолоор батлагдсан "Эдийн засгийг сэргээх хөтөлбөр"-ийн 2 дугаар хавсралт болох тэргүүн ээлжинд боловсруулж батлуулж, УИХ-д яаралтай өргөн мэдүүлэх хууль тогтоомжийн жагсаалтад, (iii) 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан "Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл"-д болон Монгол Улсын Засгийн газраас Олон Улсын Валютын Сантай хамтран "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх үндсэн нөхцөлд тус тус тусгагдаад байгаа билээ.

Үүнтэй холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2017 оны А-10 болон 2017 оны А-97 дугаар тушаалаар "Банкны салбарын хууль эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр"-ийг боловсруулсан. Энэ хүрээнд Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийг боловсруулан 2017 оны 5 дугаар сард УИХ-аар батлуулсны зэрэгцээ дараах 9 хуулийн төслүүдийг боловсруулж байна. Үүнд:

- Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт /Монголбанкны бие даасан, хараат бус байдлыг бэхжүүлэх зорилгоор холбогдох хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох/;
- Банкны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт /Банкны салбарын тогтвортой байдлыг хамгаалах, эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх, улмаар макро эдийн засгийн суурийг бэхжүүлэх зорилгоор Банкны хяналт шалгалтын эрх орчныг сайжруулах, олон улсын сайн туршлага, Банкны хяналт шалгалтын олон улсын стандарт, зарчимд нийцүүлэхийн тулд эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох/;
- Актив удирдлагын тухай хууль /санхүүгийн салбарын эрсдэлийг бууруулах арга хэмжээний хүрээнд активын удирдлагын мэргэшсэн институцийн эрх зүйн орчныг бүрдүүлэх/;
- Валютын зохицуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулга /валютын дотоодын захын дэд бүтцийг хөгжүүлж, ил тод, үр ашигтай байдлыг хангасан шинэ тогтолцоо бүрдүүлэх/;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн нэмэлт өөрчлөлт /мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх эрх зүйн зохицуулалтыг олон улсын стандартад нийцүүлэн боловсронгуй болгох/;
- Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт /Банк, санхүүгийн салбарын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэл тохиолдсон үед авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой байлгах, зохицуулагч байгууллагын зүгээс эдгээр арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхэд бэлэн байх хууль тогтоомжийн зохицуулалтыг илүү боловсронгуй болгох зорилгоор одоо мөрдөж байгаа Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн зохицуулалтыг олон улсын стандартад нийцүүлэх/;
- Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл

ажиллагааны тухай хуулийн нэмэлт өөрчлөлт /эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны зохицуулалтыг өнөөгийн нөхцөлд нийцүүлэн боловсронгуй болгох бөгөөд тус харилцаанд оролцогч этгээдийн эрх зүйн байдлыг илүү тодорхой болгох, санхүүгийн салбарт хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор холбогдох зохицуулалтыг боловсронгуй болгох/;

- Эрдэнэсийн сангийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт /Эрдэнэсийн санд шилжүүлэх түүх, соёлын өвд тавигдах шаардлагыг тодорхой болгох, соёлын өвийг хамгаалахтай холбоотой УИХ, Засгийн газар, Монголбанкны үйл ажиллагааг илүү тодорхой болгох, хуулийн хамгаалалтыг сайжруулах, алт тушаалтыг нэмэгдүүлэх зорилгоор үнэт металлын сорьцыг тогтоох эрх бүхий этгээдэд холбогдох зохицуулалтыг боловсронгуй болгох/;
- Векселийн тухай хуулийн шинэчилсэн найруулга /тус хуулиар зохицуулах харилцааг олон улсын жишигт нийцүүлэх, хуулийн хэрэгжилтэд гарч буй хүндрэлийг шийдвэрлэх/.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2017 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн А-10 дугаар тушаалаар 2017-2019 онд хэрэгжүүлэх “Монголбанкны үйл ажиллагааны шинэчлэлийн дунд хугацааны хөтөлбөр”-ийг баталсан. Энэхүү хөтөлбөрт үндсэн 5 чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар зорилт болгон дэвшүүлсэн бөгөөд үүний нэг чиглэл нь “Банкны салбарын хууль эрх зүйн орчинг сайжруулах” тухай юм. Дээрх хууль, эрх зүйн орчныг сайжруулах чиглэлийн хэрэгжилтийг хангах зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгчийн 2017 оны А-97 дугаар тушаалаар “Банкны салбарын хууль эрх зүйн шинэчлэлийн хөтөлбөр”-ийг боловсруулж, хэрэгжүүлэх Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

Үндэсний төлбөрийн системийн тухай хууль:

Үндэсний төлбөрийн системийн ил тод байдлыг дэмжих, систем хоорондын харилцан зохицолдоог хангах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, зах зээлийн өрсөлдөөнт орчинг бий болгох, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, түүнийг олон нийтэд ойртуулах замаар Үндэсний төлбөрийн системийн тогтвортой, тасралтгүй, найдвартай, үр ашигтай байдлыг хангахад чиглэсэн төлбөрийн үйлчилгээний эрх зүйн орчинг бүрдүүлэхээр зорилгоор Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн төслийг УИХ хэлэлцэж, 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр баталлаа.

Үндэсний төлбөрийн системийн тухай хууль үндэсний төлбөрийн системийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нэр томьёог холбогдох олон улсын стандарт, Монгол Улсын бусад хууль тогтоомжид нийцүүлэн тодорхойлсоноос гадна Монголбанкны Үндэсний төлбөрийн системд оролцох эрх зүйн үндсийг тогтоож, төлбөрийн системийн оролцогчдоос мэдээлэл авах, тэдгээрт хяналт тавих зохицуулалтыг тодорхойлон хуульчилсан. Түүнчлэн төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, төлбөрийн хэрэгсэл гаргах, систем ажиллуулах үйл ажиллагааг зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэхээр хуульд тусгасан байна.

Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийг 2018 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхлэх бөгөөд энэхүү хууль нь Монгол Улсын төлбөрийн систем тогтвортой, тасралтгүй, аюулгүй, найдвартай, үр ашигтай ажиллах эрх зүйн орчинг бүрдүүлэх чухал ач холбогдолтойн дээр техник технологийн хөгжлийг даган шинэ төрлийн төлбөрийн хэрэгсэл зах зээлд нэвтрэх, үүнтэй уялдуулан хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зэрэг эрх зүйн олон талт, шинэ харилцааг зохицуулах давхар ач холбогдолтой юм.

3.2 ТӨЛБӨР ТООЦООНЫ СИСТЕМ

Их дүнтэй төлбөр тооцооны систем

Төлбөрийн системийн оролцогч хоорондын их дүнтэй төлбөр тооцоог Монголбанкны Банксүлжээ системээр бодит цагийн горимоор гүйцэтгэж байгаа нь төлбөр тооцооны системийн эрсдэлийг бууруулах, мөнгөн урсгалыг бодит цагаар хянах, мөнгөний бодлогын хэрэгжилтийг сайжруулах, заавал байлгах нөөцийг хангуулах боломжийг бүрдүүлдэг.

Их дүнтэй төлбөр тооцооны системээр банк хоорондын төлбөр тооцоо, Сангийн яамны Төрийн сангийн газрын төлбөр тооцоо, Үнэт цаасны төлбөр тооцоог бодит цагийн горимоор гүйцэтгэж, бага дүнтэй төлбөр тооцооны системээс илгээсэн үр дүнгийн тооцооллыг оролцогч бүрийн харилцах дансанд тусгаж байна.

Сүүлийн дөрвөн жилийн байдлаар төлбөрийн системийн нийт гүйлгээний дүнгийн 94-98 хувь, гүйлгээний тооны 5-18 орчим хувь нь их дүнтэй төлбөр тооцооны системээр дамжиж байгаа нь энэхүү системийг банк, санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн тогтвортой байдалд нэн чухал ач холбогдолтой болохыг харуулж байна.

Дүрслэл 3.1

Их дүнтэй төлбөр тооцооны системийн нэг өдрийн дундаж үзүүлэлт



Эх сурвалж: Монголбанк

2017 оны 1 дүгээр улиралд нэг өдөрт дунджаар 197.1 тэрбум төгрөгийн, 5.8 мянган ширхэг их дүнтэй гүйлгээ хийгджээ.

Бага дүнтэй төлбөр тооцооны систем

Үндэсний цахим гүйлгээний төв нь банк хоорондын бага дүнтэй төлбөр, Сангийн яамны Төрийн сангийн газрын бага дүнтэй төлбөр болон банк хоорондын төлбөрийн картын гүйлгээг бодит цагийн горимоор дамжуулж, үр дүнгийн тооцооллыг Банксүлжээ систем рүү дамжуулж байна.

Сүүлийн 7 жилийн байдлаар бага дүнтэй төлбөр тооцоо нь төлбөрийн системийн нийт гүйлгээний дүнгийн 2-6 орчим хувийг, харин гүйлгээний тооны 82-95 хувийг тус тус эзэлж байна.

Дүрслэл 3.2

Бага дүнтэй төлбөр тооцооны системийн нэг өдрийн дундаж үзүүлэлт



Эх сурвалж: Монголбанк

Үндэсний төлбөрийн систем

Монголбанк нь Монгол Улсын Үндэсний төлбөрийн системийг удирдан зохион байгуулах, хяналт тавих, системийн үр ашигтай, найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээ бэлэн бус төлбөр тооцоог дэмжих бодлого баримтлан ажиллаж байна.

Дүрслэл 3.3

Картын гүйлгээний нэг өдрийн дундаж үзүүлэлт



Эх сурвалж: Монголбанк

Монгол Улсын төлбөрийн системийн хууль, эрх зүйн орчныг сайжруулах, хяналтын чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Дэлхийн банкнаас үзүүлж буй техник туслалцааны үр дүнд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2016 оны 8 дугаар сарын 08-ны өдрийн хурлаар "Монгол Улсын Үндэсний төлбөрийн системийг 2015-2020 онд хөгжүүлэх стратеги" баримт бичгийг Монголбанкнаас боловсруулж хэлэлцүүлэн батлсан.

Стратегийн баримт бичгийг олон улсын хандлага, сайн туршлагыг үндэслэн боловсруулсан ба авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хууль, эрх зүйн тогтолцоо, их дүнтэй бөгөөд хугацааны хувьд чухал төлбөр тооцооны зохицуулалт, жижиглэнгийн төлбөр тооцооны систем, олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, Засгийн газрын төлбөр, үнэт цаасны төлбөр тооцооны зохицуулалт, валютын арилжаа, банк хоорондын зах, төлбөрийн системийн хяналт, хамтын ажиллагаа гэсэн 9 тулгуур чиглэлээр тодорхойлон авч үзсэн болно.

Түүнчлэн энэхүү стратегийн богино хугацаанд хэрэгжүүлэх зорилтод тодорхойлсны дагуу төлбөрийн систем, төлбөрийн хэрэгсэл, төлбөрийн үйлчилгээтэй холбоотой бүхий л харилцаа, асуудлыг цогц байдлаар бүхэлд нь зохицуулж, хяналт тавих Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн А-238 дугаар тушаалаар шинэчлэн байгуулагдан боловсруулсан. Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж, 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бөгөөд Улсын Их Хурлын 2017 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар "Үндэсний төлбөрийн системийн тухай" хуулийг баталсан болно.

Энэхүү хуулиар үндэсний мөнгөн тэмдэгтийг орлон Монгол Улсад төлбөр тооцоонд хэрэглэгдэх цахим мөнгө, төлбөрийн карт зэрэг төлбөрийн хэрэгсэл, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой бүхий л үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг Монголбанкнаас олгох асуудлыг тодорхой болгосны дагуу төлбөрийн системд оролцох оператор, оролцогч, хэрэглэгчдийн оролцоог тодорхойлж, үйл ажиллагааны цар хүрээг өргөтгөн зохицуулж өгснөөр төлбөрийн систем, төлбөрийн үйлчилгээ болон төлбөрийн хэрэгслийн цаашдын хөгжлийг дэмжих боломж бүрдэж байгаа билээ. Монголбанкнаас Монгол Улсын төлбөрийн системд шинээр нэвтэрч төлбөрийн хэрэгслийг зохицуулж, хянах болсны үр дүнд тавигдах шаардлага, систем хоорондын харилцан зохицолдоо, нууцлал, аюулгүй байдал болон харилцагчийн эрх ашгийг хамгаалах асуудлууд бүрэн хангагдах нөхцөл бүрдсэн байна.

Тайлант хугацаанд их дүнтэй төлбөр тооцооны “Банксүлжээ” систем, бага дүнтэй төлбөр тооцооны систем, картын нэгдсэн сүлжээ болон үнэт цаасны төлбөр тооцооны найдвартай, тасралтгүй ажиллагааг ханган ажилласан.

Төлбөрийн системийн хяналт

Монголбанкнаас төлбөрийн системд учирч болзошгүй эрсдэлийг удирдах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалж, системийн аюулгүй байдлыг хангуулан, луйврын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, оролцогчдын төлбөрийн систем дэх эрх тэгш оролцоог хангаж, төлбөрийн үйлчилгээний өрсөлдөөнт зах зээлийн нөхцөлийг бүрдүүлэх, төлбөр тооцооны систем хоорондын харилцан зохицолдоо, нэгдмэл байдлыг хангах чиглэл баримтлан, төлбөрийн системд хяналт тавин ажиллаж байна.

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн дагуу үндэсний мөнгөн тэмдэгтийг орлон төлбөр тооцоонд хэрэглэгдэх төлбөрийн карт зэрэг бусад төлбөрийн хэрэгслийн зөвшөөрлийг олгон, түүнд хяналт тавьж, дүгнэлт гарган, шалгалт хийж байна. Тайлант хугацаанд хоёр банкинд төлбөрийн картын нэмэлт зөвшөөрөл олгон, нэг банкны төлбөрийн картын үйл ажиллагааны зөвшөөрлийг сунган, нэг банкны шинээр нэвтрүүлж буй процессорын үйл ажиллагаанд дүгнэлт гарган ажилласан байна.

Төлбөрийн системийн оролцогч 7 банкны их болон бага дүнтэй төлбөр тооцоо, картын төлбөр тооцоо, хөдөлгөөнт банкны үйлчилгээтэй холбоотой үйл ажиллагаа, мэдээллийн технологийн тасралтгүй найдвартай ажиллагаанд иж бүрэн шалгалт хийж гүйцэтгэлээ.

Олон улсын төлбөр тооцооны банкны Төлбөр тооцооны системийн хороо болон Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагын теникийн зөвлөлөөс гаргасан "Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн зарчмууд"-ын хэрэгжилтийг үнэлэх зорилгоор Төв банкны үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаатай холбоотой үнэлгээг хийж гүйцэтгэлээ. Үүний үр дүнд системийн үйл ажиллагаа олон улсын стандартад нийцэж буй эсэхийг тодорхойлох боломжтой болох юм.

Түүнчлэн олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээний нөхцөл байдалд үнэлгээ хийх, олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор Дэлхийн банкнаас гаргасан “Мөнгөн гуйвуулгын ерөнхий зарчмууд”-д суурилсан холбогдох баримт бичгийг боловсруулан байгаа билээ.

Төлбөрийн системийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангуулах зорилгын хүрээнд их дүнтэй төлбөр тооцооны “Банксүлжээ” систем, Свифт сүлжээний тасралтгүй ажиллагааны тайланг 14 хоног, төлбөрийн картын нэгдсэн сүлжээ, бага дүнтэй төлбөр тооцооны системийн тасралтгүй ажиллагааны тайланг 7 хоног, Худалдаа хөгжлийн банкны төлбөрийн картын свитчийн тасралтгүй ажиллагааны тайланг 7 хоног тутам гаргуулан авч, хяналт тавьж байна. Ингэхдээ “Банксүлжээ” систем, Свифт сүлжээ, төлбөрийн картын нэгдсэн сүлжээ, Худалдаа хөгжлийн банкны картын свитчийн тасралтгүй ажиллагааны тайланг сар бүрээр нэгтгэн , хяналт тавин, зохих арга хэмжээг цаг тухайд нь авч ажилласан болно.

3.3 САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төвбанкны тухай хууль болон Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (Зөвлөл)-ийн ажиллах дүрэмд заасны дагуу Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь түүний ээлжит болон ээлжит бус хуралдаан юм. Ээлжит хуралдааныг улирал бүр урьдчилан тогтсон товын дагуу хуралдуулдаг бол ээлжит бус хуралдааны хувьд цаг үеийн шинжтэй асуудлыг хэлэлцэх зорилгоор, аль нэг талын санаачлагаар тухай бүр зохион байгуулдаг болно. Санхүүгийн тогтвортой байдлын тайлангийн өмнөх дугаар хэвлэгдэж олон нийтийн хүртээл болсноос хойшхи хугацаанд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл нь 2017 оны 1 дүгээр сарын 24-ний, 2 дугаар сарын 23-ны өдрүүдэд ээлжит бус, 6 дугаар сарын 12-ны өдөр улирал тутмын ээлжит хуралдаанаа зохион байгууллаа.

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2017 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаар: (i) Активын удирдлагын компани байгуулах болон холбогдох хуулийн төслийн үзэл баримтлалын тухай, (ii) “Монгол Улсын Санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн концепц, (iii) Валютын бирж байгуулах тухай зэрэг асуудлыг авч хэлэлцсэн. Харин 2017 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үнэлгээг хэлэлцэж, өнөөгийн нөхцөл байдал, цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцэв. 2017 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар: (i) Эдийн засгийг сэргээх хөтөлбөрт тусгагдсан банк санхүүгийн салбарын зорилт арга хэмжээний хэрэгжилтийн тухай (ii) Санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөрийн төсөл (iii) Төв банкны тухай хуулийн 272 дах хэсгийн нэмэлт өөрчлөлтийн төсөл (iv) Валютын зохицуулалтын тухай хуулийн төсөл-ийг хэлэлцэж холбогдох шийдвэрийг гаргаад байна. Хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу Зөвлөлийн гишүүд хариуцсан чиглэлээр холбогдох газруудад тодорхой үүрэг даалгавар өгч ажиллаж байна.

Үүнээс гадна СТБЗ-ийн Ажлын алба нь 2017 оны эхний улиралд Монгол Улсын санхүүгийн системд учирч болзошгүй томоохон эрсдэлүүдийг үнэлэх, болзошгүй эрсдэлийг бууруулах макро зохистой бодлогын санал, зөвлөмж боловсруулах зорилгоор “Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын зураглал болон халалтын зураглал”-ийг талаар судалгааны ажлыг хийж гүйцэтгэв.

Санхүүгийн системийн эрсдэлийн үнэлгээ хийх, макро бодлогуудын харилцан уялдааг хангах, макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд санал боловсруулах, Монгол Улсын Санхүүгийн тогтвортой байдлын тайланг хагас жил тутам бэлтгэн, олон нийтэд хүргэх үүрэгтэй, байнгын үйл ажиллагаатай нэгж бий болгохоор шийдвэрлэсний дагуу Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн Ажлын алба (СТБЗАА)-ыг Монголбанкинд төвлөрүүлэн ажиллуулж байна.

СТБЗАА нь Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох газруудтай хамтран ажиллаж, тайлан мэдээллийг хүлээн авч, “Монгол Улсын Санхүүгийн тогтвортой байдлын тайлан”-гийн найман дугаарыг нэгтгэн боловсруулж, хэвлүүлэн, Монголбанкны цахим хуудаст байршуулж, олон нийтийн хүртээл болгосон бөгөөд ийнхүү ес дэх дугаарыг та бүхэнд хүргэж байна.

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ